СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# Үнэт цаасны танилцуулга

СЗХ-ны "Бүртгэлийн журам", МХБ-ийн бүртгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу СЗХ-ны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 267 тоот тогтоолоор бүртгэгдсэн

**6,000,000 ширхэг**

## "БиДиСЕК" Хувьцаат Компанийн энгийн хувьцаа

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын "Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмуудын дагуу нэмэлт 6,000,000 ширхэг энгийн хувьцааг зах зээл дээр гарган хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,700,000,000 төгрөгт хүргэж, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлж байгаа болно.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажиллагаа нь Монголын хөрөнгийн биржээр нээлттэй явагдах хэдий ч ХЭХ-ийн 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчдэд "Компанийн тухай" хуулийн 38-д заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлнэ. Харин хэрэгжээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгох замаар арилжаална. Монголын Хөрөнгийн Бирж дээрх бүртгэлтэй код нь "BDS:522" болно.

Үнэт цаасны эрсдэлийн талаар энэхүү "Үнэт цаасны танилцуулга"-ын 80-97 дугаар хуудсанд дэлгэрэнгүй тусгасан.

| | |
|---|---|
| Тэргүүн ээлжинд санал болгох үнэ: | 1,931 төгрөг |
| Олон нийтэд санал болгох үнэ: | Зах зээлийн үнийг үндэслэн ТУЗ-өөс тогтооно |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгө:** | |
| Тэргүүн ээлжинд санал болгох үнээр тооцоход: | 11,586,000,000 төгрөг |
| Зах зээлийн үнээр тооцоход: | 12,876,000,000 төгрөг |

| Аудит: | Хөрөнгийн үнэлгээ: | Хуулийн дүгнэлт: |
|---|---|---|
| **BDO аудит** | **Далайван аудит** | **Ананд адвокатс ХХН** |

Энэхүү үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн Зохицуулах Хороо 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталгаажуулсан болно.

2014 07 04

18

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Зураг 1. Үнэт цаас гаргагчийн төв байр






2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

19

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД:

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын "Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмуудын дагуу нэмэлт хувьцаа гарган эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлж байгаа болно.

ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ***ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ*** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэх журмыг тогтоосон болно.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд хувьцаа худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг Үнэт цаас гаргагч "БиДиСЕК" ХК-д хандаж авна уу.

Энэхүү Танилцуулгыг цаасан хэлбэрээр хэвлэж гаргах бөгөөд Цахим танилцуулгыг зөвхөн "БиДиСЕК" ХК-ийн албан ёсны вэб сайт болон Монголын Хөрөнгийн Биржийн вэб сайт дээр тус тус байрлуулах болно.

Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлдэхдээ "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 28 дугаар зүйлд заасан мэргэжлийн компанийн хариуцлага, ёс зүйн журмыг баримтлан аудитын компанид шалгуулсан санхүүгийн тайлангийн мэдээллийг алдаа, зөрүүгүйгээр авч ашигласан болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг:
Утас: 976-11-313108, 976-11-312030, Факс: 976-11-313108,
Имэйл: info@bdsec.mn, Цахим хаяг: www.bdsec.mn

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

20

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

**Андеррайтер**
"БиДиСЕК" ХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1,
Утас/Факс: 976-11-313108, 976-11-323411
И-мэйл хаяг: info@bdsec.mn, Цахим хуудас: www.bdsec.mn

**Аудит**
"БДОМонголиа" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг-14193, 6-р хороо,
11-р хороолол, Их сургуулийн гудамж 32/1
АБ центр, 10 давхар
Утас: 976-77404040, Факс: 976-77451150
Email: bdoaudit@bdo.mn, Цахим хуудас: www.bdo.mn

**Хуулийн зөвлөх**
"Ананд адвокатс" Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөл
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Метро бизнес төв, 10-р давхар
Утас: 976-11-329442, Факс: 976-70119442
И-мэйл: info@anand-advocates.mn, Цахим хуудас: www.anand-advocates.mn

**Хөрөнгийн үнэлгээ**
"Далайван аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, Амарсанаа 5,
Утас: +976-11-305401, +976-11-305402,
Факс: +976-11-3050403
И мэйл: info@dalaivanaudit.mn, Цахим хуудас: www.dalaivanaudit.mn
Baker Tilly International компанийн бүрэн эрхт гишүүн



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАТАЛГАА

**Баталгаа**
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.11-д заасныг үндэслэн:

**Үнэт цаасны танилцуулга:**
Бид "БиДиСек" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах үнэт цаасны танилцуулга, түүний хуулбар түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв болохыг баталж байна.

1. Овог, нэр: **Бүрэнмэнд Лхагвадорж**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"БиДиСЕК" ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг: ..............................

(тамга/тэмдэг)

2. Овог, нэр: **Данзан Даянбилгүүн**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"БиДиСЕК" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ..............................

(тамга/тэмдэг)

3. Овог, нэр: **М. Цагаанцэцэг**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"БиДиСЕК" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг: ..............................

(тамга/тэмдэг)

"БИДИСЕК" ХК
САНХҮҮ
ТТА4487 - 2052482
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Аудитын дүгнэлт:**

"БиДиСек" ХК-ийн бэлтгэсэн нэмэлт хувьцаа гаргах "Үнэт цаасны танилцуулга"-д "БДО Аудит" XXK-ийн аудит хийгдсэн санхүүгийн тайланг хавсарган, ашигласан болохыг баталж байна.

4. Овог, нэр: **Г. Баянмөнх**

Албан тушаал: Аудит "БДО АУДИТ" XXK-ийн Ерөнхий захирал

Гарын үсэг: ..................................

(тамга/тэмдэг)

**Хуулийн дүгнэлт:**

"БиДиСек" ХК-ийн бэлтгэсэн нэмэлт хувьцаа гаргах "Үнэт цаасны танилцуулга"-д "Ананд адвокатс" XXH-ийн гүйцэтгэсэн хуулийн дүгнэлт, тайланг хавсарган, ашигласан болохыг баталж байна.

5. Овог, нэр: **Н.Энхцэцэг**

Албан тушаал: Хуулийн зөвлөх "Ананд адвокатс" XXH-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ..................................

(тамга/тэмдэг)

**Хөрөнгийн үнэлгээний дүгнэлт:**

"БиДиСек" ХК-ийн бэлтгэсэн нэмэлт хувьцаа гаргах "Үнэт цаасны танилцуулга"-д "Далайван аудит" XXK-ийн гүйцэтгэсэн хөрөнгийн дахин үнэлгээний тайланг хавсарган, ашигласан болохыг баталж байна.

6. Овог, нэр: **Ц.Жигдэн**

Албан тушаал: "Далайван Аудит" XXK-ийн Ерөнхий захирал

Гарын үсэг: ..................................

(тамга/тэмдэг)



2014 07 07

23

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

# ГАРЧИГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД: ....... 3
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА ....... 4
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАТАЛГАА ....... 5
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ....... 12
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР ....... 13
ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ ....... 14
КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ....... 15
- Хувьцаа эзэмшигчдийн хурал ....... 22
- Төлөөлөн удирдах зөвлөл ....... 22
- ТУЗ-ийн дэргэдэх дэд хороод: ....... 25
- Гүйцэтгэх удирдлага ....... 25
- Үнэт цаас гаргагчийн охин компани “БИ ДИ СИ ЭЙ ПИ” ХХК-ийн товч танилцуулга ....... 27

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ....... 29
- Брокерийн үйл ажиллагаа ....... 29
- Андеррайтерийн үйл ажиллагааны үзүүлэлт ....... 35
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа ....... 36

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ ....... 38
- Санхүүгийн шинжилгээ ....... 41
- Монголын эдийн засгийн байдал ....... 44
- Эдийн засгийн үзүүлэлтүүд ....... 45

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ....... 49
- Хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт, шинэчлэл ....... 49
- БиДиСЕК ХК-ийн андеррайтерийн үйл ажиллагаа хөрөнгийн зах зээлд нөлөөлөх нөлөөлөл ....... 50
- Өрсөлдөгчийн судалгаа ....... 52
- Зах зээл дээр гарсан үнэт цаасны мэдээлэл ....... 53

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗАМААР САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА ....... 56
- Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ....... 56
- Монголын аж ахуй нэгжүүдийн мэдээлэл: ....... 72
- Орлогын төсөөлөл ....... 77
- Андеррайтерийн үйл ажиллагааны орлого ....... 77
- Брокерын үйл ажиллагааны орлого ....... 78
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлого ....... 78
- Нэгтгэсэн орлогын тайлан ....... 79



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА........................................................80
Эрсдэлийн хүчин зүйлс ..........................................................................................80
Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө .......................................................................91
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ..........................................................................................98
Мэдээллийн ил тод, нээлттэй байдал ......................................................................98
Компанийн үйл ажиллагааны дотоод хяналт ...........................................................98
Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа .............................99
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал ..............................................................100
НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО ....................................................................................101
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ..................................................................................101
ҮНЭТ ЦААСЫГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ......................................104
ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ ............................................107
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ..................................................................................109
Үнэт цаас гаргах шийдвэрийн тухай ......................................................................110
Нэмж гаргаж буй үнэт цаасны ширхэг ...................................................................110
Үнэт цаасыг санал болгох үнэ ...............................................................................110
Анхдагч зах зээлд байршуулах цаг хугацааны үечлэл .............................................110
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР БАЙРШУУЛАХ ХУГАЦАА.....................................................111
ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ..................................................................................................112
ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОН ЭТГЭЭД, ТЭДГЭЭРТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ .... 115
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ.....................................................................117
АУДИТЫН ДҮГНЭЛТ..................................................................................................119
ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ................................................................................................159
Үнэт цаас гаргагчтай холбоо барих .........................................................................177

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа (2014.03.03) ..........................17
Хүснэгт 2. Хувьцааны арилжааны судалгаа (2014.03.03) ..........................................17
Хүснэгт 3. 5%-аас дээш хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл (2014.03.03 өдрийн байдлаар) ........................................................................................................................18
Хүснэгт 4. Хувьцаа эзэмшигчид улсаар, цагаан толгойн үсгийн дараалаар ..................19
Хүснэгт 5. ТУЗ-ийн гишүүд ......................................................................................22
Хүснэгт 6. ТУЗ-ийн дэргэдэх хороод.........................................................................25

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Хүснэгт 7. Компанийн эрх бүхий албан тушаалтаны мэдээлэл (2014.03.03) ................ 26
Хүснэгт 8. Баланс ........................................................................................ 38
Хүснэгт 9. Орлогын тайлан ............................................................................ 39
Хүснэгт 10. Мөнгөн гүйлгээний тайлан ............................................................ 39
Хүснэгт 11. 2011-2013 оны балансад хийсэн бүтцийн шинжилгээний үр дүн ............. 41
Хүснэгт 12. 2011-2013 оны орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээний үр дүн ... 42
Хүснэгт 13. 2011-2013 оны санхүүгийн тайланд хийсэн харьцааны шинжилгээ .......... 43
Хүснэгт 14. Бодит ДНБ, салбараар (тэрбум төгрөг) ............................................ 44
Хүснэгт 15. Андеррайтерийн эрхтэй компаниудын мэдээлэл ................................. 52
Хүснэгт 16. Хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгө ............................ 53
Хүснэгт 17. Хувьцаагаар татсан хөрөнгө ........................................................... 53
Хүснэгт 18. IPO хийсэн компаниуд .................................................................. 54
Хүснэгт 19. FPO гаргасан компаниуд ................................................................ 54
Хүснэгт 20. Бонд гаргасан компаниуд .............................................................. 55
Хүснэгт 21. Нэмэлт хувьцаа гарган татах хөрөнгө ............................................. 56
Хүснэгт 22. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт (төгрөгөөр) ........................ 57
Хүснэгт 23. Бүртгэлтэй хувьцаат компани, салбараар ......................................... 59
Хүснэгт 24. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн (мянган ам.доллар) .............. 62
Хүснэгт 25. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, тэрбум төг. ..................... 63
Хүснэгт 26. ББСБ-ын харьцуулсан үзүүлэлт, мянган төгрөгөөр ............................. 67
Хүснэгт 27. ББСБ-ын салбарын орлогын бүтэц .................................................. 67
Хүснэгт 28. ББСБ-ын салбарын ашигт ажиллагаа, мянган төгрөгөөр ....................... 68
Хүснэгт 29. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн ........ 69
Хүснэгт 30. Боловсруулах аж үйлдвэрлэлийн борлуулсан бүтээгдэхүүн, дэд салбараар, оны үнээр, сая төг. ............................................................................................ 69
Хүснэгт 31 Хөнгөн аж үйлдвэрийг 2013-2016 онд хөгжүүлэх зорилт, хүрэх үр дүн ..... 70
Хүснэгт 32. Орлогын түвшингээр ангилсан ААН-үүдийн тоо (төгрөг) ...................... 74
Хүснэгт 33. Андеррайтерийн үйл ажиллагааны төлөвлөгөө .................................. 77
Хүснэгт 34. Андеррайтерийн үйл ажиллагааны орлогын төсөөлөл .......................... 77
Хүснэгт 35. МХБ-ийн сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны хэмжээ ................... 78
Хүснэгт 36. Брокерийн үйл ажиллагааны орлогын төсөөлөл .................................. 78
Хүснэгт 37. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлогын төсөөлөл ..................... 79
Хүснэгт 38. Орлогын нэгтгэсэн төсөөлөл ........................................................... 79
Хүснэгт 39. 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид ............................................ 88
Хүснэгт 40. Зохистой харьцааны шалгуур, 2013.12.31-ний өдрийн байдлаар ............. 89
Хүснэгт 41. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө ................................................... 91
Хүснэгт 42. Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг тараалтын судалгаа ....................... 101
Хүснэгт 43. Нэмж гаргаж буй үнэт цаасны мэдээлэл ........................................... 109
Хүснэгт 44. Нэмж гаргаж буй хувьцааг зах зээлд байршуулах төлөвлөгөө ............... 111

## ГРАФИК

График 1. "БиДиСЕК" ХК-ийн хувьцааны сүүлийн 3 жилийн арилжааны мэдээлэл ...... 18
График 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2014.03.03 өдрийн байдлаар) ..................... 19
График 3. Үнэт цаасны арилжааны мэдээлэл ....................................................... 32

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 02

График 4. Хувьцааны арилжаанд эзлэх хувь ..... 32
График 5. 2010-2011 оны Засгийн газрын бондын арилжааны мэдээлэл ..... 33
График 6. Харилцагчдын бүтэц ..... 34
График 7. Андеррайтерийн үйл ажиллагааны үзүүлэлт ..... 36
График 8. ДНБ-ий бодит өсөлт, салбараар ..... 45
График 9. Төсвийн нийт орлого, тусламж ..... 45
График 10. Хөрөнгө оруулалт, салбараар ..... 46
График 11. Валютын ханшийн хэлбэлзэл, гадаад валютын нөөц ..... 46
График 12. Инфляцийн түвшин ..... 47
График 13. Өрхийн орлого, ажиллагсадын тоо ..... 47
График 14. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, сая ам.доллар ..... 48
График 15. Монгол Улсын ДНБ-ийн өсөлтийн таамаг, хувиар ..... 48
График 16. Хувьцааны арилжааны хэмжээ, тоо/ширхэг ..... 50
График 17. Зах зээлийн нийт үнэлгээ ..... 51
График 18. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ..... 57
График 19. Бүртгэлтэй хувьцаат компаниуд, салбараар ..... 60
График 20. Уул уурхайн салбарын Монгол улсын эдийн засагт эзлэх хувь ..... 61
График 21. Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн, сая ам.доллар ..... 61
График 22. Ашиглалтанд орсон орон сууцны тоо, орон сууцны фонд ..... 63
График 23. Нийслэлийн орон сууцны хангамж ..... 64
График 24. ДНБ болон санхүүгийн салбарын ДНБ-ий өсөлт, жилээр ..... 65
График 25. Санхүүгийн салбарын хувь хэмжээ, 2013.06.30-ны өдрийн байдлаар ..... 66
График 26. Банк бус санхүүгийн байгууллагын тоо, жилээр ..... 67
График 27: ББСБ-ийн дундаж зээлийн хүүгийн хэмжээ /сарын/ ..... 68
График 28. Аж үйлдвэрийн салбарын хувь, хэмжээ ..... 69
График 29. Аж ахуйн нэгж(ААН)-үүдийн ангилал ..... 73
График 30. Бүртгэлтэй ААН-ийн тоо, тэдгээрийн борлуулалтын орлогын дүн ..... 74
График 31. Үнэт цаасны арилжааны дүн ..... 80
График 32. Инфляцийн түвшин, хувиар ..... 81

## СХЕМ

Схем 1. Компанийн зорилго, зорилт ..... 15
Схем 2. Компанийн бүтэц, зохион байгуулалт ..... 21

## ЗУРАГ

Зураг 1. Үнэт цаас гаргагчийн төв байр ..... 2
Зураг 2. Үнэт цаас гаргагчийн салбаруудын байршил ..... 35
Зураг 3. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэв ..... 37



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| Нэр, томьёо | Тайлбар |
|---|---|
| Андеррайтер | Хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт босгох зуучлалын үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээ |
| МХБ | "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ҮЦТТТХТ | "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК |
| ХК | Хувьцаат компани |
| ХОЗҮ | Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| BDS:522 | Монголын Хөрөнгийн Бирж дээрх үнэт цаас гаргагчийн үсгэн болон тоон код |
| FPO | Үнэт цаасаа дахин олон нийтэд санал болгох |
| IPO | Үнэт цаасаа анх удаа олон нийтэд санал болгох |



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

28

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

## "БиДиСЕК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 04 сарын 18–ны өдөр    Дугаар 03    Улаанбаатар хот

***Компанийн нэмж гаргах хувьцааны тоог шинэчлэн тогтоох тухай***

"БиДиСЕК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 4 дүгээр сарын 18 - ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шаардлагатай санхүүжилтийг 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн ХЭХ-ийн 1 тоот тогтоолоор нийт хувьцааны 45% буюу 9,000,000 ширхэг хувьцааг нэмж гарган санхүүжүүлэх байсныг нийт хувьцааны 35.29% буюу 6,000,000 ширхэг хувьцаа болгон өөрчилсүгэй.
2. Нэмж гаргах хувьцаатай холбоотой ажлыг зохион байгуулах, нэмэлт хувьцааны үнийг тогтоох, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг бүхий л эрх мэдлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Нэмж гаргаж буй хувьцааг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлж, хэрэгжүүлэх журмыг боловсруулан батлахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй
4. Тэргүүн ээлжинд худалдан авах журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.
5. Нэмэлт хувьцааны Үнэт цаасны бүрдүүлбэрийг бэлтгэж Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д бүртгүүлэн, олон нийтэд санал болгон ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Даянбилгүүн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:    /Н.БАТГЭРЭЛ/



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





# “БиДиСЕК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 15 – ны өдөр № 06 Улаанбаатар хот

***Компанийн нэмж гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлд нийлүүлэх үнэ, хугацааг тогтоох тухай***

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын №03 тоот тогтоолыг үндэслэн “БиДиСЕК” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлд нийлүүлэх үнэ, хугацааг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх СЗХ-ны тогтоол гарснаас хойш ажлын 30 хоногийн хугацаанд 6,000,000 ширхэг хувьцааг бүхэлд нь хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгосугай.
2. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр нь хувьцаа нэмж гаргах шийдвэр гарсан хурлын бүртгэлийн өдөр болох 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөр тогтоосугай.
3. Нэмэлт хувьцааны зах зээлийн үнийг ажлын хэсгээс санал оруулсаны дагуу 2,146 төгрөгөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгохдоо олон нийтэд санал болгож буй үнээс 10 хувиар хямдруулсан үнэ буюу 1,931 төгрөгөөр санал болгосугай.
5. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд санал болгон хувьцаа эзэмшигчдэд олгосон эрхийг хэрэгжүүлэсний дараа хэрэгжээгүй үлдэх хувьцааг СЗХ-ны шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор олон нийтэд санал болгон арилжаалсугай.
6. Хэрэгжээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгохдоо нэмэлт хувьцааны үнийг тэргүүн ээлжинд санал болгосон үнээс багагүй байхаар ТУЗ-с тухайн үеийн нөхцөлийг харгалзан дахин тогтоосугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал (Д.Даянбилгүүн)-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:** **/Б.ЛХАГВАДОРЖ/**



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм хөрөнгө оруулагчдад,

Миний бие Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудын өмнөөс нийт хувьцаа эзэмшигчид болон манай компанийн хувьцааг худалдан авахаар сонирхож буй хөрөнгө оруулагчиддаа талархал илэрхийлэхийн зэрэгцээ компанийхаа нэмж гаргаж буй хувьцааг санал болгож байгаадаа баяртай байна.

"БиДиСЕК" ХК (**MSE:BDS**) нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгодог тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд сүүлийн 8 жилийн хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж дээрх нийт үнэт цаасны арилжааны үнийн дүнгийн 26-91 хувийг дангаар гүйцэтгэсээр ирлээ. Мөн андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд хөрөнгийн зах зээл дээрээс татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 60 орчим хувийг гүйцэтгэж, санхүүжилт татсан компаниудын засаглалыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг тогтмол хүргэн ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд бид Үндэсний үйлдвэрүүдийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжин ажиллаж, шинэ санаачлага бүхий Үндэсний компаниудыг хөрөнгийн зах зээлд оруулах замаар өндөр чадамжтай үнэт цаасны бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн бодлого үйл ажиллагааг явуулж ирсэн. Цаашид бид энэхүү үйл ажиллагааг улам өргөжүүлэх, иргэд, аж ахуй нэгжүүдэд илүү чанартай үйлчилгээг хүргэх салбар нэгжийн үйл ажиллагааг тогтворжуулах, сайжруулах зэрэг зах зээлийн хөгжилд чиглэсэн тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх зорилгоор компани нийт хувьцааны 35.29%-тай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахаар Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар тус тус шийдвэрлээд байна. Энэхүү нэмж гаргаж буй хувьцааг Монгол Улсын "Компанийн тухай" хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн худалдан авах эрхийг эдлүүлж байгаа билээ.

Нэмж гаргаж буй хувьцааны санхүүжилт нь орж ирснээр компанийн хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагааг улам өргөтгөн компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

**Б.ЛХАГВАДОРЖ**

**ТУЗ-ИЙН ДАРГА**



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

31

## КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

БиДиСЕК компани нь Монгол Улсад 1991 оны өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн өмчийн харилцаа бий болсон цагаас эхлэн өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн, 23 жилийн арвин туршлагатай компани билээ.

Бид 2006 онд компанийн хэлбэрийг олон нийтэд нээлттэй Хувьцаат Компани болгон өөрчлөн Монголын хөрөнгийн биржийн арилжаагаар нийт 10,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд арилжаалсан байдаг. Мөн 2008 онд компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 1,000,000 ширхэг энгийн хувьцааг зах зээл дээр нэмж гаргаснаар нийт 11,000,000 ширхэг хувьцаатай болсон.

БиДиСЕК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгодог Андеррайтер, Брокер Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2007 онд авснаар Монгол улсад анхны үнэт цаасны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгч үнэт цаасны компани болсон.

Схем 1. Компанийн зорилго, зорилт

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**
"Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартад нийцсэн, санхүүгийн зах зээлд тэргүүлэгч компани болох."

**КОМПАНИЙН ЗОРИЛТ**

**УРТ ХУГАЦААНД:**
"Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох"

**ДУНД ХУГАЦААНД:**
"Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх"

**БОГИНО ХУГАЦААНД:**
"Гадаад харилцааг өргөжүүлэх, Үнэт цаасны арилжааг идэвхижүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, Харилцагчдыг хөрөнгийн зах зээлийн мэдээгээр найдвартай хангах"

Өнгөрсөн хугацаанд компанийн удирдлага, менежментийн стратегийн хүрээнд үйл ажиллагаа тогтмол өргөжин тэлж байгаа ба дээрх хугацаанд бид Монголын хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан. Энэ бүхнийг манай компанийн үйлчилж буй харилцагчдын тоо, үнэт цаасны арилжааны хэмжээ, гаргасан үнэт цаасны тоо,



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн, санхүүгийн чадвар, тогтвортой үйл ажиллагаа, харилцагчиддаа үзүүлдэг үйлчилгээний төрөл зэрэг олон үзүүлэлтүүд илтгэдэг.

Манай компанийн үндсэн үйл ажиллагааны нэг болох брокерийн үйлчилгээг ард иргэд, хөрөнгө оруулагчдад ойртуулах, тэдгээрийг үнэт цаасны зах зээлийн арилжаанд саадгүй оролцох нөхцлийг бүрдүүлэх, зах зээлийн шинэ соргог мэдээллийг цаг алдалгүй хүргэх, ард иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх үүднээс Монгол улсын томоохон хот суурин газруудад салбар нэгжээ байгуулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Одоогийн байдлаар бид Улаанбаатар хот болон 8 аймагт 8 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба дотоод, гадаадын нийт 170 гаруй мянган харилцагчдад үйлчилдэг Монгол улсын хамгийн өргөн брокерийн сүлжээг бий болгоод байна.

Бид 2007-2013 ондуудад МХБ-ийн үнэт цаасны нийт гүйлгээний 26-91%-ийг дангаараа гүйцэтгэсэн ба 2012 онд хамгийн өндөр буюу үнэт цаасны гүйлгээний 91%-ийг хийж гүйцэтгэсэн байна.

Мөн Монголын хөрөнгийн биржид шинээр болон нэмэлтээр хувьцаа гарган татан төвлөрүүлсэн санхүүжилтийн 65%-д, нээлттэй компанийн бондын 36%-д нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Манай компани хувьцаат компанийн хувьд компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, ил тод нээлттэй тайлагналын тогтолцоог нэвтрүүлэх, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааны талаарх тайлан мэдээллийг тогтмол хүргэж ажилладаг. Манай компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржийн А самбарт бүртгэлтэйгээр нээлттэй арилжаалагддаг ба зах зээлийн үнэлгээ өндөр 20 компаниудын тоонд тогтмол багтаж ирсэн.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Урьд гаргасан үнэт цаасны тухай мэдээлэл:**

"БиДиСЕК" ХК (Үнэт цаас гаргагч) нь анх 2006 онд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000,000 (арван сая) ширхэг хувьцаа гарган үүний 75%-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгож арилжаалах замаар нээлттэй хувьцаат компани болсон. Дараа нь 2008 оны 8 дугаар сард нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000 (нэг сая) ширхэг хувьцааг нэмж гарган, хувьцаа эзэмшигчдэд өмнө нь эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх боломжийг олгож, нэмэлт хөрөнгө оруулалт татан төвлөрүүлснээр нийт 11,000,000 (арван нэгэн сая) ширхэг хувьцаатай болсон.

Компанийн хувьцаа нь BDS/522 кодтойгоор Монголын хөрөнгийн биржийн А самбарт арилжаалагддаг бөгөөд арилжааны идэвх, үнийн дүнгээрээ тэргүүлэгч үнэт цаасны тоонд багтдаг. Мөн МХБ-ийн хувьцааны арилжааг тодорхойлдог ТОР 20 индекст зах зээлийн үнэлгээ өндөр 20 компанийн тоонд тогтмол багтаж ирсэн.

Дараах хүснэгтэд 2014 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн байдлаарх компанийн томоохон (5%-аас дээш хувь эзэмшигч) болон жижиг хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа (2014.03.03)

| Үзүүлэлт | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 5-с дээш хувийн хувьцаа эзэмшигч | 4 хувьцаа эзэмшигч | 7,415,087 | 67.4% |
| 5 хүртэлх хувийн хувьцаа эзэмшигч | 413 хувьцаа эзэмшигч | 3,584,913 | 32.6% |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа*

Компанийн хувьцааны сүүлийн 3 жилийн арилжааны судалгаанаас харахад дээрх хугацаанд хувьцааны хаалтын ханш 2150-4600 төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бөгөөд нийт гаргасан хувьцааны 39.12%-тай тэнцүү хэмжээний хувьцаа эргэлтэд орж 15.0 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна.

Хүснэгт 2. Хувьцааны арилжааны судалгаа (2014.03.03)

| | |
|---|---|
| Арилжаалагдсан ширхэг | 4,371,288 |
| Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь | 39.7% |
| Үнийн дүн (тэр.төг) | 15.0 |
| Жигнэсэн дундаж ханш | 3,495.1 |
| Дээд үнэ | 4,600 |
| Доод үнэ | 2,150 |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

График 1. "БиДиСЕК" ХК-ийн хувьцааны сүүлийн 3 жилийн арилжааны мэдээлэл




*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

**Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц**

2014 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2014 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн байдлаарх компанийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. 5%-аас дээш хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл (2014.03.03 өдрийн байдлаар)

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | Alexandr Zwahr | 3,080,500 | 28.0% |
| 2 | Д.Даянбилгүүн | 2,704,251 | 24.6% |
| 3 | Firebird GM 2 S.A.R.L | 1,054,301 | 9.6% |
| 4 | Firebird MF holdings S.A.R.L | 576,035 | 5.2% |
| | **Нийт** | **7,415,087** | **67.4%** |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа*

Бүртгэлийн өдрөөрх хувьцаа эзэмшигчдийн бүтцийг дараар графикт харуулав. Нийт гаргасан хувьцааны 34.9%-ийг компанийг үүсгэн байгуулагчид, 28.0%-ийг Герман улсын хөрөнгө оруулагч, 19.1%-ийг АНУ-ын хөрөнгө оруулалтын сан эзэмшдэг бөгөөд үлдэгдэл 17.9%-ийг бусад хөрөнгө оруулагчид эзэмшиж байна.

Компанийн хувьцаа эзэмшлийн хувь хэмжээг улсаар нь ангилж үзвэл 39.7% буюу хамгийн их хувийг Монгол улс, 28.5%-ийг ХБНГерман улс, 21.2%-ийг АНУ, 4.5%-ийг Япон улсын хөрөнгө оруулагчид эзэлж байгаа бол үлдсэн 6.1%-ийг бусад улсын хөрөнгө оруулагчид эзэмшиж байна.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

График 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2014.03.03 өдрийн байдлаар)




*Эх сурвалж: БиДиСЕК ХК, Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа*

БиДиСЕК ХК-ийн хувьцаа Монголын хөрөнгийн биржийн А самбарт BDS/522 симболтойгоор нээлттэй арилжаалагддаг бөгөөд дараах хүснэгтэд орсон улсын хөрөнгө оруулагчид компанийн хувьцааг эзэмшиж байна.

Хүснэгт 4. Хувьцаа эзэмшигчид улсаар, цагаан толгойн үсгийн дараалаар

| **№** | **Улсын нэр** | **№** | **Улсын нэр** | **№** | **Улсын нэр** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Австрали | 2 | Австри | 3 | АНУ |
| 4 | Бельги | 5 | БНХАУ | 6 | Герман (ХБНГУ) |
| 7 | Ирланд | 8 | Итали | 9 | Их Британи |
| 10 | Канад | 11 | Кеймэн арал | 12 | Люксембургийн вант улс |
| 13 | Малайз | 14 | Монгол | 15 | Нидерланд |
| 16 | Өмнөд Африк | 17 | Өмнөд Солонгос | 18 | Польш |
| 19 | Сингапур | 20 | Турк | 21 | Филиппин |
| 22 | Финланд | 23 | Франц | 24 | Швейцарь |
| 25 | Шинэ Зеланд | 26 | Япон | | |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа*



2014 07 03

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Компанийн бүтэц зохион байгуулалт**

"Компанийн тухай" хуульд заасны дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь тухайн жилийн эхний 4 сард багтаан ээлжит хурал хийдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар шийдвэр гаргадаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас жил бүр ТУЗ-ийн гишүүдийг сонгох ба ТУЗ нь "Компанийн тухай" хуульд зааснаас гадна компанийн дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба компанийн стратеги төлөвлөлт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянах, зааварчилгаа өгч ажилладаг.

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-тэй байгуулсан гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн үндсэн дээр Гүйцэтгэх Захирал гардан зохион байгуулдаг. Гүйцэтгэх захирлын удирдлагад тэргүүн дэд захирал, дэд захирал, хөрөнгө удирдлагын хэсэг шууд хамаардаг.

2014 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар манай компани 9 алба, 35 мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 04 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Схем 2. Компанийн бүтэц, зохион байгуулалт




*Эх сурвалж: БиДиСЕК ХК*

Хөрөнгийн зах зээлд оролцож буй хөрөнгө оруулагчдыг гадаад дотоод гэж ангилан тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн (брокерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх) үйлчилгээг харилцагчийн болон институциональ харилцагчийн албуудаар дамжуулан хүргэж байгаа бол андеррайтерийн үйлчилгээг хөрөнгө оруулалтын албаар дамжуулан харилцагчдад хүргэж байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь жил бүрийн эхний 4 сард багтаан хуралддаг бөгөөд ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан, ирэх оны төлөвлөгөөг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэмэлт үнэт цаас гаргах, хуваах, нэгтгэх зэрэг "Компанийн тухай" хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргадаг.

## Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагыг сонгох, ажилд нь хяналт тавих зэрэг үүрэгт ажлуудыг хийхээс гадна Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бусад ажил, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 9-өөс дээш гишүүнтэй байх ба 1 жилийн бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн ТУЗ-ийн гишүүд нь 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон ажиллаж байна.

Хүснэгт 5. ТУЗ-ийн гишүүд

| № | Овог нэр, албан тушаал | Ажлын туршлага | Хувь эзэмшил |
|---|---|---|---|
| 1. | **Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ** ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга БиДиСЕК ХК-ийн Тэргүүн дэд захирал | 38 настай, 1997 онд ШУТИС-ийг нефтийн инженер мэргэжлээр төгссөн. Б.Лхагвадорж нь үнэт цаас гаргагч компанийн үүсгэн байгуулагчдийн нэг бөгөөд Монголын хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил ажилласан туршлагатай. Тэрээр үнэт цаас гаргагч компанийн Тэргүүн дэд захирлын үүрэгт ажлыг хашиж байна. | Үнэт цаас гаргагчийн 4.3%-ийн хувьцааг эзэмшдэг. |
| 2. | **Данзан ДАЯНБИЛГҮҮН** ТУЗ-ийн ердийн гишүүн БиДиСЕК ХК-ийн Гүйцэтгэх захирал | 38 настай. 1997 онд Европ хэлний дээд сургуулийг бизнесийн эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэйгээр, 2005 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг бизнесийн удирдлагын магистр (MBA) зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн. Д.Даянбилгүүн нь үнэт цаас гаргагч компанийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 1997 оноос хойш тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. | Үнэт цаас гаргагчийн 24.6%-ийн хувьцааг эзэмшдэг. |

39

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№01

| | | | |
|---|---|---|---|
| 3. | **Нарангэрэл БАТГЭРЭЛ**<br>ТУЗ-ийн ердийн гишүүн<br>БиДиСЕК ХК-ийн Дэд захирал | 40 настай. 1999 онд Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад албаны мэргэжилтэнмэргэжлээр дүүргэсэн. Хөрөнгийн зах зээл дээр 7 жил ажилласан туршлагатай.<br>Үнэт цаас гаргагч компанийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд "БиДиСЕК" ХК-ийн хүний нөөц хариуцсан Дэд захирлын үүрэгт албыг хашиж байна. | Үнэт цаас гаргагчийн 3.0%-ийн хувьцааг эзэмшдэг. |
| 4. | **James CHRISTOPHER PASSIN**<br>ТУЗ-ийн ердийн гишүүн<br>Файрбөрд менежмент ХХК-ийн хөрөнгө оруулалтын менежер | 42 настай. АНУ-ийн иргэн. Жеймс Пассин нь St.John's коллежийг философи, сонгодог уран зохиолын чиглэлээр дүүргэсэн. Олон улсын хөрөнгийн зах зээл дээр олон жил ажилласан туршлагатай.<br>Тэрээр 1999 оноос хойш Firebird Management LLC-ийн хөрөнгө оруулалтын менежерээр ажиллаж байгаа бөгөөд Firebird Global Fund, Firebird Global Fund II-ийн үүсгэн байгуулагчдын нэг юм. Тэрээр "Үндэсний хөрөнгө оруулалтын банк", "Шарын гол" ХК зэрэг компаниудын ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлыг хашиж байна. | Файрбөрд менежмент ХХК-ийн хөрөнгө оруулалтын сангууд үнэт цаас гаргагчийн 19.1%-ийн хувьцааг эзэмшдэг. |
| 5. | **Дарамранз АМГАЛАНБАЯР**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>MSM ХХК-ийн захиргааны мэргэжилтэн | 38 настай. 1997 онд МУИС-ийн эдийн засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн.<br>1997 оноос хойш "БиДиСЕК" ХК, Rock Oil ХХК-д ажиллаж байсан. Хөрөнгийн зах зээл, уул уурхай, худалдааны салбарт ажилласан туршлагатай.<br>Одоо MSM ХХК-нд захиргааны мэргэжилтэнээр ажилладаг. | Үнэт цаас гаргагчийн 3.0%-ийн хувьцааг эзэмшдэг. |



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

40

| | | | |
|---|---|---|---|
| **6.** | **HITOSHI Tani**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>EXE корпорацийн үүсгэн байгуулагч бөгөөд ерөнхийлөгч | 59 настай. Япон улсын иргэн. 1979 онд Токиогийн их сургуулийг төгссөн.<br>Тэрээр Японы томоохон компаниудын нэг Мицубиши корпорацид ажиллаж эхэлсэн. 1991 онд хөрөнгө оруулалтын EXE корпораци ХК-ийг үүсгэн байгуулсан ба Ерөнхийлөгчөөр нь ажиллаж байна.<br>EXE корпораци нь групп компаниудаа оруулаад ойролцоогоор 300 ажилчинтай бөгөөд Япон улсад төдийгүй Азийн улсуудад хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол, Мьянмар улсуудад салбар компаниудтай. | Үнэт цаас гаргагчийн 1.8%-ийн хувьцааг эзэмшдэг. |
| **7.** | **Баяртогтох ЭНХБАЯР**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>Санаа EXE групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал | 33 настай. Эдийн засагч мэргэжилтэй, Японы хөрөнгө оруулалтын EXE корпорацийн Монгол дахь салбар компани болох "Санаа EXE групп" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. | Үнэт цаас гаргагчийн 100 ширхэг хувьцааг эзэмшдэг. |
| **8.** | **Alexis DE MECQUENEM**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>Санаа EXE групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал | 31 настай. Франц улсын иргэн. Alexis De Mecquenem нь ESSCA сургуулийг санхүүгийн шинжилгээ, хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр магистерийн зэрэг хамгаалсан.<br>Тэрээр Монгол, Вьетнам, Мьянмар улсын үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх "Cube Capital HK" ХХК-ийн захирлаар ажилладаг. | Үнэт цаас гаргагчийн хувь эзэмшдэггүй. |
| **9.** | **Балжинням АМАРСАНАА**<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>Хэрээжи ХХК-ийн Гүйцэтгэх захирал | 36 настай. 1999 онд Монгол улсын их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийг гадаад албаны мэргэжилтэн мэргэжлээр төгссөн.<br>Гадаад хэргийн яаманд мэргэжилтэн, "Булган гол" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан, маркетинг, мэдээллийн технологийн чиглэлийн арвин туршлагатай.<br>2006 оноос "Хэрээжи" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. | Үнэт цаас гаргагчийн хувьцаанаас хувь эзэмшдэггүй. |



2014 07 04

41

СЭХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга:**

М.Даваажаргал нь үнэт цаас гаргагч компанийн ТУЗ-ийн 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 02 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.

Тэрээр 2011 онд СЭЗДС-ийг санхүүгийн менежмент мэргэжлээр төгссөн. 2011 онд үнэт цаас гаргагч компанид ажилд орсон.

## ТУЗ-ийн дэргэдэх дэд хороод:

2011 оноос хэрэгжиж эхэлсэн "Компанийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгаар хувьцаат компанийн хувьд ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулж болохоор заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 03, 04, 05 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын дэд хороо, аудитын дэд хороо, нэр дэвшүүлэх дэд хороодод орж ажиллах гишүүдийг шинээр томилсон бөгөөд дэд хороод хууль журамд заасан эрх үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 6. ТУЗ-ийн дэргэдэх хороод

| | |
|---|---|
| **Цалин, урамшууллын дэд хороо** | 1. Н.Батгэрэл - /Хорооны дарга/<br>2. Б.Амарсанаа<br>3. Д.Амгаланбаяр |
| **Аудитын дэд хороо** | 1. Хитоши Тани - /Хорооны дарга/<br>2. Жэймс Пассин<br>3. Д.Амгаланбаяр |
| **Нэр дэвшүүлэх дэд хороо** | 1. Д.Даянбилгүүн - /Хорооны дарга/<br>2. Б.Энхбаяр<br>3. Алексис Мекюүнэм |

## Гүйцэтгэх удирдлага

Компанийн менежментийг Гүйцэтгэх захирлаар удирдуулсан Тэргүүн дэд захирал, Дэд захирлаас бүрдсэн гүйцэтгэх удирдлагын баг хэрэгжүүлдэг. Үнэт цаас гаргагч компанийн үүсгэн байгуулагчдын нэг Д.Даянбилгүүн нь Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлыг 1997 оноос хойш гүйцэтгэж байна.

Дараах хүснэгтэд үнэт цаас гаргагч компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээллийг харуулав.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 7. Компанийн эрх бүхий албан тушаалтаны мэдээлэл (2014.03.03)

| № | Овог нэр | Нас | Эзэмшсэн мэргэжил | Компанид ажилласан жил | Албан тушаал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Данзан ДАЯНБИЛГҮҮН | 38 | Бизнесийн удирдлага (MBA) | 17 | Гүйцэтгэх захирал |
| 2 | Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ | 38 | Нефтийн инженер | 16 | Тэргүүн дэд захирал |
| 3 | Нарангэрэл БАТГЭРЭЛ | 40 | Гадаад албаны мэргэжилтэн | 8 | Дэд захирал |
| 4 | NICK Cousyn* | 44 | Эдийн засагч | 2 | Үйл ажиллагаа хариуцсан захирал |
| 5 | Сүх ПҮРЭВСҮРЭН | 39 | Авто инженер | 10 | Дотоод албаны менежер |
| 6 | Цэеэрэгзэн ЦОГ | 28 | Санхүүгийн ухааны магистр | 7 | Хөрөнгө оруулалтын албаны менежер |
| 7 | Ганболд МӨНХТУЛГА | 27 | Бизнесийн удирдага | 7 | Институцнал харилцагчийн албаны менежер |
| 8 | Шараа ШИНЭБАЯР | 34 | Бизнесийн удирдлага | 7 | Харилцагчийн албаны менежер |
| 9 | Одгийв УРАНБАЙГАЛЬ | 28 | Нягтлан бодох бүртгэл | 6 | Back Office менежер |
| 10 | Төмөрдаваа ОТГОНЖАРГАЛ | 25 | Нягтлан бодох бүртгэл | 3 | Санхүүгийн албаны менежер |

* - Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Nick Cousyn нь Калифорнийн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр дүүргэсэн бөгөөд хөрөнгийн зах зээл дээр хувьцааны борлуулалт, байгууллагын харилцагчтай харилцах чиглэлээр Imperial Credit Industries, Deutsche Bank, Wells Fargo Institutional Brokerage & Sales,



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Natexis Banque Populaires, FTN Midwest Securities, CRT Capital Group зэрэг олон улсад нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагад нийтдээ 18 жил ажилласан туршлагатай.

## Үнэт цаас гаргагчийн охин компани "БИ ДИ СИ ЭЙ ПИ" ХХК-ийн товч танилцуулга

"Би Ди Сек" ХК нь 2007 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар "Би Ди Пи И Эф" ХХК-ийг өөрийн 100% ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2007 оны 8 сарын 15 нд 5157781 регистер бүхий 9011117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

2007 оны 9-р сарын 14-нд "Би Ди Пи И Эф" ХХК ний нэрийг өөрчилж "Би Ди Си Эй Пи" ХХК болгосон.

"Би Ди Пи И Эф" ХХК нь толгой компанитайгаа байгуулсан гэрээний дагуу "Би Ди Сек" ХК-ийн үйл ажиллагааг найдвартай, түргэн шуурхай явуулах үүднээс оффисын барилга, объектын бүрэн бүтэн байдал, түүний ашиглалтыг хэвийн ажиллагаагаар хангах зорилготой ажилладаг.

"Би Ди Си Эй Пи" ХХКомпани нь Би Ди Сек ХК-тай байгуулсан гэрээний дагуу оффисын барилгын 3-5 дугаар давхарын 21-н өрөө буюу 576.7 $м^2$ талбайг бусдад түрээслүүлэх үйл ажиллагааг эрхэлж байна.

Компани нь "Би Ди Сек" ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани тул Компанийн тухай хуулийн 6.4-д заасны дагуу санхүүгийн тайлангаа тусдаа гаргадаг бөгөөд толгой компани болох "Би Ди Сек" ХК нь "Би Ди Си Эй Пи"-тай нэгдсэн санхүүгийн тайлан гаргадаг.

2013 оны байдлаар компанийн борлуулалтын орлого нь 150,364,282.45 төгрөг, татвар төлөхийн өмнөх ашиг нь 44,735,162.64 төгрөг, татварын дараах ашиг нь 40,261,646.38 төгрөгийн ашигтай ажиллажээ.

**Санхүүгийн үзүүлэлт:**

| Балансын зүйл | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 1,764,105.91 | 3,646,522.53 | 28,793,353.62 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 26,098,621.89 | 14,178,394.82 | 9,652,348.69 |
| Нийт хөрөнгийн дүн | 27,862,727.80 | 17,824,917.35 | 38,445,702.31 |
| Богино хугацаат өр төлбөр | 93,905,359.00 | 68,317,262.36 | 50,880,991.80 |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - |
| Нийт өр төлбөрийн дүн | 93,905,359.00 | 68,317,262.36 | 50,880,991.80 |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | (66,042,631.00) | (50,492,345.00) | (12,435,289.48) |
| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | 27,862,727.00 | 17,824,917.35 | 38,445,702.31 |

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ



"Би Ди Си Эй Пи" ХХК нь одоогоор найман ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэх захирлаар Сүх овогтой Пүрэвсүрэн ажиллаж байна.

Хүний нөөц:

- Сантехникч – 2
- Жолооч – 2
- Үйлчлэгч –2
- Тогооч –1



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

45

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид "**Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжиж, олон улсын стандартад нийцсэн, санхүүгийн зах зээлд тэргүүлэгч санхүүгийн байгууллага болох**" зорилготойгоор Монголын Хөрөнгийн зах зээл дээр 1991 оноос хойш амжилттай ажиллаж байна.

Манай компанийн үндсэн үйл ажиллагаа бол гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад үнэт цаас худалдан авахад зуучлах Брокерийн, зах зээл дээрээс компаниудад шаардлагатай хөрөнгийг үнэт цаас гарган татах Андеррайтерийн үйл ажиллагаа юм.

Мөн компаниуд шинээр бүртгүүлэх, бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, үр ашиг бүхий төсөлд хөрөнгө оруулалт татах, иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцоход туслах Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлдэг.

БиДиСЕК ХК-ийн удирдлага, зөвлөх, мэргэжилтнүүдээс бүрдсэн баг нь гадаад, дотоодын Хөрөнгийн зах зээл дээр олон жил ажилласан туршлагатай, мэдлэг чадвар өндөртэй чадварлаг бүрэлдэхүүн юм. Иймээс бид мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг харилцагчиддаа санал болгосоор ирсэн ба манай компанийн бүхий л үйл ажиллагаа Монгол Улсын хууль, зохицуулах байгууллагуудын журам, дүрмийн дагуу явагддаг. "БиДиСЕК" ХК-ийн үйл ажиллагааны бүхий л үзүүлэлт, зах зээл дээр эзлэх байр суурь нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай харьцуулахад өндөр хэмжээнд байдаг.

Тиймээс Монголын томоохон компани, арилжааны банкууд, гадаадын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын байгууллагууд, дэлхийн тэргүүлэх банкууд манай компанийг сонгон үйлчлүүлж байна.

### Брокерийн үйл ажиллагаа

Бид харилцагч, хөрөнгө оруулагчиддаа зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдахад нь зуучлалын үйл ажиллагаагаа түргэн шуурхай гүйцэтгэсээр ирсэн ба үйлчилгээгээ тэдэнд улам ойртуулж илүү чанартай үзүүлэхийг ямагт зорин ажилладаг.

Үүний тод жишээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах салбар нэгжийнхээ тоог нэмэгдүүлж 9 салбартай болсон, "Алсаас арилжаанд" уриатай Тел-И Брокер үйлчилгээ, Харилцагчдын арилжааны танхим зэрэг олон ажлуудыг нэрлэж болно.

Мөн бид өөрийн харилцагчид болон олон нийтэд үнэт цаасны үнэ ханшийн үнэн бодит мэдээ, мэдээлэл, судалгаа, шаардлагатай бусад заавар зөвлөгөөг хууль, журмын дагуу хүргэж байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



### Тел-И брокер үйлчилгээ

Манай харилцагчид Тел-И Брокер үйлчилгээгээр дэлхийн аль ч өнцгөөс 1 минутын дотор утас, факс, и-мэйл ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран арилжаанд оролцох боломжтой юм.

Энэхүү үйлчилгээг бид 2008 онд Хөрөнгийн зах зээл дээр анх удаа шинээр нэвтрүүлсэн бөгөөд манай харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн зах зээлд оролцогчдын хувьд дэвшилтэт үйлчилгээ болоод байна.

### Арилжааны танхим



Хөрөнгө оруулагч, харилцагчиддаа арилжаанд шууд оролцох боломжийг бий болгон, тав тухтай орчинг бүрдүүлсэн. Ингэснээр харилцагчид маань Хөрөнгийн Биржийн үнэт цаасны арилжаанд тухайн цагт нь шууд оролцох болсон ба одоогоор үнэт цаасны арилжаанд идэвхитэй оролцдог харилцагчдын 1/3 нь арилжааны танхимд ирж үйлчлүүлж байна.

Арилжааны танхимийг компанийн төв байр болон Улаанбаатар хот дахь нэг салбарт нэвтрүүлээд байгаа бөгөөд цаашид өөрийн бүх салбар нэгжүүдэд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

### Сургалт, Зөвлөгөө



Монгол Улсын Хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд өсч, Эрдэнэс таван толгой ХК-ийн хувьцааг иргэдэд олгож байгаа нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг тус зах зээлд ихээр татаж байна.

Нөгөө талаар дотоодын анхлан хөрөнгө оруулагчдын мэдлэг боловсрол бага байгаа тул манай компани тэдгээрийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шаардлагатай зөвлөгөөг хэрэгцээт үед нь өгч ажилладаг.

Бид 2008 оноос эхлэн Хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалтыг явуулж эхэлсэн бөгөөд дээрх хугацаанд нийт 5000 гаруй иргэд хамрагдаад байна. Мөн Монгол Улсын томоохон аймаг, сум болон дотоодын аж ахуй нэгжүүдэд хөрөнгийн зах зээлийн өдөрлөгийг дангаараа болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн бирж, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо зэрэг байгууллагуудтай хамран зохион байгуулсаар ирсэн.



2014 07

47

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Мэдээлэл, судалгаа**

Харилцагч нартаа өдөр тутмын арилжааны мэдээ, 7 хоногийн тойм зэрэг арилжааны мэдээ хүргэхээс гадна хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниуд, эдийн засгийн судалгаануудыг цахим болон хэвлэмэл байдлаар хүргэж байна.

**Мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан үйлчилгээ:**

**Судалгаа, анализ**

Бид гадаад болон дотоод хөрөнгө оруулагч, томоохон харилцагчиддаа зориулан Монголын эдийн засаг болон хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниудын талаарх мэдээлэл, тайлан, судалгааг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэж, харилцагчдад тогтмол хүргэн ажиллаж байна.

Судалгаа шинжилгээний онолын аргачлалыг Монголын хөгжиж буй зах зээлд тохируулан өөрчлөн, бусад хөгжиж буй улсуудын компаниудтай харьцуулалт хийж, өөрсдийн дүгнэлтийг өгч хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлдэг. 2012 оноос эхлэн олон улсын Хөрөнгийн зах зээлд 18 жил ажилласан туршлагатай АНУ-ын мэргэжилтэн Nick Cousyn-ны удирдсан судалгааны баг ажиллаж байна.

**Хөрөнгө оруулагчдын уулзалт**

Бид өөрийн харилцагчид, Монголд хөрөнгө оруулалт хийхээр сонирхон судалж байгаа дотоод, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг хувьцаат компаниуд, төрийн байгууллага, Засгийн газрын нэгжүүдтэй хийх уулзалтыг тогтмол зохион байгуулдаг.

**Багцын арилжаа**

Хувьцаат компаниудын тодорхой хувийг эзэмших сонирхолтой санхүүгийн өндөр чадамж бүхий томоохон харилцагчдыг хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчидтэй зуучлах болон өөрийн эзэмшиж буй хувийг борлуулах сонирхол бүхий хувьцаа эзэмшигчдэд тухайн үнэт цаасыг худалдан авах хөрөнгө оруулагч олох замаар багцын арилжааг зохион байгуулдаг.

**Back Office**

Монголын Хөрөнгийн Бирж болон Лондонгийн Хөрөнгийн биржийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2012 оны 7 сард Millennium IT (MIT) системийг Монголд нэвтрүүлсэн ба арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээг Клиринг банкуудад шилжүүлсэн. Ийнхүү шинэ бүтэц бий болсноор брокерийн компаниуд үүнд өөрийн үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах шаардлагатай болсон.

БиДиСЕК компани 2012 онд өөрийн бүтцэд шинээр Back office албыг бий болгон төлбөр тооцоо, T+3 арилжаа, бүртгэл мэдээлэл, хяналтын үүргийг гүйцэтгэдэг ба



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

харилцагчийн захиалгыг биелүүлэх, арилжаа хэвийн явагдах бүхий л нөхцлийг зах зээлийн журам, шаардлагын дагуу хангаж ажилладаг.

**Брокерийн үйл ажиллагааны үзүүлэлт**

Брокерийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт болох Хөрөнгийн бирж дээр явагдаж буй үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцож, ямар үүрэг гүйцэтгэж байгаа нь БиДиСЕК компанийн үйл ажиллагааны хүрээ, зах зээл дэх байр суурийг илэрхийлдэг.

Бид сүүлийн 7 жилийн байдлаар үнэт цаасны арилжааны 27-91%-ийг дангаар гүйцэтгэсэн байгаа бөгөөд энэ нь манай компани нь Монголын Хөрөнгийн зах зээлийн томоохон оролцогч болохыг илтгэж буй үзүүлэлт юм.

График 3. Үнэт цаасны арилжааны мэдээлэл




*Эх сурвалж: МХБ*

**Хувьцааны арилжаа**

2013 оны жилийн эцсийн байдлаар Хөрөнгийн бирж дээр нийт 197.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдсан бөгөөд үүнээс БиДиСЕК компани нь 52.9 тэрбум төгрөгийн арилжаа хийж, нийт арилжааны 26.8%-ийг гүйцэтгэсэн.

График 4. Хувьцааны арилжаанд эзлэх хувь




*Эх сурвалж: МХБ*



2014 07 04

СЗХ
2011 он .07 сар .07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

49

**Компанийн бондын арилжаа**

БиДиСЕК компани нь 2011 онд Хөрөнгийн бирж дээр явагдсан компанийн бондын арилжааны 75%-ийг гүйцэтгэж, 6.6 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн юм.




2011 оны 10 сард батлагдсан "Компанийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгаар Хөрөнгийн зах зээл дээр ХХК нь олон нийтэд нээлттэй бонд гаргахыг хориглосон. Энэ шийдвэр нь зах зээлийн хөгжлийг хязгаарлаж, анхдагч зах зээл дээр компанийн бонд гарах ажлыг үндсэндээ зогсоосон.

Учир нь 2011 онд Хөрөнгийн зах зээл дээр хамгийн сүүлд "Монгол Мах" бонд гаргаж, 4.4 тэрбум төгрөгийг амжилттай татсан Жаст Агро нь хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ байсан бөгөөд уг бонд гарснаас хойш зах зээл дээр шинээр компанийн бонд гараагүй байна.

**Засгийн газрын бондын арилжаа**

Монгол Улсын Засгийн газрын бондын арилжаанд БиДиСЕК компани идэвхитэй оролцдог бөгөөд 2011 онд нийт бондын арилжааны 33%-ийг дангаараа гүйцэтгэсэн бол 2010 онд нийт арилжааны 58% буюу 17.5 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн.

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10-р сарын 25-ны өдрийн хамтарсан тушаалаар Засгийн газрын бондын анхдагч зах зээлийн арилжааг Монголбанкаар дамжуулан явуулах болсноор Монголын Хөрөнгийн Бирж дээр Засгийн газрын бондын анхдагч зах зээлийн арилжаа явагдах боломжгүй болоод байгаа юм.

График 5. 2010-2011 оны Засгийн газрын бондын арилжааны мэдээлэл




*Эх сурвалж: МХБ*

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Харилцагчийн бааз суурь

"БиДиСЕК" ХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох данс бүхий харилцагчдын тоо 2013 оны байдлаар 170,545 мянгад хүрч, нийт зах зээлийн харилцагчдын 22.7%-ийг эзэлж байна.

Харин зах зээлийн хэмжээнд үнэт цаасны данстай иргэд 766,961 байгаа бөгөөд Монгол Улсын хүн амын 26.7%-ийг эзэлж байгаа юм.

"ҮЦТТТХТ" ХХК дээр нийт 2,551 аж ахуйн нэгжийн данс бүртгэлтэй байгаагаас 581 данс аж ахуйн нэгж манай компанийн харилцагч байна.

График 6. Харилцагчдын бүтэц




*Эх сурвалж: МХБ, ҮЦТТТХТ*



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Брокерийн сүлжээ**

БиДиСЕК компани нь орон нутгийн иргэдэд үзүүлэх үйлчилгээгээ чанаржуулан ойртуулах, улс орон даяар салбар нэгжтэй болох зорилтын хүрээнд Төв, Хөвсгөл, Орхон, Дархан Уул, Архангай, Булган, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад салбар байгуулж, хөдөөгийн иргэдэд хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 2. Үнэт цаас гаргагчийн салбаруудын байршил




## Андеррайтерийн үйл ажиллагааны үзүүлэлт

БиДиСЕК компани нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэржилтэнд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж байгаа ба Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан юм.

2013 оны байдлаар Монголын Хөрөнгийн зах зээл дээр 18 компани IPO хийсэн бөгөөд БиДиСЕК компани үүний 65%-ийнх нь андеррайтераар ажиллаж, зах зээл дээрээс 51.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Мөн зах зээл дээр нэмэлт үнэт цаас гаргасан компаниудын 80%-ийнх нь андеррайтераар ажиллаж 9.45 тэрбум төгрөг, компанийн бондын андеррайтераар ажиллаж 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

График 7. Андеррайтерийн үйл ажиллагааны үзүүлэлт




*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК*

## Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа

"БиДиСЕК" ХК нь 2007 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. Уг зөвшөөрлийн хүрээнд бид Үнэт цаас гаргагчдад зориулсан мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2009 оноос эхлэн Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалт хийх сонирхол бүхий хувь хүмүүст чиглэсэн үйлчилгээтэй болгон өргөжүүлсэн.

Үүний хүрээнд үнэт цаас гаргагчдын нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, өөрийн харилцагчдад үнэт цаасыг худалдах, худалдан авахад хөндлөнгийн мэргэжлийн зөвлөгөөг өгч байна.

Тухайлбал МХБ дээр арилжаалагддаг Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдал, ашигт ажиллагаа зэргээр нь ангилан "Стандарт 30 компани"-ийг шалгаруулан тухайн компани дээр үнэт цаасны суурь судалгааг боловсруулан хөрөнгө оруулагчдад хүргэж эхэлсэн.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2013 оноос эхлэн Хувьцаат компаниудын ил тод байдал, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд зөвлөгөө өгөх зорилгоор Байгууллагын зөвлөх салбарыг бий болгоод байна. Ингэснээр ХК жил бүр хийдэг Хувьцаа эзэмшигчдийн хурлыг өндөр зохион байгуулалттай хийх, компанийн засаглалыг чанаржуулах үйлчилгээг авч эхэллээ.

Зураг 3. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэв




*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

Одоогийн байдлаар Хөрөнгө оруулалтын зөвлөх салбар нь 18 компанитай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн МХБ-д бүртгэлтэй идэвхигүй хувьцаат компаниудыг Хаалттай компани болгох ажлыг манай компани Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээгээрээ дамжуулан гүйцэтгэж байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 8. Баланс

| Баланс | 2013 он Мян.төг | 2012 он Мян.төг | 2011 он Мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| ***Эргэлтийн хөрөнгө*** | | | |
| Мөнгөн хөрөнгө | 857,856 | 661,214 | 88,577 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 4,096,218 | 4,387,242 | 5,303,268 |
| Худалдааны болон бусад авлага | 1,290,441 | 938,103 | 265,116 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **6,244,515** | **5,986,559** | **5,656,961** |
| ***Эргэлтийн бус хөрөнгө*** | | | |
| Үндсэн хөрөнгө - цэвэр | 3,396,621 | 3,660,528 | 3,652,941 |
| Биет бус хөрөнгө - цэвэр | 3,330 | 1,260 | 2,050 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,081 | 2,081 | 434,301 |
| Урт хугацаат авлага | 104,261 | 97,598 | 75,647 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | 2,195 | 2,988 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **3,505,293** | **3,763,661** | **4,167,926** |
| **Нийт хөрөнгө** | **9,749,808** | **9,750,220** | **9,824,887** |
| **Өр төлбөр** | | | |
| ***Эргэлтийн өр төлбөр*** | | | |
| Худалдааны өглөг | 104,459 | 202,030 | 317,965 |
| Татварын өглөг | 12,696 | 17,187 | 119,124 |
| Ногдол ашгийн өглөг | 660,000 | - | 550,000 |
| Урьдчилж орсон орлого | 10,000 | - | 30,000 |
| **Эргэлтийн өр төлбөрийн дүн** | **787,156** | **219,217** | **1,017,089** |
| ***Эргэлтийн бус өр төлбөр*** | | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 44,542 | 61,946 | 139,099 |
| **Эргэлтийн бус өр төлбөрийн дүн** | **44,542** | **61,946** | **139,099** |
| **Нийт өр төлбөр** | **831,698** | **281,163** | **1,156,188** |
| **Өмч** | | | |
| Хувьцаат капитал | 1,100,000 | 1,100,000 | 1,100,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | 2,825,305 | 2,825,305 | 2,825,305 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 1,300,244 | 1,300,244 | 1,300,244 |
| Үнэт цаасны хэрэгжээгүй олз, гарз | 400,877 | 557,512 | 1,251,891 |
| Хуримтлагдсан ашиг | 3,291,685 | 3,685,997 | 2,191,259 |
| **Нийт өмч** | **8,918,111** | **9,469,057** | **8,668,698** |
| **Нийт өмч ба өр төлбөр** | **9,749,808** | **9,750,220** | **9,824,887** |



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

55

Хүснэгт 9. Орлогын тайлан

| Орлогын тайлан | 2013 он Мян.төг | 2012 он Мян.төг | 2011 он Мян.төг |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 2,446,064 | 5,777,990 | 5,037,309 |
| Борлуулсан үнэт цаасны өртөг | (650,221) | (1,093,568) | (811,212) |
| **Нийт ашиг** | **1,795,843** | **4,684,422** | **4,226,097** |
| Түрээсийн орлого | 150,364 | 120,565 | |
| Санхүүгийн орлого (зардал) | 32,759 | 42,006 | |
| Үйл ажиллагааны зардал | (1,628,571) | (3,108,205) | (2,641,126) |
| **Үйл ажиллагааны ашиг** | **350,395** | **1,738,787** | **1,584,972** |
| Үйл ажиллагааны бус орлого | 463 | 1,407 | 10,807 |
| Үйл ажиллагааны бус зардал | (27,890) | (74,659) | (34,337) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **322,969** | **1,665,534** | **1,561,441** |
| Орлогын татварын зардал | (35,086) | (174,140) | (159,508) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | **287,883** | **1,491,394** | **1,401,933** |
| **Нэгж хувьцаанд ногдол ашиг (төгрөг)** | **26** | **136** | **127** |

Хүснэгт 10. Мөнгөн гүйлгээний тайлан

| Мөнгөн гүйлгээ | 2013 он Мян.төг | 2012 он Мян.төг | 2011 он Мян.төг |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө | 1,534,718 | 4,284,489 | 3,618,113 |
| Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө | 124,633 | 15,567 | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,526 | 15,857 | 7,432 |
| Бусад мөнгөн орлого | | 15,454 | 30,042 |
| Харилцагчаас орж ирсэн орлого | 7,685,474 | 133,837,510 | 65,268,414 |
| **Нийт мөнгөн орлогын дүн** | **9,346,351** | **138,168,877** | **68,924,001** |
| Ажиллагчдад олгосон мөнгө | (396,552) | (321,351) | (223,951) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | (99,910) | (78,064) | (54,532) |
| Түүхий эд, эд материал худалдан авахад төлсөн мөнгө | - | | (141) |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | (99,432) | (36,188) | (52,619) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | (42,768) | (24,437) | (52,254) |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | (294,642) | - | (2,875) |
| Төлсөн хүү, хураамж | - | | (1,987) |



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | |
|---|---|---|---|
| Төлсөн орлогын татвар | (43,908) | (339,623) | (98,486) |
| Шимтгэл хураамжид төлсөн мөнгө | (898,404) | (1,618,961) | (1,729,058) |
| Бусад | - | (852,967) | (376,538) |
| Харилцагчдад төлсөн мөнгө | (7,676,131) | (134,235,550) | (65,233,995) |
| **Нийт үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **(9,551,746)** | **(137,507,141)** | **(67,826,435)** |
| **Үндсэн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(205,395)** | **661,735** | **1,097,566** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | |
| Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | 1,000 | 6,708 | |
| Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | (12,813) | (254,572) | (564,802) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | 941,840 | 1,575,388 | 1,072,228 |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | (533,237) | (949,074) | (1,805,884) |
| Хүлээн авсан хүү, ногдол ашиг | 3,312 | 8,189 | 1,095 |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ** | **400,103** | **386,640** | **(1,297,363)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Гаргасан хувьцаа | | | |
| Бусдаас авсан зээл | 300,000 | 1,372,805 | 9,077,528 |
| Зээлийн төлөлт | (300,000) | (1,372,805) | (8,826,035) |
| Төрөл бүрийн хандив | | (10,000) | (56,706) |
| Мөнгөөр төлсөн ногдол ашиг | - | (550,000) | |
| Хүү ба урамшууллын орлого | 10,534 | 28,747 | 11,181 |
| Валютын ханшийн зөрүү | (8,600) | 55,514 | 21 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,934** | **(475,738)** | **205,989** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **196,641** | **572,637** | **6,192** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 661,214 | 88,577 | 82,385 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 857,856 | 661,214 | 88,577 |

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Хүснэгт 11. 2011-2013 оны балансад хийсэн бүтцийн шинжилгээний үр дүн

| Үзүүлэлт | 2013 | 2012 | 2011 | Дундаж |
|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 8.80% | 6.78% | 0.90% | 5.49% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 42.01% | 45.00% | 53.98% | 47.00% |
| Авлага | 13.24% | 9.62% | 2.70% | 8.52% |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 64.05% | 61.40% | 57.58% | 61.01% |
| Үндсэн хөрөнгө | 34.84% | 37.54% | 37.18% | 36.52% |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | 1.11% | 1.06% | 5.24% | 2.47% |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 35.95% | 38.60% | 42.42% | 38.99% |
| **Нийт хөрөнгийн дүн, хувиар** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 8.07% | 2.25% | 10.35% | 6.89% |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 0.46% | 0.64% | 1.42% | 0.84% |
| Нийт өр төлбөр | 8.53% | 2.88% | 11.77% | 7.73% |
| Хувьцаат капитал | 11.28% | 11.28% | 11.20% | 11.25% |
| Нэмж төлөгдсөн капитал | 28.98% | 28.98% | 28.76% | 28.90% |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 17.45% | 19.05% | 25.98% | 20.83% |
| Хуримтлагдсан ашиг | 33.76% | 37.80% | 22.30% | 31.29% |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | 91.47% | 97.12% | 88.23% | 92.27% |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | **100%** | **100%** | **100%** | **100%** |

Хөрөнгийн бүтцийг харахад нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хэмжээ 60%-иас дээш байгаа нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг нарийвчлан авч үзвэл нийт эргэлтийн хөрөнгийн дийлэнх хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байгаа нь компаний үндсэн үйл ажиллагааны нэг дилер (хөрөнгө оруулалт)-ийн үйл ажиллагааны хүрээнд богино хугацаанд эзэмшиж буй үнэт цаасны дүн юм. Авлагын дүн ерөнхийдөө тогтвортой бөгөөд авлагуудын ихэнхи төлөгдөх хугацаа нь болоогүй хэвийн авлагууд байна. Нийт хөрөнгийн бүтцэд хөрвөх чадвар сайтай хөрөнгө дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн хувьд нийт хөрөнгийн 36% орчим байгаагийн дийлэнх хэсэг нь компанийн оффисын барилга, үл хөдлөх хөрөнгийн дүн эзлэж байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн эх үүсвэрийн 91% орчим нь өөрийн эх үүсвэрээс бүрдсэн байна. 2013 оны байдлаар өр төлбөрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь 2.8%-иас 8.5% болж огцом өссөн байна. Энэ нь 2012 онд нэгж хувьцаанд 60 төгрөгийн ногдол ашиг олгох шийдвэртэй холбоотой 2013 оны санхүүгийн тайланд ногдол ашгийн өглөг бичигдсэн. Бусдад төлөх өрийн үүргийг өөрийн хөрөнгөөр хариуцах чадвар урт болон дунд, ойрын хугацаанд сайн байна.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 12. 2011-2013 оны орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээний үр дүн

| Үзүүлэлт | 2013 | 2012 | 2011 | Дундаж |
|---|---|---|---|---|
| **Борлуулалтын орлогын дүн** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 24.73% | 18.41% | 16.10% | 19.75% |
| Нийт ашиг | 75.27% | 81.59% | 83.90% | 80.25% |
| Үйл ажиллагааны зардал | 61.94% | 52.32% | 52.43% | 55.57% |
| **Үйл ажиллагааны ашиг** | **13.33%** | **29.27%** | **31.46%** | **24.69%** |
| Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал) | -1.04% | -1.23% | -0.47% | -0.91% |
| Татварын өмнөх ашиг | 12.28% | 28.04% | 31.00% | 23.77% |
| Орлогын татвар | 1.33% | 2.93% | 3.17% | 2.48% |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **10.95%** | **25.11%** | **27.83%** | **21.30%** |

Үнэт цаас гаргагчийн орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээгээр борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн болон татварын зардлууд нь ашгийн зохих шатлалд хэрхэн нөлөөлж буйг дүгнэвэл:

Борлуулалтын орлогын 25% орчим нь дилер (хөрөнгө оруулалт)-ийн үйл ажиллагаа, андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд худалдан авч, борлуулсан үнэт цаасны өөрийн үнэ эзлэж байна.

Борлуулалтанд эзлэх ашгийн хувь хэмжээ 2011-2012 оны байдлаар дундажаар үндсэн үйл ажиллагааны ашиг 30 орчим хувьд хэлбэлзэж байсан бол 2013 онд 13 орчим хувь болон буурсан байна. Үйл ажиллагааны зардлын 34%-ийг цалингийн зардал, 22% нь компаний үндсэн үйл ажиллагаатай холбоотой шимтгэлийн зардал, 17%-ийг элэгдлийн зардал эзэлж байна. Харин татварын өмнөх ашиг 12 орчим хувьтай, цэвэр ашгийн түвшин 11 орчим хувьтай байна. 2013 оны байдлаар авч үзэхэд дээрх үзүүлэлтүүд сүүлийн 3 жилийн дунджаас доогуур байгаа нь 2012-2013 онд зах зээл болон компанийн үйл ажиллагаа бууралттай байсантай холбоотой байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Хүснэгт 13. 2011-2013 оны санхүүгийн тайланд хийсэн харьцааны шинжилгээ

| | 2013 | 2012 | 2011 | Дундаж |
|---|---|---|---|---|
| **Income Statement** | | | | |
| Sales Growth | -58% | 15% | 88% | 15% |
| Gross margin | 75.27% | 81.59% | 83.90% | 80.25% |
| Operating margin | 13.33% | 29.27% | 31.46% | 24.69% |
| EBITDA Margin | 23.01% | 32.06% | 33.27% | 29.45% |
| Tax rate | 1.33% | 2.93% | 3.17% | 2.48% |
| Net income margin | 10.95% | 25.11% | 27.83% | 21.30% |
| **Balance Sheet** | | | | |
| Debt/Equity | 9.33% | 2.97% | 13.34% | 8.54% |
| Asset turnover | 27% | 61% | 51% | 46.39% |
| Current ratio | 7.93 | 27.31 | 5.56 | 13.60 |
| **Mixed Ratios** | | | | |
| ROE | 3% | 16% | 16% | 11.72% |
| ROIC | 4% | 18% | 16% | 12.63% |
| ROA | 3% | 15% | 14% | 10.84% |
| Depreciation as % of PP&E | 7% | 6% | 3% | 4.94% |
| **Valuation** | | | | |
| P/E | 91.70 | 26.73 | 27.46 | 48.63 |
| EV/EBIT | 79.90 | 23.77 | 24.66 | 42.77 |
| EV/EBITDA | 43.63 | 20.80 | 22.97 | 29.13 |

***Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдалд хийсэн шинжилгээнээс дүгнэлт:***

- 2010-2012 онд компанийн борлуулалтын орлого жил бүр дунджаар 52%-ийн өсөлттэй байсан бол 2013 онд зах зээлийн бууралттай нөхцөл байдлаас хамааран өмнө жилийн мөн үеэс борлуулалтын орлого 58%-иар буурсан үзүүлэлтэй байна.
- Компанийн нийт ашгийн түвшин 75%, цэвэр ашиг 11%, үйл ажиллагааны ашиг 13%-тай байна.
- Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа сүүлийн 3 жилийн дунджаар 8% байгаа нь компаний хувьд төлбөрийн чадвар өндөр байгааг илэрхийлж байна.
- Хөрөнгийн зах зээл сүүлийн 2 жил уналттай байгаа нь үнэт цаас гаргагчийн өгөөжийг бууруулсан.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Монголын эдийн засгийн байдал

2011-2013 онд Монгол Улсын эдийн засаг хоёр оронтой тоогоор буюу маш хурдтай өсөж байгаа нь дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байна. Манай улсын ДНБ 2013 онд 11.7%-иар өссөн бөгөөд үүний 5.1% нь үйлдвэрлэлийн салбар, 4.3% нь үйлчилгээний салбар, 2.0% нь хөдөө аж ахуйн салбарын өсөлт байна. Барилгын салбар 66.5%-иар буюу хамгийн өндөр өсөлттэй байсан бол бөөний болон тээвэр ба агуулахын үйл ажиллагаа хамгийн бага буюу 1.6%-ийн бууралттай байна. ДНБ оны үнээр 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2012 оныхоос 25.2%-иар өсч, 17,550.2 тэрбум төгрөгт хүрчээ. Уул уурхайн салбар 20.7%-иар өсөхөд 2013 оны 7 дугаар сард Оюу толгой ордын үйлдвэрлэл эхэлсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 14. Бодит ДНБ, салбараар (тэрбум төгрөг)

| Салбар | 2007 он | 2008 он | 2009 он | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 3,640.0 | 3,964.0 | 3,913.7 | 4,162.8 | 4,891.8 | 5,498.5 | 6,144.2 |
| *өсөлт* | *10.2%* | *8.9%* | *-1.3%* | *6.4%* | *17.5%* | *12.4%* | *11.7%* |
| Уул уурхай | 683.8 | 672.6 | 711.5 | 736.9 | 791.0 | 854.5 | 1,031.2 |
| *өсөлт* | *1.1%* | *-1.6%* | *5.8%* | *3.6%* | *7.3%* | *8.0%* | *20.7%* |
| Хөдөө аж ахуй | 734.1 | 768.4 | 796.3 | 664.2 | 660.7 | 803.2 | 911.3 |
| *өсөлт* | *14.4%* | *4.7%* | *3.6%* | *-16.6%* | *-0.5%* | *21.6%* | *13.5%* |
| Боловсруулах үйлдвэрлэл | 250.8 | 257.5 | 234.3 | 248.6 | 269.2 | 294.5 | 314.6 |
| *өсөлт* | *27.5%* | *2.7%* | *-9.0%* | *6.1%* | *8.3%* | *9.4%* | *6.8%* |
| Цахилгаан, хий, уур, ус | 98.8 | 106.8 | 113.4 | 112.8 | 122.3 | 126.6 | 133.8 |
| *өсөлт* | *6.3%* | *8.2%* | *6.1%* | *-0.5%* | *8.5%* | *3.5%* | *5.7%* |
| Барилга | 90.9 | 78.4 | 51.7 | 60.2 | 81.7 | 113.5 | 189.0 |
| *өсөлт* | *7.2%* | *-13.8%* | *-34.0%* | *16.5%* | *35.6%* | *38.9%* | *66.5%* |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 274.3 | 315.5 | 278.2 | 387.5 | 535.8 | 667.5 | 781.2 |
| *өсөлт* | *5.5%* | *15.0%* | *-11.8%* | *39.3%* | *38.3%* | *24.6%* | *17.0%* |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 356.8 | 425.5 | 459.4 | 491.5 | 536.3 | 585.0 | 575.7 |
| *өсөлт* | *25.2%* | *19.3%* | *8.0%* | *7.0%* | *9.1%* | *9.1%* | *-1.6%* |
| Мэдээлэл, холбоо | 132.4 | 157.6 | 169.5 | 180.3 | 189.7 | 202.4 | 219.0 |
| *өсөлт* | *24.2%* | *19.0%* | *7.5%* | *6.4%* | *5.2%* | *6.7%* | *8.2%* |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 130.0 | 169.6 | 143.1 | 143.6 | 198.8 | 277.0 | 353.5 |
| *өсөлт* | *19.5%* | *30.4%* | *-15.6%* | *0.3%* | *38.5%* | *39.4%* | *27.6%* |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 166.5 | 180.3 | 195.5 | 195.9 | 204.9 | 220.5 | 231.3 |
| *өсөлт* | *-0.3%* | *8.3%* | *8.4%* | *0.2%* | *4.6%* | *7.6%* | *4.9%* |
| Үйлчилгээний бусад салбар | 312.0 | 351.4 | 366.9 | 371.5 | 401.2 | 451.0 | 481.8 |
| *өсөлт* | *4.4%* | *12.6%* | *4.4%* | *1.2%* | *8.0%* | *12.4%* | *6.8%* |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 409.5 | 480.2 | 394.0 | 569.9 | 900.2 | 902.7 | 921.8 |
| *өсөлт* | *6.8%* | *17.2%* | *-18.0%* | *44.7%* | *57.9%* | *0.3%* | *2.1%* |

*Эх сурвалж: ҮСХ*



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Өнгөрсөн оноос "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр", Чингис бондоор санхүүжигдэх төслүүд үргэлжлэн хэрэгжиж, мөнгө, зээлийн үзүүлэлтүүд тогтворжин, хөдөө аж ахуй, барилгын салбарын өсөлт өндөр байгаагийн зэрэгцээ Оюу толгой төслийн бүтээгдэхүүнийг экспортолж эхэлсэн зэрэг нь оны сүүлийн хагаст эдийн засгийн бодит өсөлтөд эерэгээр нөлөөлсөн.

График 8. ДНБ-ий бодит өсөлт, салбараар




*Эх сурвалж: ҮСХ*

## Эдийн засгийн үзүүлэлтүүд

### Улсын төсөв

Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 5,927.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 19.5% буюу 969.8 тэрбум төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого ба тусламжийн 85.3%-ийг татварын орлого, 13.9%-ийг татварын бус орлого, үлдсэн 0.8%-ийг хөрөнгийн орлого болон тогтворжуулалтын сан эзэлж байна.

График 9. Төсвийн нийт орлого, тусламж




*Эх сурвалж: ҮСХ*

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 155.2 тэрбум төгрөгөөр өсч 4,559.3 тэрбум төгрөг байв. Уг дүнгийн 38.74%-ийг бараа, үйлчилгээний зардал,

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



30.68%-ийг татаас ба шилжүүлэг, 4.38%-ийг зээлийн үйлчилгээний төлбөр эзэлж байна.

**Хөрөнгө оруулалт**

2013 онд нийт 6,285.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь 2012 оноос 3,110.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгө оруулалтын 55.7% нь гадаадын хөрөнгө оруулалт байна.

График 10. Хөрөнгө оруулалт, салбараар




| Хөрөнгө оруулалт, салбараар | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он |
|---|---|---|---|---|
| Аж үйлдвэр | 1936.9 | 5494.6 | 5005.2 | 2893.4 |
| Хөдөө аж ахуй | 23.3 | 38 | 64.6 | 31.8 |
| Барилга | 262.8 | 990.7 | 913.8 | 807.4 |
| Тээвэр | 136.7 | 280.1 | 510.5 | 570.2 |
| Бусад | 1486.1 | 1584.4 | 2901.7 | 1982.8 |

*Эх сурвалж: ҮСХ*

Нийт хөрөнгө оруулалтын 46% нь аж үйлдвэрийн салбарт, 13% нь барилгын салбарт, 9% тээврийн салбарт, 1%-ийг хөдөө аж ахуйн салбарт орж, үлдсэн 32% нь бусад салбаруудад орсон байна.

**Гадаад валютын нөөц, ханшийн хэлбэлзэл**

2013 онд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын гол валют болох ам.долларын ханш 19.9%, БНХАУ-ын валют болох юань ханш 23.08%-иар өссөн байна.

График 11. Валютын ханшийн хэлбэлзэл, гадаад валютын нөөц







*Эх сурвалж: ҮСХ, Монгол банк*

**Инфляци**

2013 онд улсын инфляцийн түвшин 12.5% байсан ба уг инфляцийн дунд боловсролын үйлчилгээ, хувцас бөс бараа, гэр ахуйн тавилга хэрэгсэл, зочид буудал зоогийн газрын



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



үнийн индекс өсөлттэй байгаа бол ус цахилгаан түлш, тээвэр, шуудан холбооны үнийн индекс буурсан үзүүлэлттэй байна. Уг үнийн өсөлтөнд гадаад валютын үнийн өсөлт голлон нөлөөлсөн.

График 12. Инфляцийн түвшин




*Эх сурвалж: ҮСХ*

Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан үзвэл 9.3%-ийг мах, 12.8%-ийг махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 15.4%-ийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, 1.4%-ийг шатахууны үнийн өсөлт эзэлж байгаа бол үлдсэн 61.1%-ийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

**Өрхийн орлого**

Монгол Улсын өрхийн орлого жил бүр тогтвортой өсөж байгаа ба 2013 онд 17%-иар өсч улсын хэмжээнд өрхийн дундаж орлого 959.0 мянган төгрөгт хүрээд байна. Улсын хэмжээнд 1,125.4 мянган хөдөлмөрлөх насны идэвхитэй иргэд байна.

График 13. Өрхийн орлого, ажиллагсадын тоо




*Эх сурвалж: ҮСХ*

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2013 оны 12 дугаар сарын эцэст 42.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 7.0 мян.хүн буюу 19.6%-иар өсчээ.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№01



**Гадаад худалдаа, түүхий эдийн зах зээл**

Монгол Улс 2013 онд дэлхийн 135 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт урьдчилсан дүнгээр 10,627.4 сая ам.доллар, үүнээс экспорт 4272.7 сая ам.доллар, импорт 6354.7 сая ам.долларт хүрчээ.

График 14. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, сая ам.доллар




*Эх сурвалж: ҮСХ*

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 495.7 сая ам.доллар буюу 4.5%, экспорт 112.0 сая ам.доллар буюу 2.6%, импорт 383.7 сая ам.доллар буюу 5.7%-иар буурчээ.

Экспортын 96.5%-ийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл эзэлж байна.

## Эдийн засгийн цаашдын чиг хандлага

График 15. Монгол Улсын ДНБ-ийн өсөлтийн таамаг, хувиар




*Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, Азийн хөгжлийн банк*

Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтийн нэг болох ДНБ-ийн өсөлтийн цаашдын чиг хандлагын талаар Олон улсын санхүүгийн байгууллагуудын таамаглалыг дээрх графикт харуулав. Үүнээс харахд Монгол Улс ойрын жилүүдэд эдийн засгийн өсөлт тогтвортой үргэлжлэхээр төсөөлөгдөж байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

“БиДиСЕК” ХК нь эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор Монголын Хөрөнгийн Бирж дээр 6,000,000 (зургаан сая) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, компанийн хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалж санхүүжилт татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Бид 2006 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос анх андеррайтерийн тусгай зөвшөөрлийг авч байсан бөгөөд өдгөө андеррайтерийн үйл ажиллагааг 8 дахь жилдээ амжилттай явуулж байна. Энэ хугацаанд нийт 11 компанийн IPO, 4 компанийн нэмэлт хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргаж ажилласан бөгөөд үүний 4 компанид нь Stand by commitment хийж борлогдоогүй үлдсэн хувьцааг өөрсдөө худалдан авч байсан. Харин бусад компанийн хувьцааг дээд зэргийг хүчин чармайлт (Best efforts)-аар хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалах замаар шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Бид ирэх 3 жилийн төсөөллийг харахдаа Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын сонирхолыг татахуйц шинэ бүтээгдэхүүн, үнэт цаасны нийлүүлэлтийг идэвхижүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд энэ нь компанийн ашиг орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжил, улс орны эдийн засагт эерэг нөлөөг авчирна гэж үзэж байна.

### Хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт, шинэчлэл

Монголын хөрөнгийн зах зээл үүсч хөгжөөд өдгөө 23 жил болж байгаа хэдий ч хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүний нэр төрөл хомс хэвээр байна. Өнгөрсөн хугацаанд шинээр нийт 18 компанийн хувьцаа (IPO), 4 компанийн нэмэлт хувьцаа, 5 компанийн бонд гарсан хэдий ч зах зээл дээрх эрэлт, хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол нь хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах, хөрөнгө оруулагчдын оролцоог хумих нөхцлийг бүрдүүлж байна.

Үүний үндсэн шалтгаан нь шинээр үнэт цаас гаргах шалгуур өндөр, хөрөнгийн зах зээлд бүртгэгдэх үйл явц хэт их ажиллагаатай байсантай холбоотой юм.

2013 онд Хөрөнгийн зах зээлд үүсээд байгаа асуудлуудыг шийдвэрлэх, хууль эрхзүйн орчныг шинэчлэн сайжруулах зорилгоор УИХ-аас “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд үүнийг дагаад салбарын зохицуулах байгууллага, арилжаа эрхлэх байгууллага зэргийн журмуудад тодорхой өөрчлөлтүүд орсон юм.

Манай улсад орж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын маш бага хувь нь хөрөнгийн зах зээлээр дамжин орж ирж байгаа нь дээрх шалтгаантай холбоотой бөгөөд эдгээр хууль, журмууд өөрчлөгдсөнөөр Үнэт цаас гаргагч талд уян хатан нөхцлөөр хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт босгох боломжийг олгож байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Монголын хөрөнгийн зах зээлийн хууль эрхзүйн шинэчлэлийг дагаад дотоодын том, жижиг ялгаагүй бүх төрлийн компаниудын хувьд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох ажиллагаа илүү хялбар, тодорхой, сонголттой болж байгаа нь Хөрөнгийн зах зээл дээр олон төрлийн үнэт цаасны шинэ бүтээгдэхүүнүүд гарах боломжийг бий болгож байна.

Хууль, журамд орсон томоохон шинэчлэлийн нэг нь давхар бүртгэлийн зохицуулалт юм. Энэхүү зохицуулалтын хүрээнд Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадад бүртгэлтэй аж ахуй нэгжүүдийг Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэх, мөн Монголын томоохон Хувьцаат компаниуд гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэх хууль эрх зүйн орчныг нээлттэй болгосон явдал юм.

Санхүүгийн зах зээлтэй өрсөлдөх гол хүчин зүйл нь санхүүжилт татах хугацаа бөгөөд зохицуулах байгууллагууд үүн дээр шинэ журмынхаа хүрээнд харьцангуй уян хатан зохион байгуулалттай болсон нь аж ахуй нэгж, компаниудын хувьд богино хугацаанд Хөрөнгийн биржид бүртгэгдэж олон нийтийн компани болох боломжийг олгож байна.

Эндээс үзэхэд хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа илүү хялбаршиж, ойлгомжтой болж байгаа нь зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн бий болох таатай нөхцөл бүрдсэн гэж хэлж болохоор байна.

**БиДиСЕК ХК-ийн андеррайтерийн үйл ажиллагаа хөрөнгийн зах зээлд нөлөөлөх нөлөөлөл**

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 254 удаагийн арилжаагаар 134 компанийн 65.8 сая ширхэг хувьцааг 97.6 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10.0 мянган ширхэг бондыг 1.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 98.6 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсан байна.

График 16. Хувьцааны арилжааны хэмжээ, тоо/ширхэг




*Эх сурвалж: МХБ*



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 47.1 тэрбум төгрөгөөр буюу 32.57 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Андеррайтерийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хувьцаагаарх санхүүжилт нь Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаагаар явагдах болно. Ингэснээр хувьцааны арилжааны үнийн дүнг ирэх 3 жилийн хугацаанд 418 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

График 17. Зах зээлийн нийт үнэлгээ




*Эх сурвалж: МХБ*

Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2013 оны эцэст 1,671 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 7.1%-иар буурсан үзүүлэлт болж байна. Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд ирэх 3 жилийн хугацаанд нийт 418 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлнэ гэж төлөвлөсөн бөгөөд энэ нь нийт андеррайтераар ажиллах компанийн нийт үнэлгээний 25-30% нь болно. Иймд энэ хэмжээний хөрөнгө татан төвлөрүүлснээр зах зээлийн үнэлгээг 1,394 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

68

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

## Өрсөлдөгчийн судалгаа

Өнөөдрийн байдлаар Санхүүгийн Зохицуулах хорооноос Хөрөнгийн зах зээл дээр Андеррайтерийн үйл ажиллагаа явуулах эрх авсан 28 компани үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компаниудын 18% нь хөрөнгийн зах зээл дээр шинээр гарсан IPO-нд андеррайтер хийсэн бөгөөд бусад нь зах зээл дээр ямар нэгэн IPO гаргаагүй байна.

Хүснэгт 15. Андеррайтерийн эрхтэй компаниудын мэдээлэл

| № | Үсгэн код | Андеррайтерын эрхтэй компаниуд | Андеррайтераар ажилласан IPO | Нэмэлт хувьцаа (FPO) |
|---|---|---|---|---|
| 1 | APS | Азиа Пасифик Секьюритис | | |
| 2 | ARD | Ард Капитал Групп | | |
| 3 | ACE | Асе энд Т Капитал | Зоос банк | |
| 4 | BDSC | БиДиСЕК | Монгол шилтгээн ХК,<br>БиДиСЕК ХК,<br>Женко тур бюро ХК,<br>Хай Би Ойл ХК,<br>ТСУНөөц ХК,<br>Хөх ган ХК,<br>Нако түлш ХК,<br>Силикат ХК,<br>Э Транс ложистикс ХК,<br>Монинжбар ХК,<br>Шарын гол ХК, | Хай Би Ойл ХК,<br>Нако түлш ХК,<br>Нако түлш ХК,<br>Хай Би Ойл ХК, |
| 5 | BLMB | Блүмсбюри Секьюритис | | |
| 6 | GAUL | Гаули | Ремикон ХК | |
| 7 | ECM | Евроазиа Капитал Холдинг | | |
| 8 | CAPM | Капитал маркет корпораци | | |
| 9 | LFTI | Лайфтайм Инвестмент | | |
| 10 | MNET | Монет капитал | | |
| 11 | MSEC | Монсек | | |
| 12 | NSEC | Нэйшнл Секюритис | | |
| 13 | PREV | Превалент | | |
| 14 | RESC | Рескап Секьюритис | | |
| 15 | STIN | Стандарт Инвестмент | Мерекс ХК | |
| 16 | TDB | Ти Ди Би Капитал | | |
| 17 | TUIN | Туушин Инвест | | |
| 18 | TNGR | Тэнгэр Капитал | | |
| 19 | FRON | Фронтиер | | |
| 20 | MIBG | Эм Ай Би Жи | | |
| 21 | MICC | Эм Ай Си Си | Монфреш ХК | |
| 22 | MJIH | Эм Жэй Ай Эйч | | |
| 23 | SGC | Эс Жи Капитал | | |
| 24 | FCX | Эф Си Икс | | |
| 25 | USEC | Юнайтед Секьюритс | | |
| 26 | BZIN | Дэү секьюритис ХХК | | |
| 27 | ITR | Ай трейд ХХК | | |
| 28 | GLMT | Голомт банк ХХК | | |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

69
СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Зах зээл дээр гарсан үнэт цаасны мэдээлэл

Монгол Улсад Хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөнөөс хойш аж ахуй нэгж байгууллагууд болон Засгийн газраас Хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа, бонд гаргах замаар өөрт шаардлагатай хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлсээр байна.

Хүснэгт 16. Хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгө

| Үнэт цаасны төрөл | Анх гарсан огноо | Гаргагчийн тоо | Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум.төг/ | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Хувьцаа /IPO, FPO/ | 2005 | 18 | 93.01 | 16.9 |
| Компанийн бонд | 2001 | 11 | 17.61 | 3.2 |
| Засгийн газрын бонд | 1996 | 1 | 440.56 | 79.9 |
| | | | **551.18** | **100%** |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

### Хөрөнгийн зах зээл дээр гарсан хувьцаа

Хүснэгт 17. Хувьцаагаар татсан хөрөнгө

| Хувьцааны төрөл | Анх гарсан огноо | Гаргагчийн тоо | Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум.төг/ | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Шинэ хувьцаа /IPO/ | 2005 | 18 | 83.93 | 89.8 |
| Нэмэлт хувьцаа /FPO/ | 2008 | 4 | 9.08 | 10.2 |
| | | | **93.01** | **100%** |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

МХЗЗ дээр 2005 оноос эхэлсэн шинээр хувьцаа /IPO/ гарч эхэлсэн бол 2008 онд хувьцаат компаниуд зах зээл дээр нэмж хувьцаа /FPO/ гаргаж эхэлсэн бөгөөд нийт 18 компани IPO хийснээс 17 компанийнх нь амжилттай хийгдэж, 1 компанийн IPO /Монфреш/ амжилтгүй болоод байна.

IPO нь амжилттай хийгдсэн 17 компанийн нийт 305.3 сая ширхэг хувьцаа Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж, зах зээл дээрээс нийтдээ 83.9 тэрбум төгрөгийг босгожээ.

Харин олон нийтэд санал болгох болон өрийг хувьцаанд шилжүүлэх, хаалттай хүрээнд санал болгох зэрэг хэлбэрээр 4 компани нэмж хувьцаа гаргасан ба нийтдээ 9.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.1 сая ширхэг хувьцааг нэмж гаргасан байна.


2014 07 04

СЗХ
2014 он. 07 сар. 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Хөрөнгийн зах зээл дээр IPO хийсэн компаниуд

Хүснэгт 18. IPO хийсэн компаниуд

| № | IPO хийсэн компаниуд | Нийт гаргасан ширхэг | Гаргасан үнэ | Татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум төг/ | Гаргасан огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Шилтгээн | 10,000,000 | 800 | 0.80 | 2005 |
| 2 | Женко Тур Бюро | 100,000,000 | 100 | 8.26 | 2006 |
| 3 | Зоос Банк | 14,666,703 | 100 | 2.02 | 2006 |
| 4 | БиДиСЕК | 10,000,000 | 100 | 0.75 | 2006 |
| 5 | Монинжбар | 15,869,233 | 100 | 1.00 | 2006 |
| 6 | Хай Би Ойл | 5,000,000 | 100 | 0.40 | 2007 |
| 7 | Оллоо | 9,700,497 | 100 | 0.58 | 2007 |
| 8 | ТСУНөөц | 120,000,000 | 1 000 | 13.20 | 2007 |
| 9 | Хөх Ган | 101,317,557 | 100 | 3.19 | 2008 |
| 10 | Нако Түлш | 11,000,000 | 100 | 0.74 | 2008 |
| 11 | Мон Фреш | 148,320,348 | 100 | - | 2008 |
| 12 | Ремикон | 98,992,602 | 100 | 5.05 | 2008 |
| 13 | Гермес | 78,543,001 | 100 | 2.36 | 2008 |
| 14 | Анод Банк | 39,418,531 | 1 080 | 20.11 | 2008 |
| 15 | Силикат | 16,222,300 | 225 | 3.65 | 2011 |
| 16 | Шарын гол | 1,707,404 | 11 117 | 18.30 | 2011 |
| 17 | Э-Транс Ложистикс | 7,700,000 | 120 | 0.92 | 2012 |
| 18 | Мерекс | 26,000,000 | 100 | 2.6 | 2014 |
| **Дүн** | | **305,303,052** | | **83,93** | |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, МХБ*

## Хөрөнгийн зах зээл дээх нэмж хувьцаа гаргасан компаниуд

Хүснэгт 19. FPO гаргасан компаниуд

| № | Компаниуд | Нэмж гаргасан ширхэг | Гаргасан үнэ | Татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэр.төг/ | Огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | БиДиСЕК | 1,000,000 | 3,000 | 2.63 | 2008 |
| 2 | Хай Би Ойл | 4,234,268 | 300/174 | 0.73 | 2008/2010 |
| 3 | Нако түлш | 1,615,721 | 229 | 0.27 | 2010 |
| 4 | Шарын гол | 1,292,596 | 4221 | 5.45 | 2011 |
| **Дүн** | | **8,142,585** | | **9.1** | |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, МХБ*

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

71

**Бонд гаргасан компаниуд**

МХЗЗ дээр 2001 оноос эхлэн бонд гаргах хэлбэрээр хөрөнгө оруулалт татаж эхэлсэн бөгөөд давхардсан тоогоор 13 компани гаргаж, зах зээл дээр нийтдээ 1.64 сая ширхэг бонд арилжаалагдан 17.61 тэрбум төгрөг босгосон байна.

Хүснэгт 20. Бонд гаргасан компаниуд

| № | Компаниуд | Арилжаалагдсан ширхэг | Нэрлэсэн үнэ | Татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум төг/ | Огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Барилга корпораци" ХК | 533 568 | 10 000 | 5.34 | 2001 |
| 2 | "Алтан хот корпораци" ХХК | 99 692 | 10 000 | 0.99 | 2002 |
| 3 | "Нийслэл өргөө" ХК | 240 000 | 5 000 | 1.20 | 2002 |
| 4 | "Их барилга төсөл" ХХК | 26 000 | 50 000 | 1.30 | 2003 |
| 5 | "MCS электроникс" ХХК | 7 272 | 120 000 | 0.87 | 2004 |
| 6 | "MCS электроникс" ХХК | 5 000 | 100 USD* | 0.61 | 2004 |
| 7 | "Анодбанк" ХХК | 20 949 | 10 000 | 0.21 | 2004 |
| 8 | "Говь" ХК | 100 000 | 10 000 | 1.00 | 2005 |
| 9 | "Монинжбар" ХК | 50 000 | 10 000 | 0.50 | 2005 |
| 10 | "Пума групп" ХХК | 50 000 | 10 000 | 0.50 | 2007 |
| 11 | "Монфреш" ХХК | 15 692 | 10 USD* | 018 | 2007 |
| 12 | "Монинжбар" ХК | 50 200 | 10 000 | 0.50 | 2008 |
| 13 | "Жаст агро" ХХК | 439 954 | 10 000 | 4.39 | 2011 |
| | | **1 638 327** | | **17.61** | |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, МХБ*



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗАМААР САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

### Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Компанийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2014 оны 04 сарын 18-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №03 тоот тогтоол, ТУЗ-ийн 2014 оны 05 сарын 15-ний өдрийн №06 тоот тогтоолоор үнэт цаас гаргагч компани нэмж гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд гаргаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлнэ. Нэмж гаргаж буй 6,000,000 ширхэг хувьцаагаар татан төвлөрүүлэх хөрөнгийг компанийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зарцуулна.

Нэмэлт хувьцаа гаргахдаа эхлээд Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг нийт 6,000,000 ширхэг хувьцаа дээр хэрэгжүүлэх ба тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлээд үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд байршуулна.

Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнийг зах зээлийн үнэ болох 2,146 төгрөгөөс 10% хямдруулсан үнэ болох 1,931 /нэг мянга есөн зуун гучин нэг/ төгрөгөөр санал болгох ба үлдсэн хувьцааг олон нийтэд тогтсон үнийн аргаар санал болгоно. Олон нийтэд санал болгох үнийг тухайн үеийн зах зээлийн ханшийг үндэслэн тэргүүн ээлжинд санал болгох үнээс багагүй байхаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

Нэмэлт үнэт цаас гарган татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй хөрөнгийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 21. Нэмэлт хувьцаа гарган татах хөрөнгө

| | |
|---|---|
| **САНАЛ БОЛГОХ ҮНЭ:** | |
| Тэргүүн ээлжинд санал болгох үнэ | 1,931 төгрөг |
| Олон нийтэд санал болгох үнэ | Зах зээлийн үнийг үндэслэн ТУЗ-өөс тогтооно |
| **ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГӨ:** | |
| Тэргүүн ээлжинд санал болгох үнээр тооцоход: | 11,586,000,000 төгрөг |
| Зах зээлийн үнээр тооцоход: | 12,876,000,000 төгрөг |

Нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын дийлэнх хэсгийг хөрөнгө оруулалт, андеррайтерийн үйл ажиллагаанд зарцуулах ба энэ нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 94% болно. Үлдэх 6%-ийг хүний нөөцийн хөгжил, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (ESOP) зэргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Нэмэлт хувьцаа гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 22. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт (төгрөгөөр)

| | Үйл ажиллагааны нэр | Үнийн дүн | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Тэргүүн ээлжинд санал болгох үнээр тооцоход | Зах зээлийн үнээр тооцоход | |
| 1 | Хөрөнгө оруулалт, андеррайтерийн үйл ажиллагааг өргөтгөх | 10,890,840,000 | 12,103,440,000 | 94% |
| 2 | Хүний нөөц, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (ESOP) | 695,160,000 | 772,560,000 | 6% |
| | ***Бүгд*** | **11,586,000,000** | **12,876,000,000** | ***100%*** |

График 18. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт




## I. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Монгол улсын эдийн засаг болоод хөрөнгийн зах зээлийн доорх эерэг нөхцөл байдал, хүлээгдэж буй таамаглалууд нь компани цаашид хөрөнгө оруулалт, андеррайтерийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх томоохон хөшүүрэг болоод байна.

Монгол Улсын ДНБ өсөлт 2011 онд 17.3%, 2012 онд 12.3%, 2013 онд 11.7%-д хүрч, эдийн засгийн өсөтөөр дэлхийд тэргүүлэх орнуудын нэг болоод байна. Энэхүү өсөлтийн 5.1 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.3 нэгж хувийг үйлчилгээний салбар, 2 нэгж хувийг ХАА эзэлж байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

74

Монгол Улсын Засгийн газраас 2012 онд Олон улсын зах зээл дээр Чингис бондыг арилжаалж 1.5 их наяд ам.долларын санхүүжилт татаж дэд бүтэц, төмөр зам, эрчим хүчний салбарын томоохон төслүүдийн ажлыг эхлүүлээд байна.

Засгийн газраас 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилтийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор "үйлдвэржилтийн шинэ эрин үе" гэж зарласныг дэмжин, уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, импортыг орлох, улмаар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин ажиллахаар зарлаад байна.

2013 онд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хөгжлийн чиг хандлагыг УИХ-аар хэлэлцэн баталж УБ хотын зарим дүүрэг хороонд дахин төлөвлөлт хийж орон сууцжуулах, барилгажуулахаар ажиллаж эхлээд байна. Энэхүү төсөл хөтөлбөрийн хүрээнд олон ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж, үүнээс дурдвал дулааны цахилгаан станцууд шинээр барих, одоо ажиллаж буй ДЦС-уудыг өргөтгөх, авто замын сүлжээг өргөтгөх, хурдны зам тавих, метро барих, гэр хорооллыг орон сууцжуулах, дагуул хот байгуулах гэсэн томоохон ажлууд байна.

Засгийн газраас төмөр зам, авто зам, аж үйлдвэрийн боловсруулах үйлдвэр барих зэрэг томоохон төслүүдийг төр, хувийн хэвшлийн хамтарсан хувьцаат компани хэлбэрээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсад дэлхийн хэмжээний төслүүд болох Оюутолгой, Таван Толгойн төслүүд хэрэгжиж, эдгээртэй холбоотой дагалдах бизнесүүд хөгжиж байна.

Дэд бүтцийн томоохон төслүүд болох төмөр зам, хатуу хучилттай зам, эрчим хүчний станцууд, нисэх буудал, аж үйлдвэрийн парк зэрэг нийт 30-50 тэрбум долларын төслүүд ойрын 5-н жилд хэрэгжихээр төлөвлөгдөж байна.

Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин шинэчлэл нь зах зээлд олон шинэ боломжуудыг нээж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдын анхаарлыг татаж байна. Тухайлбал: Шинэчлэгдсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль зэргийг дурдаж болно.

Мөн Монгол Улс нь бүс нутгийн хэмжээнд хамгийн бага татварын системтэй бөгөөд аж ахуй нэгжийн татварын хэмжээ нь 10% болон 25% гэсэн 2 шатлалтай.

Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 94%-ийг хөрөнгө оруулалтын болон андеррайтерийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зарцуулахаар тооцоолсон ба энэ нь 10.8 тэрбум төгрөгөөс 12.1 тэрбум төгрөг байхаар байна.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд дараах чиглэлүүдийг барьж ажиллана. Үүнд:

**ЧИГЛЭЛ-1:** Хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалагдаж буй үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх,

**ЧИГЛЭЛ-2:** Хаалттай хүрээнд барилга, уул уурхай, санхүү, аж үйлдвэрийн салбарын компаниудад хөрөнгө оруулалт хийх,

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ-1: Хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалагдаж буй үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх**

"БиДиСек" ХК-ийн 2007-2013 онуудын богино хугацаат хөрөнгө оруулалтын /2009 оныг оролцуулаагүй/ дундаж өгөөж 25%-тай байна. Дилер (хөрөнгө оруулалт)-ийн үйл ажиллагааны өгөөж 2009 онд сөрөг дүнтэй гарсан нь санхүү эдийн засгийн хямралтай холбоотой тул ойрын 5 жилийн МУ-ын цаашдын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн эерэг хандлагаас үзэхэд уг өгөөжийн түвшин 20 хувиас буурахгүй гэж таамаглаж байна.

2014 оны 5 сарын 1-ний өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд 181 хувьцаат компанийн үнэт хувьцаа бүртгэлтэй байдаг ба тэдгээрийн 19.9% нь А самбарын компани, үлдсэн 80.1% нь Б самбарын компаниуд байна.

Мөн 2013 оны жилийн эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 206 хувьцаат компани байдаг бөгөөд тус компаниудыг салбарынх нь хувьд авч үзвэл:

Хүснэгт 23. Бүртгэлтэй хувьцаат компани, салбараар

| Салбар | Бүртгэлтэй хувьцаат компани, салбараар | | Нийт | Хувиар |
|---|---|---|---|---|
| | А самбар | Б самбар | | |
| Уул уурхай /A/ | 8 | 31 | 39 | 18.9% |
| Аж үйлдвэр /B/ | 14 | 34 | 48 | 23.3% |
| ХАА /C/ | 0 | 31 | 31 | 15.0% |
| Барилга, тээвэр /D/ | 5 | 47 | 52 | 25.2% |
| Худалдаа, үйлчилгээ /E/ | 8 | 28 | 36 | 17.5% |
| Нийт | 35 | 171 | 206 | 100% |

*Эх сурвалж: МХБ*

2014 оны 5 сарын 7-ны өдрийн байдлаар биржийн бүртгэлтэй хувьцаат компанийн жагсаалтад багтсан 206 хувьцаат компанийн нийт зах зээлийн үнэлгээ 1,528.5 тэрбум төгрөг байна. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд нь нийт бүртгэлтэй компанийн 18.9%-ийг эзэлж буй хэдий ч зах зээлийн нийт үнэлгээний 42.4%-ийг бүрдүүлж байна. Бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээний



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



34.1% нь аж үйлдвэр, 17.1% нь худалдаа үйлчилгээний салбар, 5.4% нь барилга, тээврийн салбараас бүрдэж байна. ХАА-н салбарын хувьд нийт компаниудын 15%-ийг (компанийн тоогоор) эзэлж байгаа боловч зах зээлийн үнэлгээний дөнгөж 1.0%-ийг эзэлж байна.

График 19. Бүртгэлтэй хувьцаат компаниуд, салбараар

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд, салбараар




МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээ, салбараар




*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хөрөнгийн зах зээлд барилга, уул уурхай салбарыг онцолж хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй ба тэдгээр салбарт үйл ажиллагаа явуулж буй хувьцаат компаниудад хөрөнгө оруулалт хийн ажиллахаар төлөвлөж байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ-2: Хаалттай хүрээнд компаниудад хөрөнгө оруулалт хийх

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Монгол улсад хурдацтай хөгжиж буй салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, компаниудад хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байгаа ба үүнд уул уурхай, барилга, санхүү, аж үйлдвэрийн салбаруудыг онцолж байгаа болно. Эдгээр салбаруудын статистик тоон мэдээллийг 61 дүгээр хуудаснаас харах боломжтой.

### а) Уул уурхайн салбар

Уул уурхайн салбар нь монгол улсын голлох салбаруудын нэг бөгөөд ДНБ-ний 16.8%-ийн эзэлж байгаа ба 2013 онд уул уурхайн салбар 1,031.2 тэрбум төгрөг буюу өмнө жилээс 20.7%-ийн өсөлттэй байна.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Уул уурхайн салбар сүүлийн 3 жилийн дунджаар ДНБ-ний 18.7 хувь, Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 66.7 хувь, мөн экспортын орлогын 91.3 хувийг бүрдүүлсэн байна.

График 20. Уул уурхайн салбарын Монгол улсын эдийн засагт эзлэх хувь




*Эх сурвалж: ҮСХ*

Монгол улсны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний дийлэнх нь уул уурхайн бүтээгдэхүүн байгаа ба 2013 онд нийт 4,273 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортонд гаргаснаас уул уурхайн бүтээгдэхүүн экспортын 94 хувийг бүрдүүлж байна.

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурч нийт экспортын 94%-ийг бүрдүүлжээ. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 82%, нийт экспортын 74%-ийг тус тус эзэлж байна.

График 21. Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн, сая ам.доллар




*Эх сурвалж: ҮСХ*

2013 онд экспортын хэмжээ 111,9 сая ам.доллараар буурсан ба үүнд зэсийн баяжмал, нүүрс болон бусад голлох экспортын бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь нөлөөлсөн.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Монгол улсын экспортын бүтээгдэхүүний статистик мэдээлэл:**

Монгол улс 2013 оны эхний 4 сарын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2,953 сая ам доллар үүнээс экспорт 1,212.5 сая ам доллар, импорт 1,740.8 сая ам долларт хүрсэн байна. Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний 4-сард 528.3 сая ам долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 269 сая ам.доллар буюу 33.7 хувиар буурчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 410.6 сая ам доллар буюу 12.2 хувь үүнээс импортын хэмжээ 339.8 сая ам.доллар буюу 16.3 хувь, экспортын хэмжээ 70.8 сая ам.доллар буюу 5.5 хувиар буурчээ. Экспортын 97 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс , зоос зэрэг бүтээгдэхүүн эзэлж байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 24. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн (мянган ам.доллар)

| Бүтээгдэхүүн | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014.03 |
|---|---|---|---|---|---|---|
| Нүүрс | 184,666 | 882,007 | 2,273,006 | 1,901,774 | 1,122,034 | 206,460 |
| Зэсийн баяжмал | 501,846 | 770,594 | 968,551 | 838,780 | 948,951 | 349,162 |
| Төмрийн хүдэр | 88,770 | 253,825 | 441,515 | 532,509 | 654,333 | 81,405 |
| Боловсруулаагүй газрын тос | 115,633 | 154,386 | 253,024 | 336,053 | 515,456 | 157,611 |
| Цайрын баяжмал | 122,494 | 134,135 | 143,188 | 130,830 | 119,085 | 14,601 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | 308,473 | 178,339 | 109,778 | 122,294 | 309,827 | 89,843 |

*Эх сурвалж: ҮСХ*

Оюу толгой төслийн 1-р үе шат буюу ил уурхайн бүтээн байгуулалт 2013 онд бүрэн ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба уг далд уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг ойрын хугацаанд шийдвэрлэгдэхээр байгаа бөгөөд төсөл бүрэн хэрэгжсэнээр дунд хугацаандаа Оюу толгой төсөл нь Монгол улсын ДНБ-ий 1/3-ийг дангаараа бүрдүүлнэ гэж Олон улсын санхүүгийн корпораци (IFC) тооцоолж байна.

Түүнчлэн Тавантолгойн нүүрсний орд зэрэг бусад стратегийн томоохон ордуудыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг нь эхлүүлснээр уул уурхайн салбарын Монгол улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө ихээр нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.



2014 07 04

79
СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

## b) Барилгын салбар

Барилга угсралт, их засварын ажил 2013 онд 1452.2 тэрбум төг болж, 1326.3 тэрбум төг буюу 91.3 хувь нь дотоодын, 125.9 тэрбум төг буюу 8.7 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна.

Хүснэгт 25. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, тэрбум төг

| Гүйцэтгэгчийн төрөл | 2011 | 2012 | 2013 | оны өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Барилга угсралт, их засварын ажил, бүгд | 745.0 | 811.3 | 1,452.2 | 179% |
| Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн | 657.2 | 748.1 | 1,326.3 | 177.30% |
| Гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн | 87.8 | 63.2 | 125.9 | 199.20% |

*Эх сурвалж: ҮСХ*

Барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 640.9 тэрбум төг буюу 79.0 хувиар өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил 578.2 тэрбум төг буюу 77.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

График 22. Ашиглалтанд орсон орон сууцны тоо, орон сууцны фонд




*Эх сурвалж: ҮСХ*

Арилжааны банкуудын барилгынханд олгодог зээл өсч, 2013 онд нийт 550 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оноос хоёр дахин өссөн байна. Энэ бүхний үр дүнд 2013 онд барилгын компаниуд 216 төсөл хэрэгжүүлэн, 20,300 айлын орон сууцыг ашиглалтад оруулжээ.

Монгол улсад үл хөдлөх хөрөнгийн зах зээл хөгжөөд багагүй хугацаа өнгөрч байгаа бөгөөд дээрх хугацаанд тус салбар тогтвортой өсөлтийг үзүүлж байна. Монгол улсын эдийн засгийн хурдацтай хөгжил нь байр, орон сууц худалдан авах гол хөшүүрэг болж үүнийг даган үл хөдлөх хөрөнгийн эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2012 оны эцсийн байдлаар нийт хүн амын 45% буюу 1,287,100 иргэн амьдарч байгаа судалгаа байна.

1990 оноос Монгол Улс нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжсэнээр хүн амын УБ хотруу шилжин ирэх урсгал жил бүр нэмэгдэн хүн амын төвлөрөл ихээр үүсээд байна. Улаанбаатар хотын нийт хүн амын 51.1% нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд байдаг ба нийслэлд өдөрт 78 хүн бүр мөсөн суурьшихаар



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



шилжин ирж байгаа бол, дөнгөж 23 хүн хөдөө орон нутаг руу бүрмөсөн шилжин суурьшихаар явж байна. 2012 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн нийт өрхийн 40% буюу 122.7 мян өрх орон сууцны хороололд, 60% буюу 184.1 мян өрх гэр хороололд амьдарч байна. Хотруу шилжих хөдөлгөөн жил бүр нэмэгдэж байгаагаас гэр хороолол нийслэл хот бүх чиглэлд тэлж байгаа ба гэр хорооллын өрхийн жилийн дундаж өсөлт 6% байна. Ийнхүү нийслэлд хүн амын хэт төвлөрөл бий болсон нь хотын өнгө үзэмж, нийгмийн олон асуудлыг эх үүсвэр болж байна.

Дараах хүснэгтээс хотын хүн ам болон 1969-2009 оны хоорондох орон сууцны хангамжийн талаарх мэдээллийг харна уу.

График 23. Нийслэлийн орон сууцны хангамж

*Улаанбаатар хотын хүн ам, өрхийн тоо*




*Нийслэлийн орон сууцны хангамж*




*Эх сурвалж: УСХ, УБ хотын 2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө*

***Барилгын салбарын хүлээгдэж буй төсөөлөл:***

2013 оны 1 дүгээр сараас Монгол банк, Барилга хот байгуулалтын яам хамтран "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү дэд хөтөлбөр нь барилгын салбарын эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах, барилгын материалын үнийг тогтвортой байлгах зориготой бөгөөд хэрэгжих хугацаа 3 жил, санхүүжилтийн дүн 800 тэр.төгрөг байна.

УИХ-аас "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага" хөтөлбөрийг хэлэлцэн баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу гэр хороолол дахин төлөвлөлтүүд хийгдэж эхлэж байна. Эхний ээлжинд 7 байршилд орон сууцжуулахаар төлөвлөн тендер зарлан барилгын компаниудыг сонгон шалгаруулт хийгдээд байгаа ингэснээр нийлүүлэлт ихээр нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.

Нөгөө талаас худалдан авалтыг дэмжих зорилгоор 2013 оны 4 сарын 13-ны өдөр Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллаж харилцан ойлголцлын санамж бичиг Ерөнхий сайд, Монгол банкны ерөнхийлөгч нар гарын үсэг зурлаа. Зээлийн хүүг 7-9 хувь болгох, 50 $м^2$ хязгаарыг 80 $м^2$ болгон өөрчлөв.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Барилгын салбарын дэд бүтцийг сайжруулах зорилгоор "Улаанбаатар дулааны 5 дугаар цахилгаан станц"-ыг барих ажлын сонгон шалгаруулалт явагдаж байна.

Дээр дурьдсанчлан ойрын жилүүдэд Монгол улсын барилгын салбарт ихээхэн хэмжээний бүтээн байгууалалт хийгдэхээр хүлээгдэж байгаа нь тус салбарт санхүүжилтийн хэрэгцээ өндөр байх нөхцлийг бүрдүүлж байна.

### c) Санхүүгийн салбар

Санхүүгийн салбар нь манай улсын эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэгч үндсэн салбаруудын нэг юм.

Санхүүгийн салбар нь 2007-2012 онуудад Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 4 хувийг бүрдүүлж байсан бол 2013 онд 5.8 хувийг бүрдүүлсэн байна.

График 24. ДНБ болон санхүүгийн салбарын ДНБ-ий өсөлт, жилээр




*Эх сурвалж: Монголын банкны холбооны тайлан*

Санхүүгийн салбарын үндсэн 4 хэсэг Банк, ББСБ, Даатгал, Хөрөнгийн зах зээл (БДК)-ийн салбарт эзлэх хувь хэмжээг дараах графикт харуулав.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

График 25. Санхүүгийн салбарын хувь хэмжээ, 2013.06.30-ны өдрийн байдлаар




Эх сурвалж: Монголын банк, СЗХ, МХБ

Дээрх графикаас харахад Санхүүгийн салбарын нийт активын 96.8%-ийг банкны салбар бүрдүүлж байгаа тус салбарын голлох оролцогч юм. Банкны салбар нь санхүүгийн салбарын нийт цэвэр ашгийн 82.7%-ийг эзэлж байна.

Нөгөө талаар нийт активын дөнгөж 1.9%-ийг бүрдүүлэгч ББСБ-ууд нь тус салбарын нийт цэвэр ашгийн 10.9%-ийг хүртэж байгаа юм. Иймд ББСБ салбарын компаниудад хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах нь өндөр өгөөжийг хүртэх боломжтойг харуулж байна. Банк бус санхүүгийн зах зээлийн талаар мэдээллийг доор танилцуулав.

***Банк бус санхүүгийн салбар:***

СЗХ-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 263 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай 19, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 31, Зөвхөн гадаад валютын эрхтэй 41 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



График 26. Банк бус санхүүгийн байгууллагын тоо, жилээр




*Эх сурвалж: СЗХ*

2013 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-уудийн 83.3% нь зээлийн үйл ажиллагаа, 39.5% нь гадаад валютын үйл ажиллагаа эрхлэдэг, 8.0% нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 4.9% нь факторингийн үйлчилгээ, 3.4% нь төлбөрийн баталгаа гаргах, 8.0% нь итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байна.

Хүснэгт 26. ББСБ-ын харьцуулсан үзүүлэлт, мянган төгрөгөөр

| Үндсэн үзүүлэлтүүд | 2012 | 2013 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Нийт актив** | **252,053,541.4** | **381,130,752.7** | **51.2%** |
| Банкны салбарт эзлэх хувь | 2.1% | 1.8% | -0.3% |
| **Нийт зээлийн өрийн үлдэгдэл** | **157,769,345.8** | **223,711,713.9** | **41.8%** |
| Банкны салбарт эзлэх хувь | 2.2% | 2.1% | -0.2% |
| **Нийт эздийн өмч** | **171,296,659.6** | **234,337,952.6** | **36.8%** |
| Банкны салбарт эзлэх хувь | 17.4% | 17.7% | 0.3% |
| **Нийт дүрмийн сан** | **139,194,226.2** | **183,691,627.8** | **32.0%** |
| Банкны салбарт эзлэх хувь | 45.4% | 50.6% | 5.2% |

*Эх сурвалж: СЗХ-ны жилийн тайлан*

2013 онд ББСБ-н нийт актив өмнөх оноос 51.2% -иар өссөн бөгөөд ББСБ-ийн дүрмийн сангийн хэмжээ нийт активын 48.2%-ийн эзэлж байгаа нь үйл ажиллагааны ихэнх хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгааг харуулж байна.

2013 оны байдлаар ББСБ-уудын нийт эх үүсвэрийн 61.5% нь эздийн өмч болон урт хугацаат өр төлбөр, 38.5% нь богино хугацаат өрийн эх үүсвэрээр бүрдсэн байна.

2012 оноос 2013 онд нийт эздийн өмчийн дүн 36.8%-иар өсөхөд хуримтлагдсан ашгийн 72.5%-ийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байгаа нь тус салбар ашигт ажиллагаа өндөр байгааг илтгэж байна.

Хүснэгт 27. ББСБ-ын салбарын орлогын бүтэц

| Үзүүлэлт /мянган төгрөгөөр/ | 2012 | | 2013 | | Өөрчлөлт (%) |
|---|---|---|---|---|---|
| | дүн | хувь | дүн | хувь | |
| Хүүгийн орлого | 45,674,079 | 65% | 66,088,468 | 62% | 45% |
| Хүүгийн бус орлого | 23,344,791 | 33% | 39,317,032 | 37% | 68% |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 1,149,375 | 2% | 1,088,443 | 1% | -5% |



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ердийн бус үйл ажиллагааны орлого | 314,866 | 0% | 158,143 | 0% | -50% |
| Нийт орлого | 70,483,111 | 100% | 106,652,086 | 100% | 51% |

*Эх сурвалж: СЗХ*

ББСБ-уудын нийт үйл ажиллагааны орлого 2012-2013 онд 51%-ийн өсөлттэй, тус орлогын дийлэнх хэсэг хүүгийн орлогоос 62%, хүүгийн бус орлогоос 37%-ийн бүрэлдэхүүнтэй байна.

Голлох орлого болох хүүгийн орлогын хувьд 2013 оны эцсийн байдлаар ББСБ-ын зээлийн сарын хамгийн дээд хүү 9.0%, хамгийн бага хүү 0.5% , дундаж хүү 3.13%-тай байна. ББСБ-ын зээлийн дундаж хүүг Банкны салбартай харьцуулсан графикийг харна уу.

График 27: ББСБ-ийн дундаж зээлийн хүүгийн хэмжээ /сарын/




*Эх сурвалж: СЗХ*

Хүснэгт 28. ББСБ-ын салбарын ашигт ажиллагаа, мянган төгрөгөөр

| Үзүүлэлт | 2012 | 2013 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Нийт орлого | 70,483,110.80 | 106,652,086 | 51% |
| Нийт зардал | 51,903,731.80 | 76,817,417 | 48% |
| **Цэвэр ашиг** | 18,579,379.00 | 29,834,669 | 61% |

*Эх сурвалж: СЗХ*

2013 онд салбарын цэвэр ашиг өмнөх оноос 61%-иар өсч, цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь 28% болсон байна.

Сүүлийн жилүүдэд нийт банк бус санхүүгийн байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуй нэгжүүдэд олгосон зээлийн хэмжээ 5 жилийн дунджаар жилд 36%-иар өссөн. Зээлийн эрэлтээс үүсэх энэхүү өсөлт нь цаашид хүүгийн хэмжээ одоогийн түвшинд хадгалагдах, салбарын ашигт ажиллагаа нэмэгдэх үндсэн үзүүлэлт болж байна.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

85

### d) Аж үйлдвэрийн салбар

2013 оны Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 7.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 28.4%-иар өссөн байна. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, алт, цайрын баяжмал, төмрийн хүдэр, хайлуур жоншны баяжмал, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний 0.1-42.6 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

График 28. Аж үйлдвэрийн салбарын хувь, хэмжээ




*Эх сурвалж: ҮСХ*

Хүснэгт 29. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

| Бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013* | 2014** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цахилгаан эрчим хүч | сая квт.цаг | 4,001 | 4,039 | 4,313 | 4,536 | 4,816 | 5,038 | 5,304 |
| Нүүрс | мян.тн | 10,072 | 14,442 | 25,246 | 32,030 | 29,926 | 27,625 | 33,704 |
| Газрын тос | мян.баррель | 1,174 | 1,870 | 2,181 | 2,549 | 3,636 | 4,600 | 5800,0 |
| Зэсийн баяжмал | мян.тн | 525 | 533 | 522 | 514 | 518 | 797 | 1,111 |
| Алт | кг | 15,184 | 9,803 | 6,037 | 5,703 | 5,995 | 12,780 | 27,155 |
| Төмрийн хүдэр | мян.тн | 1,387 | 1,379 | 3,203 | 5,678 | 7,561 | 5,930 | 6,532 |
| Цайрын баяжмал | мян.тн | 144 | 142 | 113 | 105 | 119 | 115 | 117 |

*Эх сурвалж: Эдийн засаг хөгжлийн яам*

Хүснэгт 30. Боловсруулах аж үйлдвэрлэлийн борлуулсан бүтээгдэхүүн, дэд салбараар, оны үнээр, сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2011 | 2012 | 2013 | Үүнээс гадаадад |
|---|---|---|---|---|
| Аж үйлдвэр, бүгд | 5,626,746.2 | 6,058,023.8 | 6,456,583.2 | 3,780,559.1 |
| Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн | 1,566,825.2 | 1,949,749.9 | 2,106,308.3 | 729,574.9 |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 664,855.20 | 719,877.80 | 815,274.70 | 17,390.50 |
| Тамхи үйлдвэрлэл | 41,611.60 | 45,211.70 | 66,445.90 | - |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 179,933.20 | 175,078.80 | 228,674.00 | 128,657.10 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 15,614.80 | 20,604.60 | 33,601.50 | 5,384.90 |

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | | | |
|---|---|---|---|---|
| Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 2,451.50 | 8,565.10 | 8,409.30 | 4,001.00 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 11,500.90 | 15,660.50 | 13,998.40 | - |
| Цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 11,772.90 | 14,935.00 | 13,243.40 | - |

*Эх сурвалж: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам*

### Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилт:

Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хөнгөн аж үйлдвэрийн салбарт 2013-2016 хөгжүүлэх зорилт, хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойлсон байна.

Үүнд:

- Ноолуурын салбарт 2012 оны байдлаар нийт 9.8 мянган ажилчид 250 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг боловсруулж байгаа бөгөөд 2016 онд нийт 20 мянган ажилчидтай, 1 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн боловсруулах,
- Ноосны бэлтгэл 70% байгаа бөгөөд хивсэн эдлэлийн гол түүхий эд болж байна. 2012 оны байдлаар уг салбарт 3 мянган ажилчид ажиллаж 50 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол 2016 онд 8 мянган ажилчидтай, нийт үйлдвэрлэлийн хэмжээг 250 тэрбум төгрөгт хүргэх,
- Арьс ширний салбарт одоогоор 3,500 ажилчин ажиллаж байгаа бол зорилтот онд 20,000 ажилчинтайгаар 2012 оны үйлдвэрлэлээс 4.4 дахин их буюу 965.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- Ой модны үйлдвэрлэлийн салбарт 5,000 ажилчин 105.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг 2016 онд 7,000 ажилчинтай, үйлдвэрлэлийн хэмжээ 148.9 тэрбум төгрөг болох,

Хүснэгт 31 Хөнгөн аж үйлдвэрийг 2013-2016 онд хөгжүүлэх зорилт, хүрэх үр дүн

| | Үзүүлэлт | 2012 он | 2016 онд хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| 1 | **Ноолуурын салбар** | | |
| | Ноолуурын бэлтгэл | 30% | 100% |
| | Ээрмэл утасны үйлдвэрлэлт | 1238 тн | 4000 тн |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 232 мян.тууш метр | 2,5 сая тууш метр |
| | Сүлжмэл бүтээгдэхүүн | 1,2 сая ширхэг | 3,8 сая ширхэг |
| 2 | **Ноосны салбар** | | |
| | Ноосны бэлтгэл | 70% | 100% |
| | Хивсний үйлдвэрлэлт | 0,9 сая м2 | 1,2 сая м2 |
| | Ноосон даавуу үйлдвэрлэл | 0 | 2,5 сая тууш метр |
| | Барилгын дулаалгын материал | 20,0 мян.м2 | 520 мян м2 |
| 3 | **Арьс ширний салбар** | | |
| | Түүхий эдийн бэлтгэл | 25% | 100% |
| | Хагас боловсруулсан арьс | 112 тэрбум ₮ | 99,7 тэрбум ₮ |
| | Гүйцэд боловсруулсан арьс | 38,0 тэрбум ₮ | 238,6 тэрбум ₮ |
| | Эцсийн бүтээгдэхүүн | 77,0 тэрбум ₮ | 627 тэрбум ₮ |



2014 07 04

87

СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Ой, модны үйлдвэрлэлийн салбар** | | |
| | Модон тавилга | 22,1 тэрбум ₮ | 31,3 тэрбум ₮ |
| | Барилгын модон хийц | 11.6 тэрбум ₮ | 17.8 тэрбум ₮ |
| | Түлээний мод | 40.1 тэрбум ₮ | 23.8 тэрбум ₮ |
| | Шахмал түлш | 1.1 тэрбум ₮ | 14.9 тэрбум ₮ |
| | Шахмал хавтан | 0 | 23.8 тэрбум ₮ |

*Эх сурвалж: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам*

Дээр дурдсанчлан Засгийн газраас Монгол улсын Хөнгөн аж үйлдвэрийг 2016 он хүртэл хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд Төр хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжих “Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэл”-ийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа нь тус салбарт ихээхэн хүлээлт, боломжийг үүсгээд байна.

Иймээс цаашдаа аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт хийж, хамтран ажилласнаар дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар өндөр өгөөж хүртэх боломжтой гэдэг нь харагдаж байгаа юм.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№01

## 1.2. АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ:

Компанийн андеррайтерийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд дараах 2 чиглэлийг баримтлан ажиллана.

| | |
|---|---|
| **ЧИГЛЭЛ-1:** | Шинээр төсөл хүлээн авах үйл ажиллагааг дэмжих, |
| **ЧИГЛЭЛ-2:** | Сонгон ажиллаж буй төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор firm commitment, stand by commitment хэлбэрээр анхдагч зах зээлийн борлуулалтанд оролцох. |

**АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ-1: Шинээр төсөл хүлээн авах үйл ажиллагааг дэмжих**

"БиДиСЕК" ХК нь Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийн хүрээнд жил бүр санхүүжилт шаардлагатай олон тооны төслийг хүлээн авч, зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн хамтран ажилладаг. Тухайлбал 2010-2013 онуудад нийт 139 төсөл хүлээн авч, хөрөнгө оруулалт татах боломжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллан, тэдгээрээс 2013-2014 онд тодорхой тооны төслүүдэд шаардлагатай санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Дунд хугацаанд шинээр томоохон хэмжээний 10 гаруй төсөлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлж, хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийг татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**Монголын аж ахуй нэгжүүдийн мэдээлэл:**
Татварын ерөнхий газраас гаргасан "Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлсөн аж ахуйн нэгж"-ийн статистик мэдээллээс харахад 2001 онд Монгол улсад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) төлөгч 19,296 ААН байсан бол 2012 онд энэ тоо 78,741 болж 4 дахин нэмэгдсэн байна.

2012 оны байдлаар Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газраас гаргасан "Улсын хэмжээний аж ахуйн нэгж, байгууллагын 2007-2012 оны санхүүгийн тайлангийн нэгтгэл"-д тусгаснаар Аж ахуйн нэгж байгууллагыг хариуцлагын хэлбэрээр харуулвал: Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) нь нийт ААН-ийн 86.0%-ийг эзэлж байгаа бол Хувьцаат компани дөнгөж 0.5%-ийг эзэлж байна.

Татварын ерөнхий газрын статистик тоон мэдээллээс харахад 2012 оны байдлаар нийт аж ахуйн нэгжийн 76.2% нь Улаанбаатар хотод, 23.4% нь орон нутагт бүртгэлтэй байна.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



График 29. Аж ахуйн нэгж(ААН)-үүдийн ангилал

**ААН, хэлбэрээр, 2012**




**ААН, байршилаар, 2012**




**ААН, Нийт хөрөнгийн хэмжээгээр, 2012**




**ААН, БО-оор, 2012**




*Эх сурвалж: Татварын ерөнхий газар, Сангийн яам*

Аж ахуйн нэгж (ААН)-үүдийг хөрөнгийн түвшингээр ангилан харахад нийт аж ахуйн нэгжийн 81.0% нь 100 сая төгрөг хүртэлх хөрөнгөтэй байгаа бол 11.5% нь 100.0-500.0 сая төгрөг, 2.6% нь 500.0-1000.0 сая төгрөг, 4.9% нь 1.000 сая төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгөтэй байна.

Орлогын түвшингээр ангилвал 2012 оны байдлаар нийт ААН-ийн 85.5 хувь нь 100.0 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой байгаа бол 8.8% нь 100.0-500.0 сая төгрөг, 2.2% нь 500.0-1000.0 сая хүртэл, 3.5% нь 1.000 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлого бүхий ААН-үүд эзэлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дээрх графикаас харна уу.

2010 оны байдлаар нийт ААН-ийн тоонд 1 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой ААН-ийн эзлэх хувь хэмжээ бага байгаа хэдий ч, 1 тэрбумаас дээш орлоготой ААН-ийн тоо 2001 онд 262 байсан бол 2010 онд 1,364 болж 5.2 дахин нэмэгдсэн байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 32. Орлогын түвшингээр ангилсан ААН-үүдийн тоо (төгрөг)

| Орлогын түвшин | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0-1 сая | 8082 | 8349 | 10326 | 11464 | 12807 | 15712 | 20444 | 22443 | 28647 |
| 1-2 сая | 1350 | 1507 | 1575 | 1679 | 1669 | 1684 | 1611 | 1762 | 1844 |
| 2-3 сая | 985 | 1082 | 1144 | 1288 | 1387 | 1386 | 1310 | 1498 | 1449 |
| 3-5 сая | 1325 | 1507 | 1719 | 1893 | 1986 | 2118 | 2172 | 2405 | 2354 |
| 5-10 сая | 2539 | 3254 | 3825 | 4456 | 4981 | 5467 | 5981 | 6180 | 6652 |
| 10-15 сая | 974 | 1085 | 1070 | 1192 | 1277 | 1377 | 1522 | 1567 | 1750 |
| 15-20 сая | 673 | 658 | 742 | 763 | 828 | 929 | 1039 | 1087 | 1192 |
| 20-50 сая | 1519 | 1717 | 1774 | 1948 | 2194 | 2740 | 3073 | 3422 | 3861 |
| 50-100 сая | 797 | 812 | 1007 | 1095 | 1203 | 1477 | 2000 | 2062 | 2520 |
| 0.1-1 тэрбум | 1327 | 1425 | 1622 | 1813 | 2073 | 2611 | 3483 | 3555 | 4483 |
| 1-2 тэрбум | 120 | 145 | 179 | 191 | 237 | 307 | 436 | 449 | 609 |
| 2-3 тэрбум | 34 | 59 | 65 | 63 | 83 | 112 | 130 | 139 | 195 |
| 3тэмбумаас дээш | 108 | 123 | 150 | 174 | 222 | 288 | 405 | 413 | 560 |
| | **19833** | **21723** | **25198** | **28019** | **30947** | **36208** | **43606** | **46982** | **56116** |

*Эх сурвалж: Татварын ерөнхий газар*

Дараах графикт ААН-ийн тоо болон тэдгээрийн орлогын дүнг харуулсан бөгөөд 2002 оноос ААН-ийн тоо болон орлогын хэмжээ тасралтгүй өссөн байна. Нийт ААН-ийн борлуулалтын орлогын дүн 2002 онд 2 их наяд төгрөг байсан бол 2010 онд 16.2 их наяд төгрөг болж 8 жилийн хугацаанд 7.8 дахин нэмэгджээ.

График 30. Бүртгэлтэй ААН-ийн тоо, тэдгээрийн борлуулалтын орлогын дүн




*Эх сурвалж: Татварын ерөнхий газар*

Монгол улсын ААН-ын талаарх статистик мэдээллээс үзэхэд нийт аж ахуйн нэгжүүдийн нэлээдгүй хэсэг нь хөрөнгийн биржид хувьцаа гарган олон нийтэд бүртгэгдэх шалгуур үзүүлэлтийг хангах боломжтой байгаа нь Андеррайтерийн үйл ажиллагаа явуулах хангалттай зах зээл байна гэж ойлгож болно.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ-2: Сонгон ажиллаж буй төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор ахдагч зах зээлээс тодорхой түвшинд худалдан авалт хийх**

“БиДиСЕК” ХК нь хөрөнгийн зах зээлд олон жил ажилласан туршлага, үнэт цаасны андеррайтерийн туршлагадаа үндэслэн firm commitment [1], stand by commitment [2] хэлбэрээр компаниудад хөрөнгө оруулалт хийх нь тухайн компани, төслийг хөрөнгийн зах зээл дээрээс амжилттай санхүүжилт татах, IPO-г амжилттай болгоход чухал түлхэц болно гэж үзэж байна.

Манай компани 2008 онд “Хөх ган” ХК-ийн IPO-н андеррайтераар ажиллахдаа олон нийтэд санал болгон арилжаалсан хувьцаанаас stand by commitment хэлбэрээр хөрөнгө татах ажлыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн. Мөн түүнчлэн хөрөнгийн зах зээлд гарсан IPO-үүдийн талаас илүү хувьд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн, шаардлагатай санхүүжилтийг амжилттай татсан ба тэдгээр компаниудын хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа тогтвортой явагдаж байна.

***Firm commitment[1], Stand by commitment[2] хэлбэрээр хөрөнгө босгохын давуу тал:***

Манай улсад хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаа, хөрөнгө оруулагчдын бааз суурь хангалттай түвшинд хүрээгүй байгаагаас шалтгаалж дийлэнх компанид үнэт цаасаар бус, банкны зээлээр санхүүжиж байна.

Андеррайтерийн компаниуд Firm commitment болон stand by commitment-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр аж ахуйн нэгж, компаниуд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох сонирхол нэмэгдэх, ингэснээр хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасаа гарган арилжаалах компаниудын тоо өсөх, өндөр үр өгөөжтэй, сайн төслүүдийг хөрөнгийн зах зээлд оруулж ирэх нөхцөл бүрдэнэ. Энэ нь цаашдаа дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэсгэх, шинэ шатанд гаргах гол хөшүүрэг болох юм.

Сүүлийн жилүүдэд Монголын Хөрөнгийн Бирж дээр андеррайтерийн компани тухайн үнэт цааснаас худалдаж авахгүйгээр бүх хүчин чармайлтаар зарж борлуулах (Best Efforts) нөхцлөөр гаргасан IPO-уудаас амжилтгүй болох тохиолдол гарч байна. Иймд андеррайтер компани нь андеррайтераар ажиллаж буй үнэт цаасыг анхдагч зах зээл дээрээс бүхлээр нь болон хэсэгчлэн худалдан авсанаар эрсдэлийг бууруулж, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

[1]Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг хоёрдогч зах зээлд худалдах зорилгоор анхдагч зах зээл дээрээс бүхэлд нь худалдан авах нөхцөл,
[2]Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалаад үлдсэн хэсгийг худалдан авах нөхцөл,



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## II. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, АЖИЛЧДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР (ESOP) ХЭРЭГЖҮҮЛЭХ

### ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

Бид шинээр гаргаж буй хувьцаанаас компанийн боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулах зэргээр хүний нөөцийн бааз суурь, чадамжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.

Энэхүү ажлын хүрээнд:

- Компанийн удирдлага болон албадын менежерүүдийг менежмент, хөгжлийн гадаад, дотоодын сургалт, семинарт хамруулж мэргэжил дээшлүүлэх,
- Бусад мэргэжилтэн, боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх сургалт,
- Хүний нөөцийн бусад зардал

### АЖИЛЧДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

БиДиСЕК ХК-ийн удирдлага, албадын менежерүүд болон голлох мэргэжилтнүүдэд шинээр гарч буй хувьцаанаас тодорхой хэмжээгээр эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (ESOP)-ийг хэрэгжүүлснээр компанийн мэргэжилтэн, боловсон хүчин нь компанидаа тогтвор суурьшилтай, өндөр бүтээмжтэй ажиллахад түлхэц болно. Ингэснээр компанийн ашиг орлого өсөн нэмэгдэхээс гадна байгууллагын хамгийн чухал нөөц болох ажиллах хүчний чадвар чадамж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, мэргэжилтэн ажилчдын бие хүний хувьд өсөж хөгжих боломжийг олгох зэрэг давуу талууд бий болно.

Нэмэлтээр гарч буй хувьцаанаас компанийн удирдлага, албадын менежерүүд болон мэргэжилтнүүдэд 2011 оноос 2016 он хүртэл 5 жилийн хугацаанд нийт 564,050,000 төгрөгийн хувьцааг эзэмшүүлэхээр төлөвлөөд байна.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Орлогын төсөөлөл

### Андеррайтерийн үйл ажиллагааны орлого

"БиДиСЕК" ХК нь Монголын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал зэргээс үүдэн ирэх 3 жилд нээлттэй болон хаалттай хүрээнд татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлан гаргасан. 2014 онд нийт 90.6 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэнэ гэж үзсэн бөгөөд ингэхдээ 60%-ийг нь хувьцаагаар үлдэх 40%-ийг нь өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 33. Андеррайтерийн үйл ажиллагааны төлөвлөгөө

| | 2014 | 2015 | 2016 | Total |
|---|---|---|---|---|
| **Хувьцааны андеррайтер** | **52,000,000,000** | **80,568,299,700** | **136,681,959,640** | |
| IPO Investment | 5,000,000,000 | 39,168,299,700 | 47,001,959,640 | 91,170,259,340 |
| Pre IPO | 12,000,000,000 | 15,000,000,000 | 18,000,000,000 | 45,000,000,000 |
| Mid size IPO, FPO | 22,000,000,000 | 26,400,000,000 | 31,680,000,000 | 80,080,000,000 |
| BDS FPO | 13,000,000,000 | | | 13,000,000,000 |
| International IPO | | | 40,000,000,000 | 40,000,000,000 |
| **Өрийн хэрэгсэлд андеррайтер** | **38,600,000,000** | **43,600,000,000** | **59,800,000,000** | |
| Үл хөдлөх салбарт | 33,600,000,000 | 33,600,000,000 | 44,800,000,000 | 112,000,000,000 |
| Санхүүгийн салбарт | 5,000,000,000 | 10,000,000,000 | 15,000,000,000 | 30,000,000,000 |
| **Нийт дүн** | **90,600,000,000** | **124,168,299,700** | **196,481,959,640** | |

Энэхүү төсөөллийг гаргахдаа "БиДиСЕК" ХК-ийн хөрөнгө оруулалтын албанд байгаа төслүүдийн хүрээнд гаргасан бөгөөд санхүүжилт татан төвлөрүүлэх ажиллагаанууд хийгдэж байгаа болно.

Дээрх төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээр андеррайтерийн үйл ажиллагааны орлогын төсөөлөл дараах байдалтай гарч байна.

Хүснэгт 34. Андеррайтерийн үйл ажиллагааны орлогын төсөөлөл

| | 2014 он* | 2015 он* | 2016 он* |
|---|---|---|---|
| **Хувьцаагаарх** | | | |
| IPO Investment | 150,000,000 | 1,175,048,991 | 1,410,058,789 |
| Pre IPO | 480,000,000 | 600,000,000 | 720,000,000 |
| Mid size IPO, FPO | 660,000,000 | 792,000,000 | 950,400,000 |
| International IPO | - | - | 1,000,000,000 |
| **Нийт** | **1,290,000,000** | **2,567,048,991** | **4,080,458,789** |
| **Өрийн хэрэгсэл** | | | |
| Үл хөдлөх салбарт | 840,000,000 | 840,000,000 | 1,120,000,000 |
| Санхүүгийн салбарт | 125,000,000 | 250,000,000 | 375,000,000 |
| **Нийт** | **965,000,000** | **1,090,000,000** | **1,495,000,000** |
| **Нийт орлого** | **2,255,000,000** | **3,657,048,991** | **5,575,458,789** |



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Брокерын үйл ажиллагааны орлого

Брокерын үйл ажиллагааны орлогыг төсөөлөхдөө одоо байгаа зах зээлийн арилжаа, шинэ бүтээгдэхүүн зах зээлд гарах, түүнд брокерын үйлчилгээг үзүүлэх гэсэн хэсгүүдээр төсөөлөл гаргасан.

Хүснэгт 35. МХБ-ийн сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны хэмжээ

| | 1 талдаа | 2 талдаа | Арилжааны өсөлт | 5 жилийн дундаж |
|---|---|---|---|---|
| 2009 | 23,181,478,462 | 46,362,956,924 | -62% | |
| 2010 | 62,873,141,553 | 125,746,283,106 | 171% | |
| 2011 | 109,110,768,611 | 218,221,537,222 | 74% | |
| 2012 | 144,746,456,537 | 289,492,913,074 | 33% | |
| 2013 | 97,586,865,645 | 195,173,731,290 | -33% | 36.7% |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

2014 оны биржийн арилжааны хэмжээг 2013 оны арилжааны хэмжээгээр авч, 2015 болон 2016 оныг сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөр өсгөн төсөөлсөн. Үнэт цаас гаргагчийн өмнөх жилүүдийн гүйцэтгэлийн дундажаар арилжаанд эзлэх хувиа тогтмолоор авсан.

Хүснэгт 36. Брокерийн үйл ажиллагааны орлогын төсөөлөл

| | 2014 он* | 2015 он* | 2016 он* |
|---|---|---|---|
| **Зах зээлийн төсөөлөл** | | | |
| Нийт зах зээлийн арилжааны хэмжээ (2 талдаа) | 195,173,731,290 | 266,706,474,867 | 364,456,544,770 |
| Гүйцэтгэх төсөөлөл | 56% | 56% | 56% |
| БиДиСЕК - н арилжааны хэмжээ | 109,037,057,881 | 149,000,017,292 | 203,609,723,011 |
| Шинэ бүтээгдэхүүн | 40,000,000,000 | 65,568,299,700 | 78,681,959,640 |
| Анхдагч зах зээлийн арилжаа 50% | 20,000,000,000 | 32,784,149,850 | 39,340,979,820 |
| Хоёрдогч зах зээлийн арилжаа 10% | 4,000,000,000 | 6,556,829,970 | 7,868,195,964 |
| **Орлогын төрөл** | | | |
| Хоёрдогч зах зээлийн арилжаанаас олох орлого | 2,260,741,158 | 3,111,136,945 | 4,229,558,380 |
| Анхдагч зах зээлийн арилжаанаас олох орлого | 200,000,000 | 327,841,499 | 393,409,798 |
| **Брокерын үйл ажиллагааны орлого** | **2,460,741,158** | **3,438,978,444** | **4,622,968,178** |

*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*

## Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлого

Компани өөрийн хөрөнгөөр нээлттэй болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулалт хийн ашиг олох үйл ажиллагааны орлого энэ хэсэгт хамаарна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлогын хувьд сүүлийн 5 жилийн дунджаар компани нийт эргэлтийн хөрөнгийн 83%-ийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулан,

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



жил бүр дунджаар 34%-ийг арилжаалан орлого олж, үүний 76% нь өртөг, 24% нь ашиг байсан байна. Иймд бид ирэх жилүүдийн төсөөллийг гаргахдаа тус хувийг хадгална гэж үзсэн.

Нэмэлт хувьцаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын 94% нь компанийн эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдэн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулагдана. 2014 оны хувьд нэмэлт хувьцааны хөрөнгөөс 30%-ийг хөрөнгө оруулалтаар байршуулах боломжтой гэж үзэн хөрөнгө оруулалтын орлогод, үлдсэн хэсгээс арилжааны банкны хадгаламжийн хүүгээр тооцон хүүгийн орлогыг үндсэн бус үйл ажиллагааны орлогод нөлөөлүүлсэн.

Хүснэгт 37. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлогын төсөөлөл

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Хөрөнгө оруулалтын орлого | 1,575,388,478 | 941,839,739 | 2,935,317,086 | 5,157,605,086 | 5,312,333,238 |
| Эргэлтийн хөрөнгө | 5,986,559,167 | 6,244,515,452 | 17,830,515,452 | 18,365,430,915 | 18,916,393,843 |
| Хувьцааны санхүүжилт | | | 11,586,000,000 | | |
| Хөрөнгө оруулалт | 4,420,241,586 | 4,129,218,132 | 8,634,134,298 | 15,170,918,051 | 15,626,045,593 |
| % ХО/ЭХ | 73.84% | 66% | **83%** | | |
| % Орлого/ХО | 35.64% | 23% | **34%** | | |

## Нэгтгэсэн орлогын тайлан

Хүснэгт 38. Орлогын нэгтгэсэн төсөөлөл

| Үзүүлэлт | 2014 он* | 2015 он* | 2016 он* |
|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **7,959,441,622** | **12,600,003,370** | **15,899,989,643** |
| Андеррайтер | 2,255,000,000 | 3,657,048,991 | 5,575,458,789 |
| Брокер | 2,460,741,158 | 3,438,978,444 | 4,622,968,178 |
| Дилер (Хөрөнгө оруулалт) | 2,935,317,086 | 5,157,605,086 | 5,312,333,238 |
| ХОЗҮ | 142,982,668 | 164,430,068 | 189,094,578 |
| Түрээс | 165,400,711 | 181,940,782 | 200,134,860 |
| **Борлуулалтын орлогын дүн** | **7,959,441,622** | **12,600,003,370** | **15,899,989,643** |
| ББӨ | 2,318,900,498 | 4,074,508,018 | 4,196,743,258 |
| **Нийт ашиг /алдагдал/** | **5,640,541,124** | **8,525,495,352** | **11,703,246,385** |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 3,317,340,572 | 4,395,898,088 | 5,764,826,176 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/** | **2,323,200,552** | **4,129,597,264** | **5,938,420,209** |
| Хүүгийн орлого | 243,306,000 | 72,991,800 | 21,897,540 |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн | 153,561,991 | 46,068,597 | 13,820,579 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/** | **2,476,762,543** | **4,175,665,862** | **5,952,240,788** |
| Орлогын татварын зардал | 247,676,254 | 593,916,465 | 1,038,060,197 |
| **Татварын дараах ашиг /алдагдал/** | **2,229,086,289** | **3,581,749,396** | **4,914,180,591** |
| Нийт гаргасан хувьцааны тоо | 17,000,000 | 17,000,000 | 17,000,000 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг /EPS/ | 131.12 | 210.69 | 289.07 |



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

"Үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна."

Компани нь үйл ажиллагаагаа амжилттай удирдан явуулах, компанид нөлөөлж болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, удирдах буюу эрсдэлийг бууруулах арга замыг хэрэгжүүлэх нь өнөөгийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хувьсамтгай байдал, мөн гадаад зах зээлийн нөлөөлөл их байгаа үед эрсдэлийн шинжилгээ хийж учирч болзошгүй эрсдэлийг тооцоолж, үйл ажиллагаандаа удирдах нь нэн шаардлагатай юм. Компанийн хувьд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг дараах хэсгээс уншина уу.

### Эрсдэлийн хүчин зүйлс

#### Зах зээлийн болон үнэт цаас гаргагчийн бизнестэй холбоотой эрсдэл

Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ ДНБ-нд эзлэх хувь хэмжээ, үнэт цаасны арилжааны үнийн дүн бага байгаа учир зах зээл дээрх ханшийн савлагаа өндөр байдаг. Иймд бүтээгдэхүүн үйлчилгээний болон санхүүгийн салбарт гарсан бууралт, хямрал нь хөрөнгийн зах зээлийн уналтанд нөлөөлж улмаар компанийн оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж буурах, зах зээлд оролцогчдын оролцоо буурснаар компанийн үйл ажиллагааны орлого, ашигт байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

График 31. Үнэт цаасны арилжааны дүн




*Эх сурвалж: МХБ, БиДиСЕК ХК*



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Дээрх графикт 2006-2013 оны үнэт цаасны арилжааны үнийн дүн болон үнэт цаасны хэмжээг ДНБ-нд харьцуулсан харьцааг харуулав. Графикаас харахад үнэт цаасны арилжааны хэмжээ нэлээд өөрчлөлтэй байсан. Тухайлбал, ДНБ-тэй харьцуулсан үнэт цаасны арилжааны хэмжээ 2007 онд 1,3% байсан бол 2008-2009 оны хооронд болсон олон улсын эдийн засгийн хямралаас шалтгаалан 0,4% хүртэл огцом буурч байсан.

Компани үнэт цаас гарган нэмэлт санхүүжилт татах бөгөөд санхүүжилтийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаар өргөтгөхөд зарцуулна. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтанд нөлөөлөх мэдээлэл судалгаа дутуу хийгдсний улмаас оновчгүй хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэх улмаар алдагдалд хүрэх эрсдэлтэй.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин өндөр буюу 2011 онд 10,2%, 2012 онд 14%, 2013 онд 12,5% -тай байсан байна. Иймд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан компанийн хөрөнгө оруулалт хийсэн компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа уртсах талтай. Иймд хөрөнгө оруулалтын хийхдээ хөрөнгө оруулалт хийх гэж буй компанид учир болох эрсдэлийг нарийн судлах, хөрөнгө оруулалтын тооцоолол, шаардлагатай хөрөнгө оруулалт зарцуулалтад хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагаанд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, валютын ханшийн өсөлт хэрхэн нөлөөлөх талаар нарийн судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг хийнэ. Мөн тэргүүлэх чиглэлийн салбарт хөрөнгө оруулалтын гол анхаарлыг хандуулна.

График 32. Инфляцийн түвшин, хувиар




*Эх сурвалж: ҮСХ, Монголбанк*

**Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбоотой үүсч болох эрсдэл**

Монголын хөрөнгийн зах зээл нь 1991 оноос төрийн өмчид компаниудыг хувьчилж, 1995 онд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээр хөгжих эхлэл тавигдсан. 2000 онд засгийн газрын бонд, 2001 онд компанийн бонд, 2005 онд шинээр хувьцаа гарган олон нийтээс санхүүжилт татаж (IPO) эхэлсэн. 2005 оноос хойш нийт 18 компани хувьцаа гарган арилжаалахаар зөвшөөрлийг СЗХ-ноос авсан байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2006, 2007, 2008 онуудад шинээр хувьцаа гаргах ажлууд эрчимжиж IPO амжилттай болж шаардлагатай санхүүжилтийг татаж байсан бол 2008 оны 3-р улирлаас эхлэн дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас үүдэн хөрөнгө оруулалт буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа татаж эхэлсэн бөгөөд 2008 оны 8 сараас хойш хувьцаа гаргахаар ажиллаж байсан "Монфреш шүүс" ХК-ийн IPO амжилтгүй болсон. Иймээс гадаад дотоодын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, гадны улс орны эдийн засгийн байдал, түүхий эдийн ханшийн уналт зэргээс үүдэн шинээр гаргаж буй хувьцааны үнэ ханш, борлогдох байдалд нөлөөлөх эрсдэлтэй байна.

Компанийн нэмж гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахдаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгон үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгон арилжаална. Хэрэв тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгох үед худалдан авах эрэлт үүсээгүйгээс төлөвлөсөн хөрөнгө бүрэн татан төвлөрөхгүй, компани төлөвлөж буй үр өгөөждөө хүрэхгүй байх, нэмэлт хувьцаа гаргах асуудал амжилтгүй болох эрсдэлтэй.

### Хууль эрх зүйн эрсдэл

Монгол Улсын хууль эрх зүйн орчин өөрчлөгдсөнөөр гадаадын хөрөнгө оруулалтын өсөлтөнд сөргөөр нөлөөлж улмаар хөрөнгийн зах зээлд оролцогч гадаадын хөрөнгө оруулагчдын идэвхи оролцоо буурснаар үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого буурах эрсдэлтэй. Ялангуяа Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн багтаамжийн дийлэнх хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарт улс төрийн зохицуулалт их байдаг нь тус салбарт хөрөнгө оруулагчдын идэвхийг бууруулах эрсдэлтэй.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль, "Компанийн тухай" хууль, "Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай" хууль, "Иргэний хууль", "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх гол хуулийн нэг болох Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013 оны 5 дугаар сарын 24-нд шинэчлэн батлагдан бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдөж эхэлсэн. Хуульд нийцүүлэн дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр журмуудыг батлаж байна. Шинээр боловсруулагдах журмын шалгуур шаардлага өндөр байх, журам батлагдахгүй удах, шимтгэл хураамжийн зардал нэмэгдэх зэрэг эрсдэл үүсч болзошгүй.

### Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл

"БиДиСЕК" ХК нь хөрөнгийн зах зээл дээр брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг цогцоор нь эрхлэн явуулдаг.

*Брокерийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой эрсдэл*



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ



"БиДиСЕК" ХК нь 2004 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны дийлэнх хувийг дангаараа гүйцэтгэж ирсэн ба нийт дотоод харилцагчдын 22 хувь, гадаад харилцагчдын 46 хувь, нийт 169 орчим мянган харилцагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Брокерийн үйлчилгээг харилцагчддаа хүргэх, харилцагчдыг түргэн шуурхай мэдээ, мэдээллээр хангах, чанартай түргэн шуурхай үйлчлэхээр дараах ажлыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Арилжааны танхимыг байгуулсан. Арилжаа заалыг байгуулснаар харилцагчдад арилжааны цагаар буюу 10 цагаас 13 цагийн хооронд уг танхимд ирж, дэлгэцээр арилжаа хэрхэн явагдаж байгааг харж, бодит цагийн горим буюу арилжааны дундуур өөрийн захиалгыг өгч, арилжаанд оролцох боломжоор хангасан. Уг заалаар өдөрт дундажаар 10-20 хүн үйлчлүүлж байна.
- Тел-е үйлчилгээ. Ажил ихтэй буюу цаг зав муутай харилцагчдад зориулсан үйлчилгээ юм.
- Арилжааг гар утаснаасаа. Мобайл төхөөрөмжид зориулсан вэб. Энэ нь гар утаснаасаа арилжааны талаар мэдээллийг харах боломжоор хангасан. www.m.bdsec.mn
- Байгууллагын харилцагчийн салбар нээсэн. Энэхүү салбараар дамжуулан хувьцаат компаниудад зөвлөхийн үйлчилгээг хүргэж байна. Хувьцаат компаниудад хэрэгтэй, тэнд тулгамдаж буй асуудалд зөвлөх, хувьцаат компанийн хурлыг зохион байгуулах, дүрэм журам боловсруулахад зөвлөх, тендер санал зарлах, хувьцаат компаниас хязгаарлагдмал хариуцлагатай компани болох зэрэгт зөвлөн, хамтран ажиллахаас гадна харилцагчдад зориулсан сургалт зохион байгуулж байна.
- Хөдөө орон нутгийн иргэд хүрч үйлчлэх, хөрөнгийн зах зээлд оролцох боломжоор хангах үүднээс салбаруудыг нээн ажиллуулж байна.

Өнөөгийн хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн ажиллах, техник технологи, программ хангамжыг сайжруулж, нэмэгдүүлэх, мэргэжлийн чадварлаг мэргэжилтнүүдийг бий болгохтой зэрэгцэн брокерын үйлчилгээг чанаржуулж, сайжруулахаар чармайн ажиллаж байна.

Брокер, дилер, мэргэжилтнүүдийн санамсаргүй, хайхрамжгүй алдаанаас харилцагчдаа хохирол учруулах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай журмуудыг чанд мөрдөн ажиллаагүйгээс, мөн харилцагчдаа дутуу танин мэднээс үүдэн тэдгээрийн хүсч буй үйлчилгээг хүргэж чадахгүй байх зэргээс харилцагчдынхаа итгэлийг нь алдах, улмаар компанийн нэр хүнд болон санхүүгийн үзүүлэлтэнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

"БиДиСЕК" ХК нь өөрийн үндсэн харилцагчдаас гадна "Түмэн бул" брокер, дилерийн компани, "Эрдэнэст" брокер дилерийн компанийн харилцагчдад үйлчилж байна. Дээрхи 2 компаниудын харилцагчдаас үнэт цаасыг зарж борлуулж хохироосон гэх өргөдөл, гомдлыг нилээдгүй гаргадаг. "Түмэн бул", "Эрдэнэст" брокер дилерийн

100
СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

компанийн удирдлага, ажилчид нь харилцагчдаа хохироосон асуудал нь манай компанийн нэр хүнд болон санхүүд нөлөөлөх эрсдэлтэй байдаг.

“БиДиСЕК” ХК нь 9 салбар нэгжтэй бөгөөд Улаанбаатар хотод 1 салбар, хөдөө орон нутагт 8 салбартай. Салбар нэгжүүдээр дамжуулан хөдөө орон нутгийн иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцох боломжоор хангаан ажиллаж байна. Салбар бүр шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж, утас, интернетэд холбогдсон бөгөөд харилцагч, үйлчлүүлэгч нар мэдээллийг түргэн шуурхай авах боломжоор хангагдсан. Салбарт ирж үйлчлүүлж буй иргэд шинээр данс нээлгэх, мөнгө хүсэх, арилжааны данс нээлгэх тохиолдолд баримт материал Улаанбаатар хотын төв оффист 3-7 хоногт материалыг хүлээн авч үйлчилж байна. Баримт материалыг төв оффис руу шуудангаар илгээдэг. Шуудан үйлчилгээтэй холбоотой ямар нэг асуудал өмнө нь үүсч байгаагүй хэдий ч ирээдүйд шуудангийн үйлчилгээтэй холбоотой эрсдэл үүсэхгүй гэсэн баталгаа байхгүй.

*Дилерийн үйл ажиллагааны эрсдэл*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд “өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдан авах ажиллагааг үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа гэнэ” гэж заасан байдаг.

Компани өөрийн нэр дээр арилжаанд оролцох дилерийн үйл ажиллагаа эрхлэдэг бөгөөд судалгаа шинжилгээ дутуу хийн, хөрөнгө оруулалтын буруу тооцоолсноор эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийх нь компанийн санхүүгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

*Хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой эрсдэл*

Компани нь хуучинаар Үнэт Цаасны Хорооны 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч Монголын анхны андеррайтерийн компани болсон юм.

2007 онд Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ явуулах эрхийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан юм. Ингээд санхүү эдийн засгийн хямралтай байсан 2008 оноос эхлэн албан ёсоор үйлчилгээгээ эхэлж, иргэд байгууллагуудад хэрхэн өөрийн хөрөнгөө үр ашигтай зарцуулах, шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтаа хэрхэн олох, хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт босгох, үнэт цаас гаргах зэрэг нэн шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг олгож эхэлсэн.

Хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гарган санхүүжилт татан төвлөрүүлэх компаниудад хийгдэх судалгаа, үнэлгээ дутуу хийгдэх, буруу зөрүүтэй мэдээлэл дээр үндэслэн мэдээлэл, судалгаа боловсруулагдах, түүнчлэн тухайн компанийн үйл ажиллагаа хэтийн төлвийг дутуу судлан буруу дүгнэлт гаргах, үнэт цаас гаргах компаниа бүрэн дүүрэн танин мэдээгүйгээр үнэт цаас гаргах нь улмаар хөрөнгө оруулагчид хохироох болон компани санхүүгийн эрсдэлтэй байдалд орох, компанийн нэр хүнд унах



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



эрсдэлтэй. Үнэт цаас гарган санхүүжилт татсан компанийн үйл ажиллагаа доголдох, татан буугдах, дампуурах улмаар хөрөнгө оруулагчдад хохирол учрах нь андеррайтер хийсэн компанийн нэр хүндийг унагаах эрсдэлтэй.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтераас гадна аудит, хууль, үнэлгээний мэргэжлийн байгууллагууд оролцдог ба эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа, гаргасан дүгнэлт нь үнэн бодит мэдээлэл дээр тулгуурласан, хөндлөнгийн хяналт шалгалт хэр хийгдсэн гэдгээс хамаарч, үнэт цаас борлогдох цаашлаад үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаа,андеррайтерийн компанийн нэр хүндэд эрсдэл үүсэх талтай юм.

**Үйл ажиллагаанд нөлөөлөх талтай бусад эрсдэл**

Санаатай болон санамсаргүйгээр харилцагчдын нууц мэдээлэл болон бусад дотоод мэдээллийг бусдад задруулснаар компанид итгэх харилцагчдын итгэл буурах, нэр хүндээ алдах эрсдэлтэй

Томоохон өрсөлдөгчид зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр, харилцагчдаа бусад компаниудад алдах эрсдэлтэй. Харилцагчдын бааз суурия алдсанаар компанийн зах зээлд эзлэх байр суурь багасан компанийн санхүүгийн болон бизнесийн үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хурдацтай хөгжлийг даган байгууллагын боловсон хүчний чадвар, техник программын шинэчлэл бусад шаардлагатай сайжруулалт шинэчлэлийг хийгээгүйгээс компанийн зах зээлд эзлэх байр суурь буурах эрсдэлтэй.

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага болох үнэт цаас гаргагч компанийн хувьд дотоод үйл ажиллагаанаас гадна хамтарч ажиллаж буй зохицуулагч байгууллага, арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, төлбөр тооцооны банк зэрэг байгууллагуудын гаргасан шийдвэрүүд нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх талтай.

Эрсдэлийг бууруулах, эрсдлээс хамгаалах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Мэргэжилтнүүдийг хариуцлагын даатгалд хамруулна,
- Компанийн дотоод журмыг чанд мөрдөн ажиллах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөхийг шаардах, нууцлалын гэрээ байгуулах,
- Мэргэжилтнүүдийн ажиллах ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрийн сурахыг хүсч буй сургалтанд хамруулах, мэргэжлийн сургалтанд суралцах боломжийг олгох
- Due diligence хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох,
- Дотоод хяналтын нэмэгдүүлэх, нэмэлт боловсон хүчин бэлтгэх,



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогддог брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх гэсэн 3 тусгай зөвшөөрлийг хүрээнд үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" шинэчлэн батлагдсантай холбоотой Санхүүгийн Зохицуулах Хорооноос "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ыг шинэчлэн 2013 оны 12 сарын 12-ны өдөр баталсан билээ. Хуучин журмаар тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгодог, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар 3 жил тутамд тусгай зөвшөөрлөө сунган ажилладаг байсан бол энэ оноос зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаагаа байнгын, тогтвортой, тасралтгүй явуулахаар журамласан.

2002 оны 12 сарын 12-нд батлагдсан хуучин "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуульд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зааж өгсөн байдаг. Үүнд:

- Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө хэмжээ 50 сая төгрөгөөс доошгүй,
- Андеррайтер үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 200 сая төгрөг,үүнээс мөнгөн болон түргэн борлогдох эргэлтийн хөрөнгө нь 100 сая төгрөгөөс доошгүй байна гэж заасан байсан.

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмаар зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлт

- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг
- Брокерын үйл ажиллагаа- 200,0 сая төгрөг
- Дилерийн үйл ажиллагаа – 300,0 сая төгрөг
- Андеррайтерийн үйл ажиллагаа – 1,000.0 сая төгрөг болж тус тус өөрчлөгдөж байна.

Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг 2014 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. *(СЗХ-ны даргын тогтоолоор 2015 оны 7 дугаар сарын 1-ийг хүртэл хойшлуулаад байна)*

Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,100.0 сая төгрөг байгаа бөгөөд нэмж гаргаж буй 6 сая ширхэг хувьцааг гаргаснаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,700.0 сая төгрөг хүрч, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангана. Гаргаж буй үнэт цаасыг борлуулж чадаагүй тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг бүрдүүлж чадахгүй нөхцөл байдал үүсч зөвшөөрлүүдээс зарим нь цуцлагдах эрсдэлтэй. Иймд нэмж гаргах буй 6 сая ширхэг хувьцааны 83.5% борлогдсоноор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.6 тэрбум төгрөг болж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангана.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 506 тоот тогтоолын хавсралт буюу үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журамд дараах

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01


тохиолдолд зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохоор заасан байна.

Дараах үндэслэлээр түтгэлзүүлнэ:

1. Нэг жилийн хугацаанд арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлд элсээгүй
2. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохирч болзошгүй нөхцөл байдал үүссэн,
3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон,
4. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр дараалан хангаж ажиллаагүй,
5. Хагас болон жилийн санхүүгийн тайлан тэнцлийг холбогдох тодруулгын хамт ирүүлээгүй,
6. Хорооноос мэдээллийн сангийн журмын дагуу шаардсан мэдээллийг удаа дараа хугацаанд гаргаж өгөөгүй болон алдаатай, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн,
7. Хорооны 2007 оны 156 дугээр тогтоолд заасан зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлс төлөх хугацааг нэгээс дээш сараар хэтрүүлсэн,
8. Зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд биш болсон,
9. Хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар үнэт цаасны арилжаа эрхлэх болон үнэт цаасны хадгаламжийн байгууллага, бусад эрх бүхий өөрийгөө зохицуулагч байгууллагаас үндэслэл бүхий хүсэлт гаргасан,
10. Журмын 1.7, 1.8 –д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй (1.7. Энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй хэд хэдэн үйл ажиллагааг нэг зохицуулалттай этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлж тооцно. 1.8. Зохицуулалттай этгээд нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэх бөгөөд эдгээрээс өөр төрлийн үйл ажиллагаа давхар эрхлэхийг хориглоно,
11. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу өгсөн даалгаварыг биелүүлээгүй,
12. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

Тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтээ Хороонд ирүүлнэ. Хорооноос тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлсэн шалтгааныг арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрлийг сэргээх бөгөөд хэрэв тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хүсэлт ирүүлээгүй тохиолдолд Ажлын алба тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар Хорооны худалдаанаар хэлэлцүүлнэ.

Дараах тохиолдолд хүчингүй болгоно:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан,
2. Зохицуулалттай этгээд дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болж татан буугдах тухай эрх бүхий байгууллага болох шүүх, зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан,



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

3. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад харшлах бусад нөхцөл байдал үүссэн,
4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаж, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд ирүүлээгүй,
5. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.

Компани дээр дурьдсан шалгууруудыг хангаж ажиллаагүйгээс тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох эрсдэлтэй. "БиДиСЕК"ХК нь "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай" журмыг чанд баримтлан үйл ажиллагааг эрхлэн явуулах ба өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай" журмыг чанд баримтлан үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байсан. Өмнө нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож байсан удаагүй болно.

**Компанийн гүйцэтгэх удирдлага, хяналтын багц эзэмшигчдийн шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл**

Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллаж байна. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу гүйцэтгэх удирдлага нь өмнөх улирлын балансын нийт активын 25 хувьтай тэнцэх дүнгээр өөрийн эрх мэдлийн хүрээнд бие даан шийдвэр гаргах, гэрээ хэлцэл хийн компанийн өмчийг захиран зарцуулах эрхтэй.

Гүйцэтгэх удирдлагын эрх мэдлээс давсан асуудлыг Компанийн тухай хууль, компанийн дүрэм, бусад холбогдох журмуудад нийцүүлэн ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан шийдвэрлэдэг.

Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу хяналтын багц эзэмшигчид нь бусад хувьцаа эзэмшигчдийн адил хувьцаа эзэмшигчдийн хуралд эзэмшиж буй хувьцааны тоогоор саналын эрх эдлэж, санал өгөх, компанийн ТУЗ-д нэр дэвших болон өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх эрхтэй.

Үнэт цаас гаргагч компанийн хувьд одоогоор хяналтын багц эзэмшигч буюу 33.3%-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч байхгүй. 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 5-аас дээш хувийн хувьцааг дараах хөрөнгө оруулагчид эзэмшиж байна.

Хүснэгт 39. 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Хувь хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Alexander Zwahr | 3,080,500 | 28% |
| 2 | Firebird GM 2 S.A.R.L | 1,054,301 | 9,58% |
| 3 | Firebird MF holding 2 S.A.R.L | 576,276 | 5,24% |
| 4 | Д.Даянбилгүүн | 2,704,251 | 24,58% |

*Эх сурвалж: Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл*

105
СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

Компанийн тухай хуулийн дагуу жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, ТУЗ-ийн гишүүдийг сонгодог бөгөөд ТУЗ-д 3 хараат бус гишүүн ажиллаж байна. ТУЗ –ийн үйл ажиллагааны журмын дагуу ТУЗ-ийн хурал улирал 1-ээс доошгүй удаа хуралдаж байна. Гүйцэтгэх удирдлагын ирүүлсэн саналын дагуу ТУЗ хуралдан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, хэлэлцүүлэн шийдвэрлэж байна.

**Компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн компаниудад тавьдаг хүчин төгөлдөр үйлчилж буй шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувиар эрсдэлийн сан бүрдүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 40. Зохистой харьцааны шалгуур, 2013.12.31-ний өдрийн байдлаар

| Үзүүлэлт | Хүчин төгөлдөр үйлчилж буй шалгуурууд | БиДиСЕК ХК-ийн хувьд | | Шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх |
|---|---|---|---|---|
| | | Брокер, дилерийн үйл ажиллагаа | Андеррайтерийн үйл ажиллагаа | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | Брокер дилерийн үйл ажиллагаа 50,000,000 төгрөг, Андеррайтерийн үйл ажиллагаа 200,000,000 төгрөгөөс дээш. | "БиДиСЕК " ХК нь 1.1 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй. | | Хангасан |
| Эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь | Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаас доошгүй хувийг мөнгөн хөрөнгө, Монголын хөрөнгийн биржийн "А" ангилалд хамаарах үнэт цаасаар бүрдүүлнэ. Үнэт цаас нь эргэлтийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байна. | 6,244,515 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй | | Хангасан |
| | | | 4,954,074 мянган төгрөгийн /мөнгө болон түргэн борлогдох/ эргэлтийн хөрөнгийн хэмжээтэй байна. | Хангасан |
| Эрсдэлийн сан | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хэмжээгээр байгуулах | 33,000 мянган төгрөг байршуулсан | | Хангасан |
| Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт | Орлого | 2,114,898.8 мянган төгрөг | 206,832.5 мянган төгрөг | Хангасан |
| | Зардал | 311,961 мянган төгрөг | | |
| | Ашиг /алдагдал (Үр ашигтай ажиллах) | 287,883 мянган төгрөг | | |

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хариуцлага, санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн бөгөөд 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх юм.

2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр СЗХ-ны 506 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 8-р хавсралтаар зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг дараах байдлаар тогтоосон.

1) Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг,
2) Брокерийн үйл ажиллагаа – 200.0 сая төгрөг,
3) Дилерийн үйл ажиллагаа – 300.0 сая төгрөг,
4) Андеррайтерийн үйл ажиллагаа – 1,000.0 сая төгрөг

"БиДиСЕК" ХК нь нэмэлт үнэт цаас гарган арилжаалах хэлбэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлснээр шинээр тавигдаж буй тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангах боломж бүрдэх юм.

Гэсэн хэдий ч цаашид тусгай зөвшөөрлийн шалгуур шаардлагыг хангахгүй болсон, Хорооноос тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийн шаардлагыг хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр дараалан хангаж ажиллаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх эрсдэлтэй. Иймд дээрх эрсдэлд орохгүйн тулд үйл ажиллагаандаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг чанд мөрдөн ажиллах шаардлагатай юм.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 41. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

| № | ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ | ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|---|---|
| **Гадаад хүчин зүйлийн эрсдэл**<br>*Компани нь гадаад хүчин зүйлээс хамааралтай эрсдэлийг бүрэн удирдан чиглүүлэх боломжгүй тул уг хүчин зүйлээс хамаарсан эрсдэл учрахаас зайлсхийх, урьдчилан сэргийлэх бодлогыг эрсдэлийн удирдлагад баримталж ажиллана.* | | | |
| 1 | Зах зээлийн болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбартай холбоотой эрсдэл | - Хөрөнгө оруулалтыг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу зарцуулах, | Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан тэргүүлэх чиглэлийн салбарт хөрөнгө оруулалтын гол үйл ажиллагааг чиглүүлэх ба хөрөнгө оруулалт хийх салбаруудын иж бүрэн судалгааг хийгээд байна. |
| | | - Эрсдэлийн судалгааг нарийвчлан хийх, | Хөрөнгө оруулалт хийхдээ хөрөнгө оруулах гэж буй компанид учир болох эрсдэлийг нарийн судлах, хөрөнгө оруулалтын тооцоолол, зарцуулалтад хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагаанд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, валютын ханшийн өсөлт хэрхэн нөлөөлөх талаар нарийн судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг хийнэ. |
| | | - Хөрөнгө оруулалтын бодлогыг чанд баримтлах, | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахдаа тухайн хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, эрх бүхий байгууллагуудаас гаргасан журмыг мөрдлөг болгон ажиллахаас гадна компанийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, дотоод журмуудыг чанд мөрдөн ажиллана. |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбоотой үүсч болох эрсдэл | - "Үнэт цаас тэргүүн ээлжинд худалдан авах эрх"-ээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, | "Үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх"-ийг хэрэгжүүлэхийн тулд хуульд заасан хугацаанд нийтэд зарлах, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтанд шаардлагатай мэдээллээр бүрэн хангахад анхаарах, хувьцаа худалдан авахад шаардлагатай үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, боломжит таатай үнийг санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. |
| | | - Олон нийтэд санал болгох төлөвлөгөө боловсруулах, | Үнэт цаасыг олон нийтэд санал болгох төлөвлөгөөг боловсруулж гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, уулзалт хийх замаар үнэт цаасны борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. |
| | | - Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад танилцуулах, сурталчлах ажиллагаа буюу Road show-г үр дүнтэй хийх, | Өөрийн компанийн харилцагчдаас гадна дотоодын брокер дилерийн компаниудтай хамтран ажиллах замаар дотоодын зах зээлийн оролцогчдод үнэт цаасны мэдээллийг хангалттай хүргэхэд анхаарна.<br><br>БиДиСЕК ХК-тай хамтран ажилладаг олон улсад нэр хүнд бүхий CLSA зэрэг томоохон брокерын сүлжээ, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын банкуудад үнэт цаасны мэдээлэл хүргэх, танилцуулах уулзалт зохион байгуулна |
| | | - Маркетинг, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулж, олон нийтэд мэдээлэл хүргэхэд анхаарч ажиллах, | Маркетинг сурталчилгааны үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээ болон Bloomberg зэрэг мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллаж, үнэт цаасны талаарх мэдээллийг олон нийтэд хангалттай хүргэхэд анхаарч ажиллана. |

СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

2014 07 04



108

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Хууль эрх зүйн эрсдэл | - Хууль, журмыг мөрдлөг болгон ажиллах, | Эрх бүхий байгууллагаас шинэчлэн баталсан хуулиуд, түүнд нийцүүлэн шинэчлэгдэж буй дүрэм, журмуудаар бий болж буй шалгуур шаардлага болон бусад асуудлыг компани нь эрх мэдэн зохицуулах боломжгүй юм. Иймд уг эрх зүйн баримтуудад өөрийн дотоод дүрэм, журмыг нийцүүлэн шинэчлэх замаар хууль, журмыг мөрдлөг болгон, алдаагүй үйл ажиллагааг эрхэмлэн ажиллана. |
| **Дотоод хүчин зүйлийн эрсдэл**<br><br>*Компанийн үйл ажиллагаанаас хамаарах эрсдэлийн хүчин зүйлд олон хувилбар бүхий эрсдэлийн удирдлагын бодлого баримталж уг эрсдэлийг бууруулахад чиглэж ажиллана.* | | | |
| 4 | Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, түүнтэй холбогдон үүсч болох эрсдэл | - Харилцагчдад үзүүлэх үйлчилгээ, санал болгох бүтээгдэхүүний чанарт онцгойлон анхаарах, | ***Брокерийн үйл ажиллагаа:***<br>Өнөөгийн хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн ажиллах, техник технологи, программ хангамжыг сайжруулж, нэмэгдүүлэх, мэргэжлийн чадварлаг мэргэжилтнүүдийг бий болгохтой зэрэгцэн брокерын үйлчилгээг чанаржуулж, сайжруулахаар ажиллаж байна. Үүний хүрээнд:<br>- Цахим арилжаа нэвтрүүлэх<br>- Номинал дансны үйл ажиллагаа эрхлэх<br>- Back office-ийн үйл ажиллагааг сайжруулах<br>- Орон нутгийн салбаруудад арилжааны танхим бий болгох замаар ХЗЗ-ийн идэвхтэй харилцагчдыг нэмэгдүүлэх.<br><br>***Андеррайтерийн үйл ажиллагаа:***<br>Компани нь андеррайтерийн туршлагадаа тулгуурлан зах зээл |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дээр шинэ бүтээгдэхүүн гаргахад хаалттай, нээлттэй бүх төрлийн компанитай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.<br>Нэмэлт хувьцаа гаргах замаар санхүүжилт татаж андеррайтерийн үйл ажиллагаагаа дэмжсэнээр санхүүгийн чадвар нэмэгдэж, зах зээл дээрх байр сууриа хадгалах, бэхжүүлэх боломж бүрдэнэ.<br><br>***Хөрөнгө оруулалтын зөвлөх:***<br>Компани нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчний бааз суурь, тус салбарт олон жил ажилласан туршлагадаа үндэслэн цаашид аж ахуйн нэгж, компаниудад хөрөнгө татан төвлөрүүлэх боломж, компанийн засаглалын талаар зөвлөхөд анхааран ажиллах замаар үйл ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгийн зах зээлд гарах компаниудыг бэлтгэх, андеррайтерийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. |
| | | - БиДиСЕК Бренд бий болгох чиглэлд ажиллах, | Бид цаашид өөрийн компанийн брокерийн сүлжээ болон зах зээл дээрх нэр хүнд, олон жилийн туршлагаараа дамжуулан харилцагчиддаа чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд анхаарч ажиллана.<br><br>Мөн хувьцаа эзэмшигч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа нээлттэй ил тод, компанийн засаглалын зохистой хэм хэмжээг нэвтрүүлэх замаар олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж "БиДиСЕК Бренд"-ийг бий болгоно. |

СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

2014 07 04

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Үйл ажиллагаанд нөлөөлөх талтай бусад эрсдэл | - Хүний үйл ажиллагаанаас хамаарах эрсдэлийг бууруулах, | Компанийн мэргэжилтнүүдийг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлд дараах ажлуудыг хийнэ:<br>- Санаатай болон санамсаргүй гаргасан алдаанаас үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор мэргэжилтнийг хариуцлагын даатгалд хамруулна,<br>- Мэргэжилтнүүдэд мэргэжлийн ёс суртахууныг хэвшүүлэхэд анхаарч ажиллана.<br>- Компанийн дотоод журмыг чанд мөрдөн ажиллах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөхийг шаардах, мэргэжилтэн тус бүртэй нууцлалын гэрээг шинэчлэн баталгаажуулна. |
| | | - Мэргэжилтэнүүдийг мэргэшүүлэх, чадварыг дээшлүүлэх, | - Мэргэжилтнүүдийн ажиллах ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай сургалтанд хамруулах,<br>- Хөрөнгө оруулалтын албаны мэргэжилтэнүүдийг мэргэшсэн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин зэрэг мэргэжлийн сургалтанд суралцахад дэмжлэг үзүүлнэ.<br>- Due diligence хийх үйл ажиллагааг боловсронгүй болгох, чанаржуулах,<br>- Дотоод хяналтыг нэмэгдүүлэх, нэмэлт боловсон хүчин бэлтгэх, |
| 6 | Тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой эрсдэл | - Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны шалгуурыг хангаж ажиллах, | Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,100.0 сая төгрөг байгаа бөгөөд нэмж гаргаж буй 6 сая ширхэг хувьцааг гаргаснаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,700.0 сая төгрөг хүрч, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангана.<br><br>Санхүүгийн Зохицуулах Хорооны 506 тоот тогтоолын хавсралт буюу үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмын зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох |

СЭХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 0

2014 07 04



111

| | | | |
|---|---|---|---|
| | | | заалтуудад заасан алдаа, дутагдлыг гаргахгүй байх чиглэлд анхаарч ажиллаж байна. |
| 7 | Компанийн гүйцэтгэх удирдлага, хяналтын багц эзэмшигчдийн шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл | - Сайн засаглалын тогтолцоог бүрдүүлэх, | Уг эрсдлийг бууруулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.<br>- "Монголын компанийн засаглалыг кодекс"-ийн зөвлөмжүүдийг компанийн засаглалд нэвтрүүлэх,<br>- Ил тод мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх,<br>- Хууль тогтоомжийн нийцүүлэн үйл ажиллагаа явуулах,<br>- Дотоод хяналтын тогтолцоог хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарна. |
| 8 | Компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл | - Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах,<br>- Санхүүгийн бичиг баримт хөтлөлт, бүрдүүлэлтийг стандартад оруулах, | Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн компаниудад тавьдаг хүчин төгөлдөр үйлчилж буй шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байна.<br>Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хариуцлага, санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн бөгөөд 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх юм.<br>Иймд дээрх эрсдэлд орохгүйн тулд үйл ажиллагаандаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг чанд мөрдөн ажиллах шаардлагатай. |
| 9 | Хүний нөөц, боловсон хүчний хангамж, түүнтэй холбоотой эрсдэл | - Мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, | Компанийн албадын менежерүүд болон голлох мэргэжилтэнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх<br>- "Ажилчдад байр", |

СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

2014 07 04

112

| | | | |
|---|---|---|---|
| | | | - "Смарт утас"<br>зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.<br><br>Ингэснээр тухайн мэргэжилтэн компанид тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэх юм. |
| | | - ESOP хөтөлбөр, | Ажилчдад үнэт цаас эзэмшүүлэх (ESOP) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр компанийн ашигт ажиллагаанаас хамаарч ажилчид хувь хүртэх боломж нээгдэх тул ажилчдын бүтээлч чанар дээшилж, ажлын бүтээмж нэмэгдэх сайн талтай. Туршлагатай, мэргэшсэн ажилтантай урт хугацаагаар хамтран ажиллах боломжоог олгож буй уг хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлж ажиллана. |

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



113

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Үнэт цаас гаргагч нь "Компанийн засаглалын кодекс" болон бусад журмуудад нийцүүлэн компанийн засаглалын 5 журмыг боловсруулж, 2012 оны 3 сарын 12 өдрийн ТУЗ-ийн хурлаар батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Эдгээр журмуудыг 2012 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хувьцаа эзэмшигчиддээ танилцуулсан.

### Мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл хүргэх үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012.03.12-ны өдрийн хурлаар батласан хурлаар "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Олон нийтэд түгээх үүрэгтэй мэдээлэл. Үүнд: Хууль тогтоомжид заавал мэдээлэхээр заасан бүхий л мэдээлэл хамаарна.

Олон нийтэд түгээвэл зохих мэдээлэл. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүдийг хамааруулахаар заасан байна.

Бусад мэдээлэл: Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, олон нийтэд хүргэх мэдээллүүдийг хамааруулан үзэхээр заасан байна.

Мэдээллийг олон нийтэд хүргэх мэдээллийг эрх бүхий албан байгууллагуудад хүргэх замаар болон компанийн www.bdsec.mn мэдээллийн цахим хуудсанд давхар байршуулж байхаар журамлаж өгсөн байна. Компани нь мэдээллийн цахим хуудсыг 2005 оноос ашиглалтанд оруулж салбарын болон компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчиддээ хүргэн ажиллаж байна.

### Компанийн үйл ажиллагааны дотоод хяналт

Компани нь хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын ашиг сонирхол хууль ёсны эрх ашгийг хамгаалахын тулд компанийн үйл ажиллагаан дахь хяналтын тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зохих хариуцлага ногдуулах зорилгоор 2012.03.12-ны ТУЗ-ийн хурлаар "Дотоод хяналтын журам"-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Журамд зааснаар Дотоод ажлын алба (ДАА) хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ба ДАА-аас томилогдсон хянан шалгагч шалгалтыг явуулдаг.Үүнд:

- Компанийн ажилчдын үйл ажиллагаанд тавих хяналт;
- Харилцагч болон хамтын ажиллагаатай байгууллагатай хийгдсэн гэрээ хэлцэлд тавих хяналт;
- Өргөдөл гомдлын дагуу хийгдэх шалгалт;



2014 07 04

СЭХ
2014он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, харуул хамгаалалт, ажилчны үйл ажиллагаа зэрэг бусад үйл ажиллагаанд хяналт тавин ажиллана.

## Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа

Компанийн ТУЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх компанийн үйл ажиллагааны стратеги бодлогыг тодорхойлох ТУЗ-ын бүрэлдэхүүнийг сонгохдоо тавих шаардлага, хараат бус гишүүний шалгуур зэргийг зохицуулах зорилгоор 2012.03.12-ны ТУЗ-ийн хурлаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батлан, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн компанийн ТУЗ-ийн 2012 оны 06 сарын 25-ны өдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог байгуулан, гишүүдийг сонгон үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь дараах чиглэлээр ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна. Үүнд:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал;

Компанийн Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцлийг боловсруулах;
- ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



- ТУЗ гишүүнд нэр дэвшигч нь өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулаагүйгээс үүдэн 3 жилийн хугацаанд аль нэг компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллах эрхгүй болсон бол нэр дэвшүүлэхээс татгалзах;

Компанийн Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна.

- ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулах олгох санал боловсруулах;
- Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

## Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, саналаа өгөх эрхийг нь хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор 2012.03.12-ны ТУЗ-ийн хурлаар “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам”-ыг батлан, мөрдлөг болгон ажиллаж байна.

Компани нь компанийн тухай хуулийн дагуу жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргадаг.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

"БиДиСЕК" ХК нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, хуваарилахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 2012.03.12-ны ТУЗ-ийн хурлаар "Ногдол ашгийн журам"-ыг батлан мөрдөж байна.

Журамд зааснаар компани нь хөрөнгө оруулагчдын хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллах ба ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр тусгасан байна. Компани нь ашигтай ажилласан тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол үүнийгээ Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнаж, ашиг хуваарилахгүй байх үндэслэл, ашгийн зарцуулалтын төсөл, тооцооллыг танилцуулахаар заасан байна. Мөн тухайн жил ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бол ногдол ашиг тараасан тухай тайланг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар зайлшгүй танилцуулахаар тусгасан.

Үнэт цаас гаргагч нь 2006 онд үнэт цаасаа олон нийтэд санал болгон арилжаалж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон. Түүнээс хойш дараах байдлаар ногдол ашиг тарааж байжээ.

Хүснэгт 42. Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг тараалтын судалгаа

| Хугацаа | 2006 | 2007 | 2009 | 2010 | 2012 | 2013* |
|---|---|---|---|---|---|---|
| Ногдол ашиг | 3 | 30 | 5 | 50 | 60 | 11.78 |

*Эх сурвалж: БиДиСЕК ХК, МХБ*

2013* *-ТУЗ-ийн 2014 оны 02 сарын 18-ны өдрийн шийдвэрээр 2013 оны цэвэр ашгаас компанийн нэгж хувьцаанд 11.78 төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.*

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-уудад заасан болон компанийн дүрэмд заасан дараах эрхтэй.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан хувьцаа эзэшигч хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах;

Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ хангана.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
Үүнд:

- Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах;
- Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
- Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Хувьцаа эзэмшигч дангаараа эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно. ТУЗ-өөс тогтоосон үнэ нь үнэлгээний байгуулагын дүгнэлтэд заасан үнээс доогуур байж болохгүй.

Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч болон эзэмшигчид нь санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэх эрхтэй.

Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрэмд заасан эрхээ эдлэх баталгаа болно.

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 болон 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.
Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцааг эзэмшигчид нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.

Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.



2014 07 04

Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

## ҮНЭТ ЦААСЫГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ

### ТУЗ-ийн тогтоол

## “БиДиСЕК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 15 – ны өдөр №07 Улаанбаатар хот

***Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах журам батлах тухай***

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын №03 тоот тогтоолыг үндэслэн “БиДиСЕК” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах журмыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Компанийн тухай хууль”-ийн 38 дугаар зүйлд заасны дагуу нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх СЗХ-ны тогтоол гарснаас хойш ажлын 30 хоногт нийт 6,000,000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлсүгэй.
2. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журмыг хавсралт 1-р баталсугай.
3. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал (Д.Даянбилгүүн)-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **Б.ЛХАГВАДОРЖ**



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ



# ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь "Компанийн тухай хууль"-ийн 38-р зүйлд заасны дагуу "БиДиСЕК" ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд санал болгох, санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан, худалдан авах санал ирүүлээгүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Компани нь Нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх СЗХ-ны тогтоол гарснаас хойш ажлын 30 хоногт нийт 6,000,000 ширхэг хувьцааг бүхэлд нь хувьцаа эзэмшигчдэд санал болгон тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлнэ. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр нь хувьцаа нэмж гаргах шийдвэр гарсан хурлын бүртгэлийн өдөр болох 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдөр байна.

1.3 "Компанийн тухай хууль"-ийн 38.4, 55.8-т заасны дагуу нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд санал болгох хувьцааны үнийг ТУЗ-ийн 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс өмнөх хувьцааны 6 сарын жигнэсэн дундаж ханш болох 2146 төгрөгийн 90%-иас доошгүй байна гэдгийг харгалзан хамгийн багадаа 1931 төгрөгөөр тогтоосон.

## Хоёр. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх

2.1 Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд авах эрхийг тус компанийн 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөрх энгийн хувьцаа эзэмшигч бүрт эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авах эрхийг тэгш олгоно.

2.2 СЗХ-ны шийдвэр гарснаас хойш Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд гаргаж буй хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэнэ.

2.3 Хувьцаа эзэмшигчдэд 2.2-т заагдсан мэдээлэл хүргэгдсэнээс хойш ажлын 30 хоногийн дотор хувьцаа худалдан авах саналаа журмын 1-р хавсралтаар баталсан хүсэлтийн дагуу бөглөн "БиДиСЕК" ХК-нд хүргүүлнэ.

2.4 Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах эрх хэрэгжүүлэх заавар журамтай холбоотой зөвлөгөө зааварчилгааг үнэт цаас гаргагч "БиДиСЕК" ХК-иас авах эрхтэй.

2.5 Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ бусад этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлж болно.

2.6 Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ бусад этгээдэд жилжүүлэхэд одоогийн хувьцаа эзэмшигчид хоорондоо болон өөрийн гэр бүлийн гишүүнд шилжүүлэхээс бусад тохиолдолд үнэт цаас гаргагчийн ТУЗ-н зүгээс эрх шилжүүлэх хүсэлт дээр татгалзах эрхтэй.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2.7 Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ бусад этгээдэд шилжүүлж байгаа хувьцаа эзэмшигч болон эрх хүлээн авч буй этгээд нь 2-р хавсралтаар баталсан хүсэлтийг 2.3-д заасан хугацаа дуусахаас ажлын 10 хоногийн өмнө үнэт цаас гаргагч компанид ирүүлсэн байна.

## Гурав. Тэргүүн ээлжинд худалдан авах саналаа илэрхийлсэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх

3.1 Хувьцаа эзэмшигч нь тус журмын 2.2 болон 2.7-д заасан хугацаанд хувьцаа худалдан авах хүсэлтээ үнэт цаас гаргагч компанид ирүүлсэнээр тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх баталгаажна.

3.2 Тэргүүн ээлжинд худалдан авах санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн бүртгэл гарган арилжаа эхлүүлэх хүсэлтийг СЗХ-нд хүргүүлнэ.

3.3 Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаа худалдан авч буй хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ба тухайн арилжаа явагдах өдөр хувьцаа эзэмшигчдийн клирингийн банкин дахь төлбөр тооцооны дансанд худалдан авах хувьцааны үнийн дүн, арилжааны шимтгэлтэй тэнцэх хэмжээний мөнгө байршсан байна.

3.4 Тухайн арилжаа явагдах өдөр хувьцаа эзэмшигчдийн төлбөр тооцооны дансан дахь мөнгөний үлдэгдэл захиалга өгсөн хувьцаа худалдан авахад шаардагдах үнийн дүнд хүрэхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болно.

## Дөрөв. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр аваагүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах

4.1 Нэмж гаргаж буй үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргүүлснээс хойш хувьцаа эзэмшигч нь ажлын 30 хоногт багтаан худалдан авах саналаа ирүүлээгүй, эрхээ бусдад шилжүүлээгүй нөхцөлд тухайн хувьцаа эзэмшигчийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

4.2 Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгож буй хувьцаанаас санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн худалдан авах эрхийг хэрэгжүүлэн үлдэгдэл хувьцааг зах зээл дээр олон нийтэд санал болгоно.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ

Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр арилжаалагдаагүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаална.

Нэмж гаргаж буй үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргүүлснээс хойш хувьцаа эзэмшигч нь ажлын 30 хоногт багтаан худалдан авах саналаа ирүүлээгүй, эрхээ бусдад шилжүүлээгүй нөхцөлд тухайн хувьцаа эзэмшигчийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгож буй хувьцаанаас санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн худалдан авах эрхийг хэрэгжүүлэн үлдэгдэл хувьцааг олон нийтэд санал болгоно.

Үлдэгдэл хувьцааг олон нийтэд тогтсон үнийн аргаар санал болгох ба санал болгох үнийг ТУЗ-аас зах зээлийн үнийг харгалзан тэргүүн ээлжинд санал болгох үнээс багагүй байхаар тогтооно.

## Татвар, шимтгэл

### Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч үнэт цаасны арилжаанд ороход нийт гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар шимтгэл төлөх ба тус шимтгэлийн хувь хэмжээ нь тухайн харилцагч өөрийн брокерийн компанид үнэт цаасны данс нээлгэхдээ тогтоосон хувь байна.

### Ногдол ашгийн татвар

"Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн 30.2 дугаар зүйл "энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2013/01/01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна" гэж заасан ба 13.1.3 "ногдол ашгийн орлого" ба 13.1.4 "хүүгийн орлого" гэж тодорхойлжээ.

*Иймд иргэн, хувь хүн ногдол ашгийн орлогод 2013.01.01-ээс эхлэн 10%-ийн татвар төлнө.*

"Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 16.3 "Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно", 16.3.1 "ногдол ашгийн орлого", 17.2 "Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна", 17.2.1 "ногдол ашгийн орлогод 10 хувиар" гэж заагдсан.

*Иймд ногдол ашгийн орлого олсон байгууллага нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар ногдол ашгийн орлогоосоо 10 хувиар татвар ногдуулж төлнө.*



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 17.2.9.а-д зааснаар "Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгч нь Монгол улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлогоос 20 хувиар тооцож татвар төлнө" гэж заасан.

**Борлуулалтын орлогоос олсон ашгаас татвар төлөх:**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн *"20.1.4.хувьцаа бусад үнэт цаас борлуулсан тохиолдолд нийт хувьцаа, бусад үнэт цаас худалдсан үнээс тэдгээрийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн нийт дүнг хассан зөрүүгээр нь";* 20.1.4-д заасан орлогод ногдуулах татварын хэмжээг *"тус хуулийн 23.1-д тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна"* гэж заасан байна.

Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн *"16.8.Хувьцаа бусад үнэт цаас борлуулсан тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо нийт хувьцаа, бусад үнэт цаас худалдсан үнээс тэдгээрийг худалдан авсан үнэ, болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн нийт дүнг хасч тооцно. Энэ заалтад тухайн хуулийн этгээдийн гаргасан өөрийнх нь хувьцаа, бусад үнэт цаас хамаарахгүй"*, 16.8-д заасан орлогод ногдуулах албан татварын хэмжээг *"тус хуулийн 17.1-д 0-3,0 тэрбум төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3,0 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3,0 тэрбум төгрөгөөс давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна"* гэж заасан байна.

Мөн тус хуулийн *"17.2.8-д гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20 хувиар"* тооцож албан татвар ногдууна гэж заасан.

**Давхар татварын гэрээ:**

2013 оны 3 дугаар сарын байдлаар Монгол улс 28 улстай "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр"-ийг байгуулаад байна.
Дэлгэрэнгүй мэдээлэл авах хаяг цахим хаяг: Татварын ерөнхий газар www.mta.mn

**Валютын ханш**

МХБ-ийн арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (MNT) хийгдэнэ. Ханшийг тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцно. Арилжааны банкууд төгрөгтэй харьцах гадаад валютын ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоож олон нийтэд зарладаг. Монгол Улсын томоохон арилжааны банкуудын ханшийн мэдээлэл авах цахим хаягууд:

**Голомт банк:** www.golomtbank.com
**Хаан банк:** www.khanbank.com
**Төрийн банк:** www.statebank.mn
**Худалдаа хөгжлийн банк:** www.tdbm.mn

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





Хүснэгт 43. Нэмж гаргаж буй үнэт цаасны мэдээлэл

| | |
|---|---|
| Хувьцааны код: | 522 /BDS/ |
| Нийт гаргасан хувьцааны тоо: | 11,000,000 ширхэг |
| Хувьцааны төрөл: | Энгийн |
| Нэрлэсэн үнэ: | 100 төгрөг |
| Зах зээлийн үнэ буюу 6 сарын жигнэсэн дундаж ханш: /2014.01.16-наас өмнөх/ | 2,146 төгрөг |
| Нэмж гаргах хувьцааны тоо: | 6,000,000 ширхэг /35.29%/ |
| Санхүүжилтийн зорилго: | Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт |
| Тэргүүн ээлжинд санал болгох: | Нэмж гаргаж буй үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг компанийн энгийн хувьцааг 2014/03/03-ны өдрөөр эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчдэд санал болгоно. |
| Олон нийтэд санал болгох: | Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгосон хувьцаанаас тус эрхийг хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгоно. |
| Тэргүүн ээлжинд санал болгох үнэ: | Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнэ 1,931 /нэг мянга есөн зуун гучин нэг/ төгрөг байна. |
| Олон нийтэд санал болгох үнэ: | Олон нийтэд тогтсон үнийн аргаар санал болгоно. Санал болгох үнэ нь зах зээлийн үнийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл тогтооно. |

*Зах зээлийн үнэ* - Компанийн хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш*



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Үнэт цаас гаргах шийдвэрийн тухай

Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 42, 87-р зүйл, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн 2014.04.18-ны өдрийн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 3 тоот тогтоолоор Компанийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нэмэлт санхүүжилтийг татах зорилгоор 6,000,000 ширхэг энгийн хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн.

Тус хурлын 2014.03.03-ны бүртгэх өдрөөр компанийн хувьцааг эзэмшиж байсан 417 хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж буй хувьцаанаас Тэргүүн ээлжинд худалдан авах эрх үүссэн.

"Компанийн тухай хууль"-ийн 39.4, 43, 56-р зүйлийг үндэслэн, "БиДиСЕК" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн хурлаар нэмж гаргаж буй хувьцааны зах зээлд санал болгох үнэ, тэргүүн ээлжинд санал болгох үнийг тогтоосон.

## Нэмж гаргаж буй үнэт цаасны ширхэг

Компанийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нэмэлт санхүүжилтийг татах зорилгоор 6,000,000 ширхэг хувьцаа нэмж гаргана. Ингэснээр нэмэлт хувьцаа гаргасны дараа компанийн нийт гаргасан хувьцааны тоо 17,000,000 ширхэг болох ба одоо байгаа гаргасан хувьцаа нь 64.71%-ийг, шинээр гаргаж буй нэмэлт хувьцаа нь 35.29%-ийг эзлэх юм.

## Үнэт цаасыг санал болгох үнэ

Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнэ "Компанийн тухай хууль"-ийн 38.4, 55.8-д заасны дагуу 2014.01.16-ны өдрөөс өмнөх 6 сарын дундаж ханш 2,146 төгрөгийн 90%-иас доошгүй үнэ болох 1,931 төгрөгөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр санал болгоно. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр арилжаалагдаагүй үлдсэн хувьцааг зах зээлийн үнээр анхдагч зах зээлд байршуулан арилжаална.

## Анхдагч зах зээлд байршуулах цаг хугацааны үечлэл

Нэмж гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах ажиллагаа хүснэгт 43-д туссан цаг хугацааны үечлэлийн дагуу явагдана. Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоолоор үнэт цаасны арилжаалах арга хэлбэр, захиалга авч эхлэх, дуусах хугацаа, уг хугацааг сунгах, богиносгох зэрэгт өөрчлөлт орж болно.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР БАЙРШУУЛАХ ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эхний удаа нийт 6,000,000 ширхэг хувьцаа дээр хэрэгжүүлэх ба үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгон анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна

Хүснэгт 44. Нэмж гаргаж буй хувьцааг зах зээлд байршуулах төлөвлөгөө

| | | Долоо хоног | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-6 | | | | | | 7-24 | | | | |
| СЗХ-ны шийдвэр | | | | | | | | | | | | |
| МХБ-н бүртгэл | | | | | | | | | | | | |
| ҮЦТТТХТ-н бүртгэл | | | | | | | | | | | | |
| Тэргүүн ээлжийн захиалга | Хувьцаа эзэмшигчдэд санал болгох | Нэмэлтээр гарч буй бүх хувьцаа дээр санал авна | | | | | | | | | | |
| | Тэргүүн ээлжинд хэрэгжих хувьцааг зах зээлд байршуулах | | | | | | | | | | | |
| Олон нийтэд санал болгох | Хөрөнгө оруулагчдад санал болгох | | | | | | | Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлээд үлдсэн хувьцааг санал болгоно | | | | |
| | Анхдагч зах зээлд байршуулах | | | | | | | | | | | |

2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10 дугаар зүйлийн 10.8.1-д заасны дагуу "Хуульчийн дүгнэлт"-ийг Өмгөөллийн "Ананд адвокатс" ХХН-ээр 2014 оны 5 дугаар сарын 19-ны байдлаар хийж гүйцэтгүүллээ.

Уг хуулийн дүгнэлтийг хийхдээ үнэт цаас гаргагчаас дараах баримт бичгүүдийг гаргуулан хянасан болно.

1. Компанийн дүрэм, хуулийн этгээдийн гэрчилгээ, танилцуулга,
2. Компанийн хөдөлмөрийн болон үйл ажиллагааны бусад журмууд,
3. Компаниас гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлүүд,
4. Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх олгосон төрийн захиргааны байгууллагын шийдвэр, эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл,

Энэхүү хуулийн дүгнэлт нь нийт 28 хуудас болсон ба үнэт цаасны танилцуулгад зөвхөн "дүгнэлт" хэсгийг нь оруулсан. Хэрэв хөрөнгө оруулагч та хуулийн дүгнэлтийг бүрэн эхээр нь авч танилцах бол үнэт цаас гаргагчид хандан танилцаж болно.

### Хуульчийн дүгнэлт

- Компани нь Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн, хувьцаагаа нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хувьцаат компани болно.
- Компанийн дүрэм болон дотоод журмууд нь Компанийн тухай хууль, Монголын Компанийн Засаглалын Кодекст нийцсэн байна.
- Компани нь Монголын Компанийн Засаглалын Кодекст зөвлөсний дагуу 2012 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 03 тоот тогтоолоор ""БиДиСек" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам", ""БиДиСек" ХК-ийн ногдол ашгийн журам", ""БиДиСек"ХК-ийн дотоод хяналтын журам", "БиДиСек" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам", "БиДиСек" ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус батлаж, даган мөрдөж байна.
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Аудитын хороог дэргэдээ байгуулан, ажиллуулж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь үйл ажиллагааны тодорхой чиглэлээр зөвлөгөө өгөх, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хороодыг байгуулан ажиллахыг Монголын Компанийн Засаглалын Кодекст зөвлөсөн байдаг.
- Компани нь Мэдээллийн үйл ажиллагааны журмыг батлаж, өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байгаа нь компанийн үйл ажиллагаа ил тод байж, компанид итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх нэг үндэслэл болж байна.
- Компанийн эрхлэн явуулж буй үйл ажиллагааны онцлогтой холбоотой журмуудыг баталж мөрдөж байгаа нь Санхүүгийн Зохицуулах хорооны шаардлага хийгээд үнэт цаасны зах зээлийн журмуудад нийцсэн байна.
- Компани нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болох үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа, андеррайтерийн үйл ажиллагаа,

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүд нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаж байгаа тул төрийн захиргааны байгууллагаас шууд хүчингүй болгох, цуцлах хууль үндэслэл байхгүй болно. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 506 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-д "Өргөдөл гаргагч нь ... шаардлага хангасан тохиолдолд Хороо тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгоно" гэж заасны дагуу Компанийн эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хугацаагүй болсон байна.

- Нэмж хувьцаа гаргах тухай шийдвэрийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дах заалттай нийцэж байна.
- Компанийн байгуулсан гэрээнүүдийн үнийн дүнг тухайн гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс хамаарах байдлаар тогтоосон байна.
- Компаниас байгуулсан Андеррайтерийн гэрээ нь компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.1-д заасны дагуу Их хэмжээний хэлцэлд хамаарахгүй юм.
- Компани нь Голомт банктай байгуулсан Зээлийн гэрээнүүдийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Компанийн хувьцаа эзэмшигч Д.Даянбилгүүн өөрийн эзэмшлийн хувьцаагаа барьцаалсан байна. Хувьцаа эзэмшигч Д.Даянбилгүүн өөрийн өмчлөлийн зүйлээр Компанийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар үүрэг хүлээж буй хэлцэл нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.1-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байна. Мөн "Эм Ай" ХХК-ийн хувьцаа худалдах худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарна. Компани нь сонирхлын зөрчилтэй зарим хэлцлийг хийхдээ Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан журмыг баримталсан байна.
- Шинээр нэмж 6 000 000 (зургаан сая) ширхэг хувьцааг нэг ширхэг хувьцаа нь 2 146 (хоёр мянга нэг зуун дөчин зургаа)-н төгрөгөөг гаргаж байгаа нь Компанийн тухай хуулийн 87 дгаар зүйлийн 87.1.2-т заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолд дурьдсанаар нэмж хувьцаа гаргах асуудлыг 100 хувийн саналаар зөвшөөрч баталсан байна. Компанийн нэмж хувьцаа гаргах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол нь Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-д заасан журмын дагуу гарсан байна.
- Дүгнэлтэд хамаарах хугацаанд Компаниас гуравдагч этгээдтэй байгуулсан бусад гэрээ хэлцлүүд нь компанийн хэвийн үйл ажиллагааг хангасан, үндсэн үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан гэрээ хэлцлүүд бөгөөд эдгээр гэрээ хэлцлүүд хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан байна.
- Компаниас нэмж гаргаж байгаа үнэт цаасыг Хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахыг хүссэн өргөдөл,үнэт цаасны танилцуулга болон холбогдох бичиг баримт нь хууль тогтоомж,

СЗХ
2014 он . 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

Хорооноос тогтоосон журмууд болон Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан, тэдгээртэй нийцсэн байна.

- Компанийн үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл нь хууль тогтоомж хийгээд төрийн захиргааны эрх бүхий байгууллагын тодорхойлолт, лавлагаагаар нотлогдож байна.
- Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч нь Компанийн хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Монгол Улсын иргэн Д.Даянбилгүүн болохыг тодорхойлж байна. Д.Даянбилгүүн нь ял шийтгэгдэж байгаагүй, “БиДиСек” ХК-ийг үүсгэн байгуулагч бөгөөд 18-н жилийн турш тус компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№01

131

## ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОН ЭТГЭЭД, ТЭДГЭЭРТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч компани нь нэмж үнэт цаас гаргахтай холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ийн холбогдох журамд заасны дагуу хараат бус хөндлөнгийн аудит, үнэлгээ, хуулийн байгууллагуудаар өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл тайлагнал, үнэт цаас гаргах шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэлүүдэд дүгнэлт хийлгүүлсэн. Үүнд:

1. **Аудит**

   БиДиСЕК ХК нь 2013 оны 11 дүгээр сарын 1-ны өдөр БДО Монголиа ХХК (БДО Аудит ХХК) -тай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү гэрээгээр "БДО Монголиа" ХХК нь үнэт цаас гаргагчийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулгуудад аудит хийх үүрэг хүлээсэн болно. Мөн аудитор нь 2011 болон 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн.

   Аудитын компанийн зүгээс гэрээнд заасан ажлыг гүйцэтгэн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр үнэт цаас гаргагчид ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН-г ирүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн. 2013.12.31-ний өдрөөрх аудитлагдсан тайланг үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгын 119-158-р хуудсанд тусгасан болно.

   БДО Монголиа ХХК нь 2012 оны 12 сард Монгол Улсын Улаанбаатар хотод Итгэлт Аудит ХХК болон Амар Инкон ХХК нэгдсэнээр байгуулагдсан. Итгэлт аудит ХХК нь 1997 оноос хойш нягтлан бодох бүртгэл, аудит ба зөвлөх үйлчилгээг үзүүлж байгаа ба Монгол Улсын шилдэг 5 аудитын компанийн тоонд багтсаар ирсэн. Амар Инкон ХХК нь 2005 оноос хойш Монгол Улсын шилдэг зөвлөх үйлчилгээний компануудын нэг юм.

   БДО сүлжээ нь 1963 онд мэдлэг туршлагаа солилцон, өргөжүүлж харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд Их Британий Нэгдсэн Вант Улс, Голланд, Герман, Америкийн Нэгдсэн Улс болон Канадын байгууллагууд нэгдсэнээр анх үүсгэн байгуулагдсан юм

2. **Үнэлгээ**

   Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшилд байгаа үндсэн хөрөнгө (барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер, түүний эд анги, бусад хөрөнгө, биет бус хөрөнгө мөн охин компанийн компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил)-ийн зах зээлийн дахин үнэлгээг тодорхойлуулах ажлыг "Далайван Аудит" ХХК-тай 2014 оны 2 дугаар сарын 04-ны өдөр 2/02 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

132

Далайван Аудит ХХК нь гэрээнд заасан хугацаанд гэрээт ажлыг гүйцэтгэн 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр "Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн тухай тайлан"-г үнэт цаас гаргагчид ирүүлсэн.

Үнэт цаас гаргагч нь дээрх тайланг үнэт цаасны танилцуулгын 159-176-р хуудсанд тусгасан болно.

Далайван Аудит ХХК нь 1993 онд байгуулагдсан Монголын анхны аудитын компани бөгөөд үүсгэн байгуулагдсанаас өдгөөг хүртэл аудитын салбарт манлайлагч, тэргүүлэгч байр сууриа хадгалж ирсэн.

Аудит ба баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ, үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Дархан-Уул, Орхон аймгуудад өөрийн салбартай.

Тус компани 2007 онд олон улсын хэмжээнд 8-д жагсдаг, дэлхийн 125 улс орны 149 гишүүн байгууллагыг нэгтгэсэн аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн зөвлөх үйлчилгээний томоохон сүлжээ Бейкер Тилли Интернэшл (Baker Tilly International)-ийн Монгол Улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн болсон.

## 3. Хууль

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр "Ананд энд Батзаяа" ХХК (Ананд адвокатс ХХН)-тай Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулсан. Энэхүү гэрээгээр БиДиСЕК ХК-ийн нэмж үнэт цаас гаргахтай холбогдон компанийн дүрэм журмууд, бусадтай байгуулсан хүчин төгөлдөр гэрээ хэлцэл, их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийсэн бол хууль журмын дагуу хийсэн эсэх зэрэгт хөндлөнгийн дүгнэлт гаргасан болно.

Хуулийн компани нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 2014 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн албан тоотоор Хуульчийн дүгнэлтийг ирүүлсэн.

Үнэт цаас гаргагч нь дээрх дүгнэлтийг үнэт цаасны бүрдүүлбэрийн Хавсралт материалд тусгасан болно.

Ананд Адвокатс ХХН нь 2004 онд үүсгэн байгуулагдсан "Ананд энд Батзаяа" ХХК-ийн зүй ёсны үргэлжлэл болж Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу байгуулагдсан хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйл ажиллагааг дагнан эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд юм.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.7-д заасан үний дүн бүхий дараах хэлцэлийг байгуулсан бөгөөд тэдгээр гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, хариуцлагыг биелүүлэн ажилласан ба мөн гэрээ хэлцэлүүдийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу хийсэн болно. Үүнд:

Хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ хэлцэл:

- "Хай Би Ойл" ХК-тай 2013 оны 12-р сарын 30-ны өдөр Андеррайтерын гэрээг байгуулсан. Энэхүү гэрээгээр тус компанид БНАСАУ-д хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөлд шаардлагатай 5 сая ам.долларын санхүүжилтийг хөрвөх зээлийн хэлбэрээр амжилттай босгосон ба мөн гэрээний дагуу Хөрвөх зээлийг хувьцаанд хөрвүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн гэрээ хэлцэлүүд:

- Голомт банктай 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдөр ЗГ81115006307 дугаартай зээлийн гэрээ байгуулсан ба гэрээгээр 300 сая төгрөгийг 3 сарын хугацаатай, жилийн 16.8 хувийн хүүтэй зээлэхээр харилцан тохиролцсон. БиДиСЕК ХК нь дээрх зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн болно.
- Голомт банктай 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдөр ЗГ/81115005220 дугаартай Зээлийн гэрээ байгуулсан. Энэхүү гэрээгээр 1.5 тэрбум төгрөгийг 1.6 хувийн хүүтэйгээр 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2011 оны 12 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаагаар авахаар тохиролцож, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн болно.
- "Бэрэн майнинг"ХК-тай 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Андеррайтерын гэрээ байгуулсан ба гэрээгээр тус компанийн нийт хувьцааны 30%-тай тэнцэх нийт 130,560,999,000 төгрөгийн хувьцаа гаргах зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах, мөн нийтэд санал болгон арилжаалахаар харилцан тохиролцсон болно. "БиДиСЕК" ХК нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу "Бэрэн майнинг" ХК-ийн үнэт цаас гаргах зөвшөөрлийг СЗХ болон МХБиржээс авч, нийтэд санал болгох үйл ажиллагаанд дээд зэргийн хүчин чармайлт гарган ажилласан.
- "Жаст групп" ХХК-тай 2011 оны 3 дугаар сарын 14-ний өдөр ЖГХА/10-11 дугаартай Андеррайтерын гэрээг байгуулсан ба гэрээгээр 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,000,000 ширхэг бондыг хэсэгчлэн олон нийтэд санал болгох гаргах, түүнийг худалдан борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд эхний ээлжинд 4.4 тэрбум төгрөгийг зах зээл дээрээс амжилттай татан төвлөрүүлсэн.
- "Монгол 999 Үндэсний нэгдэл" ХК-тай 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Андеррайтерын гэрээ байгуулсан. Энэхүү гэрээгээр тус компанийн хувьцааг нийтэд санал болгон гаргах, хөрөнгийн зах зээл дээр зуучлан худалдах ба үнэт цаас гаргагч компанийн тодорхой шалтгааны улмаас хоёр тал дээрх гэрээг дүгнэж акт байгуулсан.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ

134

- Аурум Ресурс Майнинг ХХК-тай 2012 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Зуучлалын гэрээ байгуулсан. Энэхүү гэрээгээр “Жамп-Алт” ХХК-д шаардлагатай 4,816.0 сая төгрөгийг хаалттай хүрээнд шууд хөрөнгө оруулалтаар татахаар ажилласан ба УИХ-аас баталсан “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуульд “Жамп-Алт” ХХК-д хамрагдсан, уг хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой бус байсан, УИХ-ын ээлжит сонгуулийн дүнд олон намын бүрэлдэхүүнтэй Засгийн газар байгуулагдах болсноор эдийн засаг, улс төрийн ямар бодлого хэрэгжүүлэх нь тодорхой бус болсон, Монголын Хөрөнгийн Биржид шинээр “Миллимиум IT” программ нэвтрүүлэх үйл ажиллагаа нь зах зээлд тодорхойгүй хугацаагаар уналт, зогсонги байдал үүсгэсэн зэрэг нь хөрөнгө оруулагчдын идэвхийг сулруулж, хүлээлт үүсгэсэнтэй холбоотойгоор талууд 2013 оны 5 дугаар сарын 27-нд Гэрээг дүгнэж, актыг байгуулсан.



2014 07 04

135

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

# “БИ ДИ СЕК”
## Хувьцаат Компани

2013 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

BDO



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## "БИДИСЕК" Хувьцаат компани
## Байгууллагын талаарх мэдээлэл

| | |
|---|---|
| Гэрчилгээ | "БиДиСек" ХК нь 2006 оны 06 сарын 22-ны өдөр хувьцаат компани болон дахин зохион байгуулагдаж Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 2052482 регистрийн дугаар бүхий 9010001030 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. |
| Үндсэн үйл ажиллагаа | Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. |
| Нэгтгэгдсэн компани | "БиДиСиЭйПи" ХХК 100% <br> 2007 оны 07 сарын 16-ны өдрийн "БиДиСек" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрээр "БиДиСиЭйПи" ХХК-ийг хөрөнгө оруулалтын чиглэлээр үүсгэн байгуулахаар шийдвэрлэж 2007 оны 8 сарын 15-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 5157781 регистрийн дугаар бүхий 9011117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. |

| | | |
|---|---|---|
| Хувь нийлүүлэгчид | Герман улсын иргэн Alexander Zwahr | 28% |
| | Монгол Улсын иргэн Д.Даянбилгүүн | 26% |
| | АНУ-ын Firebird Master Fund хөрөнгө оруулалтын сан | 10% |
| | Firebird Master Fund Holding | 5% |
| | Firebird Global Master fund | 4% |
| | Монгол Улсын иргэн Б.Лхагвадорж | 4% |
| | Монгол Улсын иргэн Д.Амгаланбаяр | 3% |
| | Монгол Улсын иргэн Н.Батгэрэл | 3% |
| | Пи Би Си ХХК | 3% |
| | Бусад жижиг хувьцаа эзэмшигчид | 14% |
| Төлөөлөн Удирдах Зөвлөл | Б.Лхагвадорж | ТУЗ-ийн дарга |
| | Д.Даянбилгүүн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| | Н.Батгэрэл | ТУЗ-ийн хараат гишүүн |
| | Д.Амгаланбаяр | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Б.Энхбаяр | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Б.Амарсанаа | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | James Passin | ТУЗ-ийн хараат гишүүн |
| | Hitoshi Tani | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Alexis Mecquenem | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гүйцэтгэх Удирдлага "БиДиСек" ХК | Д.Даянбилгүүн | Гүйцэтгэх Захирал |
| | Б.Лхагвадорж | Тэргүүн Дэд Захирал |
| | Н.Батгэрэл | Дэд Захирал |
| "БиДиСиЭйПи" ХХК | С.Пүрэвсүрэн | Гүйцэтгэх Захирал |
| Байгууллагын хаяг | "БиДиСек" ХК<br>Залуучуудын өргөн чөлөө 27/1<br>Сүхбаатар дүүрэг 8-р хороо,<br>Улаанбаатар,<br>Монгол улс | |
| Аудитор | "БДО Аудит" ХХК<br>АБ Центр, 10-р давхар<br>Их сургуулийн гудамж 31,/1<br>Сүхбаатар дүүрэг, 6-р хороо<br>Улаанбаатар-142193,<br>Монгол улс | |

1

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-4 дэх хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "БиДиСек" ХК-ийн 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

"БиДиСек" ХК-ийн удирдлага бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, иж бүрэн бэлтгэх үүрэгтэй билээ. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангуудаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээг бүрэн гүйцэд, үнэн зөв бүртгэж иж бүрэн толилуулсан гэдгээ баталж байна.

"БиДиСек" ХК-ийн 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

| Б.Лхагвадорж | Т.Отгонжаргал | М.Цагаанцэцэг |
|---|---|---|
| *Тэргүүн Дэд Захирал* | *Санхүүгийн менежер* | *Нягтлан бодогч* |

Огноо: ________________________

Улаанбаатар хот, Монгол улс





2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

BDO

Tel. +976 77404041
Fax: +976 77451150
www.bdo.mn

Level 10, AB Center Building,
University Street,
11 th Khoroolol, khoroo-6,
Sukhbaatar District-14193,
Ulaanbaatar, Mongolia

Утас: +976 77404041
Факс: +976 77451150
www.bdo.mn

АБ Центр, 10 давхар
СБД-6, 11-р хороолол
Улаанбаатар Монгол улс
14193

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"БиДиСек" ХК-ийн хувь нийлүүлэгчдэд

## Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаарх

Бид "БиДиСек" ХК-ийн 5-39 дүгээр хуудсанд тусгагдсан 2013 оны 12 сарын 31-ний өдрийн Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайлан, Нэгтгэсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан, Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан, Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

### *Нэгтгэсэн санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага*

Удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, шударгаар иж бүрэн толилуулах үүрэгтэй. Үүнд: санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг тогтоож, ажиллуулан, хэвийн түвшинд сахих, тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

### *Аудиторын хүлээх хариуцлага*

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.



BDO LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО ХХК нь Их Британи Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

СЭХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

BDO

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН *(үргэлжлэл)*

### *Аудиторын дүгнэлт*

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь *Тэмдэглэл 31* Болзошгүй алдагдал хэсэгт дурдсанаас бусад бүх л материаллаг зүйлсийн хувьд, "БиДиСек" ХК-ийн 2013 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

### *Тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "БиДиСек" ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

"БДО Аудит" ХХК
Улаанбаатар хот, Монгол улс
*Тусгай зөвшөөрөл: 009-1997*

Огноо: 2014.02.28

4

BDO LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## “БИДИСЕК” ХК

2013 оны 12 сарын 31-ний өдрөөрх
### Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

| | Тэм | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| ***Эргэлтийн хөрөнгө*** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 7 | 857,856 | 661,214 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 8 | 4,096,218 | 4,387,242 |
| Худалдааны ба бусад авлага | 9 | 1,268,499 | 872,201 |
| Орлогын албан татварын авлага | | 21,942 | 54,633 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | 6,244,515 | 5,975,289 |
| ***Эргэлтийн бус хөрөнгө*** | | | |
| Үндсэн хөрөнгө - цэвэр | 10 | 3,396,621 | 3,660,528 |
| Биет бус хөрөнгө - цэвэр | 11 | 3,330 | 1,260 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 12 | 1,081 | 2,081 |
| Урт хугацаат авлага | 13 | 104,261 | 108,867 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | - | 2,195 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | 3,505,293 | 3,774,931 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | 9,749,808 | 9,750,220 |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| ***Эргэлтийн өр төлбөр*** | | | |
| Худалдааны ба бусад өглөг | 14 | 104,459 | 202,030 |
| Бусад татварын өглөг | 15 | 12,696 | 17,187 |
| Ногдол ашгийн өглөг | 16 | 660,000 | - |
| Урьдчилж орсон орлого | | 10,000 | 20,000 |
| **Эргэлтийн өр төлбөрийн дүн** | | 787,156 | 239,217 |
| ***Эргэлтийн бус өр төлбөр*** | | | |
| Хойшлогдсон татварын өглөг | 17 | 44,542 | 61,946 |
| **Эргэлтийн бус өр төлбөрийн дүн** | | 44,542 | 61,946 |
| ***Нийт өр төлбөр*** | | 831,698 | 301,163 |
| **ӨМЧ** | | | |
| Хувьцаат капитал | 18 | 3,925,305 | 3,925,305 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 19 | 1,300,244 | 1,300,244 |
| Үнэт цаасны хэрэгжээгүй олз/(гарз) | 20 | 400,877 | 557,512 |
| Хуримтлагдсан ашиг | | 3,291,685 | 3,665,997 |
| **Нийт өмч** | | 8,918,111 | 9,449,057 |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | 9,749,808 | 9,750,220 |

*Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

141

“БИДИСЕК” ХК

## 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

| | Тэм | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 21 | 2,446,064 | 5,777,990 |
| Борлуулсан үнэт цаасны өртөг | | (650,221) | (1,093,568) |
| **Нийт ашиг** | | **1,795,843** | **4,684,422** |
| Түрээсийн орлого | 22 | 150,364 | 120,565 |
| Санхүүгийн орлого/(зардал) | 23 | 32,759 | 42,006 |
| Үйл ажиллагааны зардал | 24 | (1,628,571) | (3,108,205) |
| **Үйл ажиллагааны ашиг** | | **350,395** | **1,738,787** |
| Үйл ажиллагааны бус орлого | 25 | 463 | 1,407 |
| Үйл ажиллагааны бус зардал | 26 | (27,890) | (74,659) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | | **300,774** | **1,665,534** |
| Орлогын татварын зардал | 27 | (35,086) | (174,140) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | **287,883** | **1,491,394** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг)** | 28 | **26** | **136** |

**БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

| | Тэм | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|---|
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | **287,883** | **1,491,394** |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй олз/(гарз) | 20 | (174,039) | (771,532) |
| Хэрэгжээгүй олзод ногдох хойшлогдсон татвар | | 17,404 | 77,153 |
| **Дэлгэрэнгүй цэвэр ашиг** | | **131,248** | **797,015** |
| Нэгж хувьцаанд ногдох дэлгэрэнгүйлсэн ашиг | | 12 | 72 |

*Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

| | Хувьцаат капитал мян.төг | Нэмж төлөгдсөн капитал мян.төг | Дахин үнэлгээний нөөц мян.төг | Үнэт цаасны хэрэгжээгүй олз/(гарз) мян.төг | Хуримтлагдсан ашиг мян.төг | Нийт өмч мян.төг |
|---|---|---|---|---|---|---|
| 2012 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 1,100,000 | 2,825,305 | 1,300,244 | 1,251,891 | 2,194,603 | 8,672,042 |
| Алдааны залруулга | - | - | - | - | (20,000) | (20,000) |
| 2012 оны 01 сарын 01-ний залруулсан үлдэгдэл | 1,100,000 | 2,825,305 | 1,300,244 | 1,251,891 | 2,174,603 | 8,652,042 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй гарз | - | - | - | (694,379) | - | (694,379) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | - | - | - | - | 1,491,394 | 1,491,394 |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 1,100,000 | 2,825,305 | 1,300,244 | 557,512 | 3,665,997 | 9,449,057 |
| Шилжээгүй алдагдлын буцаалт | - | - | - | - | (2,195) | (2,195) |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй гарз | - | - | - | (156,635) | - | (156,635) |
| Хуваарилсан ногдол ашиг* | - | - | - | - | (660,000) | (660,000) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | - | - | - | - | 287,883 | 287,883 |
| 2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 1,100,000 | 2,825,305 | 1,300,244 | 400,877 | 3,291,685 | 8,918,111 |

* - Компани 2013 оны 02 сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 08 тоот тогтоолоор 2012 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 60 төгрөгний ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн.

*Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*





2014 07 04

СЭХ
2014 оны 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## "БИДИСЕК" ХК

2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
### Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| *Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Үндсэн ажиллагааны мөнгөн орлого | | |
| Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө | 1,534,718 | 4,284,489 |
| Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө | 124,633 | 15,567 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,526 | 15,857 |
| Бусад мөнгөн орлого | - | 15,454 |
| Харилцагчдаас орж ирсэн мөнгө | 7,685,474 | 133,837,510 |
| Нийт мөнгөн орлогын дүн | 9,346,351 | 138,168,876 |
| *Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага* | | |
| Ажиллагчдад олгосон мөнгө | (396,552) | (321,351) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | (99,910) | (78,064) |
| Түүхий эд, эд материал худалдан авахад төлсөн мөнгө | - | - |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө, холбоо | (99,432) | (36,188) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | (42,768) | (24,437) |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | (294,642) | - |
| Төлсөн хүү, торгууль | - | - |
| Төлсөн орлогын татвар | (43,908) | (339,623) |
| Шимтгэл хураамжид төлсөн мөнгө | (898,404) | (1,618,961) |
| Бусад мөнгөн зарлага | - | (852,967) |
| Харилцагчдад төлсөн мөнгө | (7,676,131) | (134,235,550) |
| Нийт үйл ажиллагааны мөнгөн зарлага | (9,551,746) | (137,507,141) |
| Үндсэн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (205,395) | 661,735 |
| *Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ* | | |
| Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | 1,000 | 6,708 |
| Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | (12,813) | (254,572) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | 941,840 | 1,575,388 |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | (533,237) | (949,074) |
| Хүлээн авсан хүү, ногдол ашиг | 3,312 | 8,189 |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | 400,102 | 386,640 |
| *Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Гаргасан хувьцаа | - | - |
| Бусдаас авсан зээл | 300,000 | 1,572,805 |
| Зээлийн төлөлт | (300,000) | (1,572,805) |
| Төрөл бүрийн хандив | - | (10,000) |
| Мөнгөөр төлсөн ногдол ашиг | - | (550,000) |
| Хүү ба урамшууллын орлого | 10,534 | 28,747 |
| Валютын ханшийн зөрүү | (8,600) | 55,514 |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 1,934 | (475,738) |
| Цэвэр мөнгөн гүйлгээ | 196,641 | 572,637 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 661,214 | 88,577 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 857,856 | 661,214 |

*Хавсаргасан тодруулгууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*





2014 07 04

144

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# "БИДИСЕК" ХК

## 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тэмдэглэл

## 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

"БиДиСек" Хувьцаат компани ("Компани" гэх) нь анх 1991 онд "Баяндэхэм" нэртэйгээр Төв аймгийн Зуунмод хотод иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх ажлыг зохион байгуулах зорилгоор анх байгуулагдсан.

1995 онд хөрөнгийн зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах зорилгоор "БиДиСек" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан бөгөөд 1997 онд компанийн салбарыг Улаанбаатар хотод байгуулсан.

2006 онд "БиДиСек" Хувьцаат Компани болон зохион байгуулагдаж, андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах 2052482 регистр бүхий 9010001030 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2007 оны 8-р сарын 17-ны өдрийн 113 тоот тогтоолоор брокер, дилерийн болон хөрөнге оруулалтын зөвлөгөө өгөх үйл ажиллагааны 3/15 тоот тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан. 2012 оны 6-р сарын 20-ны өдрийн 172 тоот тогтоолоор брокер, дилерийн үйл ажиллагааны, 2013 оны 08-р сарын 17-ний өдрийн 459 тоот тогтоолоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 3 жилийн хугацаагаар сунгасан байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 6-р сарын 12-ны өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авч 2011 оны 6 сарын 12-ны өдрийн 170 тоот тогтоолоор андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасан.

Компанийн 2007 оны 07-р сарын 16-ны Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн хурлаар "БиДиПиИЭф" ХХК-ийг Хөрөнгө оруулалтын чиглэлээр "БиДиСек" ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2007 оны 8-р сарын 15-нд 5157781 регистр бүхий 9011117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

2007 оны 9-р сарын 14-нд "БиДиПиИЭф" ХХК-ийн нэрийг "БиДиСиЭйПи" ХХК болгон өөрчилсөн. "БиДиСиЭйПи" ХХК нь "БиДиСек" ХК-ийн үл хөдлөх хөрөнгийг бусдад түрээслэх үйл ажиллагаа эрхэлж байна.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

"БиДиСек" ХК-ийн 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-оос баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол журам, Сангийн Яам болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар журам, аргачлалын дагуу бэлтгэгдсэн.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь компанийн 2012 оны жилийн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлого болон 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын дагуу түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн ба санхүүгийн хэрэглүүрүүд нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн.

Компанийн бүртгэлийн болоод тайлагнагч валют нь Төгрөг болно. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

9



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

*Тасралтгүй үйл ажиллагааны зарчим*

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Компани тасралгүйгээр үйл ажиллагаагаа явуулна гэсэн өөдрөг төсөөллийн үндсэн дээр бэлтгэсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

## 3. ТАЙЛАН НЭГТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС 10 *Нэгтгэсэн санхүүгийн тайлан*-ийн дагуу нэгтгэгч компани болох "БиДиСек" ХК болон түүний охин компани болох "БиДиСиЭйПи" ХХК-ийн тусдаа бэлтгэгдсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэн илэрхийлж байгаа бөгөөд нэгтгэлд хамрагдаж буй тусдаа санхүүгийн тайлангууд нь ижил хугацаагаар тасалбар болж, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг бодлого баримтлан бэлтгэгддэг.

Компани нь өөр аж ахуйн нэгжийн эсвэл бизнесийн үйл ажиллагаанаас нь өгөөж хүртэхийн тулд санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг зохицуулах эрх мэдэлтэй байх тохиолдолд охин компани гэж ангилагддаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь компаний болон түүний охин компаниудын үр дүнг нэг аж ахуйн нэгж болгон тайлагнадаг. Иймд компани болон охин компанийн хооронд хийгдэж буй ажил гүйлгээнүүдийг бүрэн цэвэрлэдэг.

Санхүүгийн байдлын тайланд нэгдэгчийн тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр зэргийг нь олж авсан өдрөөрх бодит үнэ цэнээр тусгадаг. Худалдан авсан буюу олж эзэмшсэн компаниудын үйл ажиллагааны үр дүнг тухайн хяналт бий болсон өдрөөс эхлэн нэгтгэсэн ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг бөгөөд хяналтгүй болсон өдрөөс эхлэн нэгтгэлээс хасдаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ, толгой болон охин компаниудын санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого болон зардлын ижил төстэй зүйл тус бүрийн дүнг мөр мөрөөр нь нэмж нэгтгэсэн.

Дараах зүйлсийг нэгтгэлээс цэвэрлэж тайлагнасан. Үүнд:

a) Бүлэг доторх компаниудын хоорондын
   - Хөрөнгө, өр төлбөрийн дансдын үлдэгдэл;
   - Орлого болон зардлын дүн;

b) Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ болон өмчийн дүн.

10

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

### 4.1 Тооцоолол ба төсөөлөл

Компани ирээдүйтэй холбоотой тодорхой тооцоолол болон төсөөллүүдийг хийдэг. Тооцоолол ба шийдлийг удирдлагын түүхэн туршлага ба бусад хүчин зүйлст суурилан үнэлдэг бөгөөд үүнд тухайн нөхцөл байдалд ул үндэслэлтэй гэж үзсэн ирээдүйн үйл явдал гарна гэсэн хүлээлт багтана.

Хэрэв өөрчлөлт нь тухайн тайлант хугацаанд эсвэл ирээдүйн хугацаанд нөлөө үзүүлж буй эсвэл тайлант болон ирээдүйн хугацааны аль алинд нөлөө үзүүлж буй бол Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн нөлөөлөл нь өөрчлөлт гарсан тухайн хугацаандаа Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөнө.

Энэхүү тооцоолол ба таамаглал нь бодит байдлаас зөрүүтэй байж болно.

Эдгээр таамаглал, тооцооллууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогууд болон санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүдэд хэрхэн нөлөөлөх талаар доор тодорхойлсон болно.

*a) Хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Компани нь хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт орсон байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгийг ашиглах эсвэл худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг. Бодит үнэ цэнэ нь тухайн арилжааны талаар зохих мэдлэг бүхий сонирхогч талуудын хооронд хөрөнгөө худалдах үнээр тодорхойлогдоно.

*b) Хойшлогдсон татварын хөрөнгийн буцаалт*

Тайлант үед бий болсон алдагдлыг ирээдүйн тайлант үеүд дэх ашгаас буцаан нөхөгдөнө гэсэн төсөөлөлд үндэслэн, ирээдүйн тайлант үеүдэд хүчин төгөлдөр мөрдөгдөх татварын түвшингээр тооцон санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. Монгол улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуульд заасны дагуу дэд бүтэц, уул уурхайн салбарын тайлант жилийн татварын алдагдлыг тайлант жил, түүний өмнөх дараалласан 3 жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан ирээдүйн 4-8 жилийн хугацаанд ямар нэг хязгаарлалтгүйгээр, бусад салбарын хувьд 2 жилийн хугацаанд тухайн жилийн татвар ногдох орлогын 50 хувиас хэтрэхээргүйгээр шилжүүлэн тооцохыг зөвшөөрдөг. Энэ хугацаанд буцаагдаагүй хойшлогдсон татварын хөрөнгийг буцаалтын сүүлийн жилд алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

*c) Болзошгүй байдал*

Ирээдүйд нэг эсвэл хэд хэдэн тодорхойгүй үйл явдал тохиолдохоор бол болзошгүй байдлаар тусгадаг. Ирээдүйн үйл явдлын үр дүнгийн талаарх дүгнэлтийн хэрэглээ, үр ашигтай шийдлийг гаргах зэрэг нь болзошгүй байдал оршин буй эсэхийн үнэлгээ болдог.





2014 07 04

147

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ (үргэлжлэл)

### 4.2 Шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандарт, стандартын тайлбар

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, тодруулгад нөлөөлөхүйц шинэ стандарт, стандартын өөрчлөлт болон стандартын тайлбарын өөрчлөлтийг дор үзүүлэв.

- СТОУС 7 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*, СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр*-ийг 2015 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө. СТОУС 9 нь холимог хэмжүүрийн загварыг хялбарчилсан бөгөөд санхүүгийн хөрөнгөнд зориулж хоёр үндсэн хэмжилтийн: гэрээл болох бодит үнэ цэнэ, хорогдуулалтын өртгийг шинээр гаргаж ирсэн.

- СТОУС 10 *Нэгтгэсэн санхүүгийн тайлан* стандартын зорилго, үйлчлэх хүрээнд нэмэлт өөрчлөлт, Хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгж нэгтгэл хийхгүй байх үндэслэлийг шинээр нэмсэн, 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

- НББОУС 27, *Тусдаа санхүүгийн тайлан* стандартад СТОУС 10 батлагдсантай холбоотойгоор 2013 оны 01 сарын 01 болон 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх анхны гаргалт болон хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжтэй холбоотой нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

- НББОУС 32 *Санхүүгийн хэрэглүүр:* Хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгж өөрийн охин компани, хараат компани болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг санхүүгийн хэрэглүүрээр бүртгэж тайлагнах үндэслэлд нэмэлт өөрчлөлт орсон, 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

- НББОУС 36 *Хөрөнгийн үнэ цэнийн бууралт* Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх өртгийг тодруулахыг шаардсан нэмэлт өөрчлөлт оруулсан, 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

- НББОУС 39 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*-д үүсмэл хэрэглүүр шинэ зүйл нэмж оруулсан, 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

*Тус компани нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ Нягтлан Бодох Бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримтална.*

### 5.1 Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг Компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах бэлтгэл ажиллагааны зардлууд багтах бөгөөд удаан хугацааны бэлтгэл ажил шаардагддаг хөрөнгүүдийн хувьд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг. Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ.
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

Компанийн эзэмшиж буй төв оффисын барилга нь нийт 1,908 $м^2$ талбайтай бөгөөд үүний 578.8 $м^2$ -ыг оффисын зориулалтаар үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэдэг.

*Дараа үеийн зардал*

Сольж тавьсан эд анги, хэсэг нь компанид ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэнд нэмж хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

*Олз болон гарз*

Данснаас хассан хөрөнгийн дансны үнэ болон борлуулсан үнийн зөрүүгээр тайлант хугацааны олз, гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд үндсэн бус үйл ажиллагааны хэсэгт тайлагнана.

*Элэгдэл*

Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

| | |
|---|---|
| Барилга, байгууламж | 40 жил |
| Машин механизм, техник тоног төхөөрөмж | 10 жил |
| Компьютер түүний эд анги, программ хангамж | 3 жил |
| Конторын тавилга, эд хогшил | 10 жил |
| Биет бус хөрөнгө | 4-10 жил |
| Бусад үндсэн хөрөнгө | 5 жил |





2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.2 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (ХОЗҮХХ) гэж капиталын үнийг өсгөх эсвэл түрээсийн орлого олох эсвэл аль альных нь зорилгоор эзэмшиж буй (өмчлөгч эсвэл санхүүгийн түрээсээр түрээслэгчийн) хөрөнгө (газар эсвэл барилга эсвэл барилгын нэг хэсэг, эсвэл аль аль нь)-ийг хэлэх бөгөөд үүнд дор дурдсанаас бусад хөрөнгө багтана:

i. Бараа буюу үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, эсвэл удирдлагын зориулалтаар ашиглаж байгаа; эсвэл
ii. Бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулж байгаа

ХОЗҮХХ-ийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд анхны хэмжилтээс хойшхи үеүдэд дараах зүйлсийн аль нэгийг сонгон хэрэглэхийг зөвшөөрдөг:

i. *Бодит үнэ цэнийн загвар:* Анхны хэмжилтээс хойш бодит үнэ цэнээр нь буюу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг тусгасан дүнгээр хэмжих; эсвэл
ii. *Өртгийн загвар:* Анхны хэмжилтийн дараа үеүдэд элэгдүүлсэн өртөг (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн)- өөр нь бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн загвар нь НББОУС 16 *Үндсэн хөрөнгө*-өөр тодорхойлсон дахин үнэлгээний загвараас ялгаатай бөгөөд бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч орлогын тайланд тусгадаг.

Зарим үл хөдлөх хөрөнгөд түрээсийн орлого олох эсвэл капиталын үнэ цэнийг өсгөх зорилгоор эзэмшиж буй хэсэг болон үйлдвэрлэл эсвэл бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, эсвэл удирдлагын зориулалтаар ашиглахаар эзэмшиж буй бусад хэсэг багтдаг. Хэрэв эдгээр хэсгүүдийг тусад нь борлуулж болохоор байвал аж ахуйн нэгж эдгээр хэсгүүдийг тусад нь бүртгэнэ. Харин тусад нь борлуулах боломжгүй бол уг үл хөдлөх хөрөнгийн өчүүхэн бага хэсгийг бараа үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа тохиолдолд л зөвхөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж үзнэ.

### 5.3 Санхүүгийн хөрөнгө

*i. Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

НББОУС 39-ийн цар хүрээний санхүүгийн хөрөнгүүд нь
(а) ашиг алдагдлаар дамжин бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгүүд;
(б) борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө;
(в) зээл ба урьдчилгаа;
(г) дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилагддаг. Компани нь санхүүгийн хөрөнгүүдийн ангилалыг анхны хүлээн зөвшөөрөлтөнд тодорхойлдог.

Ашиг алдагдлаар дамжин бодит үнээрээ хүлээн зөвшөөрөгддөг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүд нь бодит үнэ цэнэ дээр нь гүйлгээтэй холбоотой шууд хамаарагдах зардлуудын нийлбэрээр хэмжигддэг.

Дүрэм, журмаар тогтоосон эсвэл зах зээл дээр тохиролцсон хугацаанд хөрөнгө нийлүүлэхийг шаарддаг санхүүгийн хөрөнгийн худалдан авалт ба борлуулалтыг арилжааны өдөр буюу Компаний тухайн хөрөнгийг борлуулах буюу худалдан авахаар тогтоосон өдөр хүлээн зөвшөөрдөг.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.3 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

*ii. Дараа үеийн хэмжилт*

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт нь хөрөнгүүдийн ангилалаас хамаарч дараах байдалтай байна. Үүнд:

(а) Ашиг алдагдлаар дамжин бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Ашиг, алдагдал бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(б) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжиж бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн байдлыг тайланд өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Эмчид хуримтлагдсан ашиг, алдагдлыг санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн үед Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(в) Зээл ба авлага нь тогтмол эсвэл тодорхойлж болохоор төлбөртэй, идэвхтэй зах зээлд зарагддаггүй үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм. Эдгээр нь анх бодит үнэ цэнээрээ хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд анхны хэмжилтийн дараа үеүдэд үнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр бүртгэж, санхүүгийн байдлын тайланд толилуулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа санхүүгийн хөрөнгүүдийг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг. Хорогдуулсан өртгийг олз бэлтгэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох хураамж ба зардлуудыг харгалзан үздэг. Үр ашигт хүүгийн түвшний хорогдуулалт нь орлогын тайлангийн санхүүгийн орлогод тусгагддаг. Үнэ цэнийн бууралтаас үүдэлтэй алдагдал нь орлогын тайланд санхүүгийн зардлаар танилцуулагддаг.

(г) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр нь хэмждэг.

*iii. Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн хөрөнгийг дараах нөхцлүүдэд үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал бий болох эрх нь дуусвар болсон.
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн буюу хүлээн авсан мөнгөн урсгалыг хугацаа хоцроолгүй гуравдагч талд буцаан төлөх үүрэг хүлээсэн байх
- Компани нь тухайн хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн байх
- Тухайн хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй буюу хадгалж үлдээгүй боловл тухайн хөрөнгөнд тавих хяналтаа шилжүүлсэн байх

Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн буюу дамжуулах хэлцэлд оролцож байх үед болон тухайн хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй буюу хадгалж үлдээгүй боловч хяналтаа алдаагүй үед, санхүүгийн байнгын оролцоо хэмжээтэй нь уялдуулан энэхүү хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн байна. Энэ тохиолдолд Компани нь холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрдөг. Компанид хэвээр үлдсэн эрх ба үүргийг тусгахуйц суурийн дагуу Шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг хэмжинэ.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.3 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

*iv. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Тайлант хугацаа бүрийн эцэст Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнэ нь буурсан гэсэн биет нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд санхүүжигч санхүүгийн томоохон хүндрэлд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, хувьцааны арилжаа зогссон, хувьцаат компанийн бүртгэлээс хасагдсантай холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

### 5.4 Санхүүгийн өр төлбөр

Компанийн санхүүгийн өр төлбөрт худалдааны болон бусад өр төлбөр, урт болон богино хугацаат банкны зээл зэрэг хамаарна.

*i. Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Анхны хүлээн зөвшөөрөлтөөр Компани нь санхүүгийн өр төлбөрүүдийнхээ ангиллыг тодорхойлдог. Санхүүгийн бүх өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр олж бэлтгэхтэй холбоотой шууд хамаарагдах зардлуудын нийлбэрээр хэмждэг.

*ii. Дараагийн хэмжилт*

Дараагийн хэмжилт нь санхүүгийн өр төлбөрийн ангилалаас шалтгаалах бөгөөд хорогдуулсан өртгөөр хэмжигддэг.

*iii. Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн өр төлбөрийн үүрэг цуцлагдсан, хугацаа нь дууссан эсвэл үүргээс чөлөөлөгдсөн тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг. Анхны өр төлбөрийн дансны үнэ болон [illegible] тооцоолсон дүн хоёрын зөрүүг орлогын тайланд олз, гарзаар хүлээн зөвшөөрч, тайлагнадаг.

### 5.4 Эрсдлийн нөөц

[illegible] Компани эрсдлийн нөөцийг хувь нийлүүлсэн хөрөнгийн 3%-тай тэнцэх хэмжээгээр байгуулж, эрсдлийн зардлыг нөөц байгуулсан тайлант жилийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.5 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь тайлант хугацаанд эзэмшиж буй санхүүгийн болон брокерын программ хангамжийн дүнг илэрхийлнэ. Программ хангамжийг тэдгээрийн эдийн засгийн бодит ашиглалтын хугацаанд, тусгай зөвшөөрлийг түүний хүчинтэй байх хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулж бүртгэдэг.

### 5.6 Бараа материал

Бараа материал нь бичиг хэргийн материал, аж ахуйн материал гэсэн хангамжийн зүйлээс бүрдэнэ. Бараа материалыг байнгын системээр бүртгэдэг.

### 5.7 Худалдааны ба бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд дансны болон бусад авлагуудыг өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд авлагын үнэгүйдлийг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ. Худалдааны болон бусад авлагын үнэгүйдлийн хасагдуулга нь компани авлагын анх үүссэн үеийн нөхцлийн дагуу бүрэн хэмжээгээр цуглуулж чадахгүй байж магадгүй гэсэн бодит нотолгоонд суурилан тогтоодог. Хасагдуулгын дүн нь дансны үнэ ба таамагласан мөнгөн урсгалыг ижил төрлийн зээл борлуулалтын зах зээлийн хүүгийн түвшингээр хорогдуулсан өгөгдлийн үнэ цэнээр тогтоосон эргэн нөхөгдөх дүнгийн хоорондын зөрүү юм. Хасагдуулгын дүнг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютаарх авлагын дансны үнийг тайлангийн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж тодорхойлно. Тайлант хугацааны дундуур гадаад валютаар төлсөн авлагыг төгрөгт шилжүүлэх ханшийн зөрүүгийн бодит олз ба гарзыг тооцно.

### 5.8 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгүүд нь бэлэн мөнгө болон бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлс, 3 сар хүртэл хугацаатай хадгаламжаас бүрдэнэ.

### 5.9 Худалдааны ба бусад өглөг

Худалдааны ба бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.





2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.10 Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь компанийн гаргасан энгийн хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигддэг. Хувьцаат капиталыг балансад тусгахдаа гаргахаар зарласан, худалдагдсан, эргүүлэн авсан болон нийт гаргаад байгаа хувьцаануудын нэрлэсэн үнийн дүнг нэмж тодруулдаг.

Энгийн хувьцааны нэрлэсэн үнээс давсан хэсгийг нэмж төлөгдсөн капиталаар бүртгэдэг. Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур борлуулвал хүлээсэн алдагдлын хэмжээг нэмж төлөгдсөн капиталд сөрөг тэмдэгтэйгээр харуулна.

### 5.11 Ногдол ашиг

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчдийн компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгний ногдол ашиг олгохыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол компанийн жилийн цэвэр ашгийн 20-иос доошгүй хувиар ногдол ашиг хуваарилж байхаар дүрэмдээ тусгасан.

### 5.12 Орлого

*i. Үйлчилгээний орлого*

Андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний орлого нь үйл ажиллагааны үндсэн орлого байна. Орлогыг НББОУС 18 *Орлого*-ын дагуу компани ирээдүйд эдийн засгийн өгөөж хүртэх магадлалтай, орлогын дүнг үнэн зөв найдвартай хэмжих боломжтой үед бодит үнэ цэнээр нь аккруэл суурийг ашиглаж хүлээн зөвшөөрдөг.

*ii. Хүү, эрхийн шимтгэл ба ногдол ашиг*

Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашгийн орлого нь компанийн өмчлөл, эзэмшил дэх хөрөнгийн өгөөжийг илэрхийлнэ. Тэдгээрийг НББОУС 18 *Орлого*-ын дагуу орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой үед хүлээн зөвшөөрдөг.

154

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.13 Орлого (үргэлжлэл)

iii *Түрээсийн орлого*

НББОУС 17 *Түрээс*-ийн дагуу дараах шалгуур хангасан тохиолдолд түрээсийг санхүүгийн түрээс, бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үүнд:

- Түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгө түрээслэгчид шилжих;
- Түрээслэгч түрээсийн хөрөнгийг зах зээлийн үнээс бага үнээр тогтоосон хугацаанд худалдан авах сонголттой байх;
- Түрээсийн хугацаа нь түрээсийн хөрөнгийн дийлэнх хугацааг хамарч байх;
- Хамгийн бага түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь түрээсийн хөрөнгийн зах зээлийн үнэтэй ойролцоо байх:
  Түрээсийн хөрөнгийг тухайн түрээслэгч л томоохон хэмжээний нэмэлт өөрчлөлт хийлгүйгээр ашиглах боломжтой онцгой шинж чанар бүхий хөрөнгө байх;
- Түрээсийн хөрөнгийн үлдэх өртгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзыг түрээслэгч хүлээх;
- Түрээслэгч нь түрээсийг цаашид үргэлжлүүлэх боломжтой байх;
- Түрээслэгч түрээсийн гэрээг цуцалснаас түрээслүүлэгчид учирсан хохирлыг хариуцах бол.

Компанийн одоогийн үл хөдлөх хөрөнгө түрээслүүлэх ажил гүйлгээ нь үйл ажиллагааны түрээсээр ангилагдаж байгаа бөгөөд олох түрээсийн орлогыг нийт түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар тооцож, орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

### 5.13 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Компанийн бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Компанийн бүртгэлийн валютаас бусад валютаар илэрхийлэгдсэн орлого, зардлыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн ханшийг үндэслэн, санхүүгийн тайлангийн өдрөөрх гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөр эргэн төлөгдөх авлага ба мөнгөн өр төлбөрүүд нь тайлагнах өдрийн гадаад валютын албан ханшаар хөрвүүлэгдэнэ. Гадаад валютаар гарсан мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг тухайн гүйлгээ гарсан өдрийн түүхэн ханшаар хөрвүүлдэг. Бодит үнэ цэнээр тайлагнагддаг мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн түүхэн ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютаарх ажил гүйлгээг хөрвүүлэхтэй холбоотой үүсэх бүх олз, гарзууд нь Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд тайлагнагддаг.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.14 Санхүүгийн зардал

Санхүүгийн зардалд зээлийн хүүний зардал хамаарна. Бэлтгэл ажиллагаа, хугацаа шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтайгаар өөр бусад хөрөнгийн өртөгт багтсанаас бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд тусгана.

Барьж босгоход хугацаа шаардагдах хөрөнгийн өртөгт багтаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах үйл ажиллагаанаас гарч буй зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг. Харин энэхүү зээлийн өртгийн капиталжуулалтыг тухайн хөрөнгийг барьж босгох үйл явц зогссон юмуу бүрэн дууссан үед зогсоодог.

### 5.15 Түрээсийн зардал

Түрээслэсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг компани хүртэх тохиолдолд тухайн түрээсийг санхүүгийн түрээс, бусад тохиолдолд үйл ажиллганааы түрээс гэж ангилна.

Санхүүгийн түрээсийн үед, түрээсийн хөрөнгийн анх хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөх дүн нь түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хугацаанд төлөгдөх түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль бага байна. Түрээстэй холбоотой үүрэг хариуцлага нь өглөгөөр тайлагнагдана.

Үйл ажиллагааны түрээсийн үед, түрээстэй холбоотой бүх төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын арга дээр үндэслэн Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд зардлаар тайлагнана.

### 5.16 Орлогын албан татварын зардал

Орлогын [illegible] татварын зардал нь балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувиар тооцсон тайлант жилийн болон хойшлуулсан татвараас бүрдэнэ. Нягтлан бодох бүртгэлийн болон татварын зорилгоор тооцсон орлого, зардлын түр зөрүүний улмаас хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүсдэг. Мөн тайлант жилийн алдагдлыг дараа үеүдрүү шилжүүлэхдээ, ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба тухайн тайлант жил, түүний өмнөх дараалласан 3 хүртэлх жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнд үндэслэн ирээдүйн 4-8 жилийн хугацаанд шилжүүлэн тооцно. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрийн эцэст [illegible] холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.17 Нэгж хувьцаанд ногдох ашиг/алдагдал

Нэгж хувьцаанд ногдох ашиг(алдагдал) нь компанийн тайлант жилийн турш эргэлтэнд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрт ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Компани аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг(алдагдал)-ийн тооцоог мөн хийж тайлагнана.

### 5.18 Хувьцаанд суурилсан төлбөр

Хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээгээр хүлээн авсан буюу худалдан авч эзэмшсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бараа, бүтээгдэхүүнийг олж эзэмшсэн эсвэл үйлчилгээг хүлээн авсан үед хүлээн зөвшөөрдөг. Өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний хувьд, бодит үнэ цэнийг найдвартай тооцох боломжгүйгээс бусад тохиолдолд, компани хүлээн авсан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ болон өмчийн холбогдох өсөлтийг тухайн хүлээн авсан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжинэ. Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний хувьд, хүлээн авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үүссэн өр төлбөрийг хэмжихдээ өр төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Өр төлбөрийг төлж барагдуулах хүртэл, тайлагналын үеийн эцэс бүрт болон барагдуулах өдрөөр өр төлбөрийн бодит үнэ цэнийг дахин хэмжиж тухайн тайлагналын үед үнэ цэнэд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээгээр дамжуулан хүлээн авсан буюу олж эзэмшсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангахгүй байвал зардал гэж хүлээн зөвшөөрдөг.

Ажилчидтай хийсэн хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний хувьд, хүлээн авсан үйлчилгээний бодит үнэ цэнийг шууд хэмжихэд хүндрэлтэй учраас компани хүлээн авсан ажилчдын үйлчилгээний бодит үнэ цэнийг зөвшөөрсөн өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн жишгээр хэмжинэ. Энэхүү бодит үнэ цэнийн жишиг нь, тухайн ажил гүйлгээний талаар зохих мэдлэг бүхий арилжаанд оролцоход бэлэн талуудын ашиглаж болох байсан үнэ цэнэ байна.

Ажилчдаас бусад талуудтай хийсэн ажил гүйлгээний хувьд, бараа бүтээгдэхүүнийг олж эзэмшсэн буюу харилцагч тал үйлчилгээ үзүүлсэн өдрийн бодит үнэ цэнээр, бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд бодит үнэ цэнийн жишгээр хэмждэг.

Бүлгийн тогтоож өөр аж ахуйн нэгж бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авах үед хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний төлбөрийг барагдуулж буй аж ахуйн нэгж төлбөрийг өөрийн өмчийн хэрэглүүр гаргах замаар барагдуулж байгаа тохиолдолд л уг ажил гүйлгээг өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээгээр хүлээн зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд, ажил гүйлгээг мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээгээр хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн авсан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ, мөн өмчид гарсан холбогдох өсөлтийг хүлээн зөвшөөрсний дараа, баталгаажих өдрөөс хойш аж ахуйн нэгж нийт өмчийн дүнд дараагийн тайлант үеүүдэд ямар тохируулга хийхгүй.





2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.19 Сегментийн тайлагнал

Үйл ажиллагааны сегмент гэдэг нь
(а) Орлого олж, зардал гаргадаг бизнесийн үйл ажиллагаа,
(б) Сегментэд нөөц хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой шийдвэр гаргах зорилгоор аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргагч ахлах ажилтаны зүгээс үйл ажиллагааны үр дүнг нь тогтмол хянаж байдаг,
(в) Тусдаа санхүүгийн мэдээлэл бэлтгэх боломжтой.

Компани дараах газарзүйн сегментүүдтэй:
- Экспресс Тауэр
- Төв аймаг аймаг
- Орхон аймаг
- Дорноговь аймаг
- Дархан-Уул аймаг
- Архангай аймаг
- Хөвсгөл
- Сэлэнгэ
- Булган

Салбар хоорондын тооцоогоор үүссэн өглөг, авлагыг салбар нэгж тус бүр дээр нэрийн данс нээж бүртгэх бөгөөд салбаруудын үлдэгдлийг цэвэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

### 5.20 Холбоотой тал

Хэрэв тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компаний хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

Тус компани нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:
i. Охин болон хараат компаниуд;
ii. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагууд, тэдгээрийн гэр бүлийн ойр дотны гишүүд



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 5.21 Холбоотой тал (үргэлжлэл)

Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой. Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

(а) Худалдан авалт
(б) Борлуулалт
(в) Түрээс
(г) Зээл
(д) Баталгаа, барьцааны нөхцлүүд
(е) Хэрэв ирээдүйд тодорхой нэг үйл явдал хэрэгжих эсвэл хэрэгжээгүй үед ямар нэг үүрэг хүлээх амлалт
(ж) ААН-ийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс ААН өр төлбөрийг барагдуулах

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

### 5.21 Ажилчдын тэтгэмж

*Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал*

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

## 6. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР-ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Компани нь үйл ажиллагааны явцад дараах санхүүгийн эрсдлүүдэд өртөх магадлалтай. Үүнд:

- Өрийн эрсдэл
- Бодит үнэ цэнийн болон хүүгийн түвшний эрсдэл
- Гадаад валютын эрсдэл
- Зах зээлийн бусад үнийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл.

Компани нь бусад бизнесүүдийн нэгэн адил санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсэх эрсдлүүдтэй тулгардаг. Энэ тэмдэглэлд Компанийн эрсдлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарлана. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллийг санхүүгийн тайланд зохих ёсоор тэмдэглэсэн.

Энэ тэмдэглэлд дурдаагүй л бол компанийн өмнө тулгарсан санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл, түүнтэй холбоотой бодлого, эдгээр эрсдлийг зохицуулах процесс эсвэл түүнийг хэмжихэд хэрэглэгдэж буй аргуудад ямар нэгэн томоохон өөрчлөлт ороогүй болно.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 6. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

### i. *Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүд*

Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл үүсч болох Компанийн ашиглаж буй санхүүгийн үндсэн хэрэглүүр нь дараах санхүүгийн хэрэглүүрүүдийг агуулна. Үүнд:

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
- Богино хугацаат хөрөнгө оруулалт
- Худалдааны ба бусад авлага
- Урт хугацаат хөрөнгө оруулалт
- Урт хугацаат авлага
- Худалдааны ба бусад өглөг
- Урьдчилж орсон орлого

### ii. *Ангилал тус бүрээрх санхүүгийн хэрэглүүрүүд*

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Санхүүгийн хөрөнгө | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 857,856 | 661,214 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 4,096,218 | 4,387,242 |
| Худалдааны ба бусад авлага | 1,268,499 | 872,201 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,081 | 2,081 |
| Урт хугацаат авлага | 104,261 | 108,867 |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **6,327,915** | **6,031,605** |
| Санхүүгийн өр төлбөр | | |
| Худалдааны болон бусад өглөг | 104,459 | 202,030 |
| Урьдчилж орсон орлого | 10,000 | 20,000 |
| **Нийт санхүүгийн өр төлбөр** | **114,459** | **222,030** |
| **Цэвэр санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр)** | **6,213,456** | **5,809,575** |

### iii *Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хэрэглүүрүүд*

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй санхүүгийн хэрэглүүр нь мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны ба бусад авлага, худалдааны ба бусад өглөг, зээл зэргийг агуулна.

Богино хугацааны шинж чанараас хамаарч мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны ба бусад авлага, худалдааны ба бусад өглөг зэрэг нь бодит үнэ цэнэтэй нь ойролцоо байдаг.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01





## 6. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

*Ерөнхий зорилго, бодлого ба үйл явц*

Удирдлага нь Компанийн эрсдлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байдаг.

Удирдлагын гол зорилго нь Компанийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд хэт нөлөөлөхгүйгээр эрсдлийг аль болох бууруулах бодлого тогтоох явдал юм. Энэхүү бодлоготой холбоотой нэмэлт мэдээллийг доор үзүүлэв:

**a. Зээлийн эрсдэл**

Зээлийн эрсдэл гэдэг нь үйлчлүүлэгч эсвэл санхүүгийн хэрэглүүр дэх бизнесийн түнш нь гэрээгээр заасан өр төлбөр төлөх үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Компанид санхүүгийн гарз үүсгэх эрсдэл юм.

Зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн томоохон дүн нь худалдааны ба бусад авлага (*Тэмдэглэл* 9)-ын 1,179,151 мянган төгрөг (2012 онд: 877,655 мянган төгрөг)-ийн үлдэгдэлд төвлөрч байна. Үүний 41 хувь буюу 484,982 мянган төгрөгийн дүн нь "Дархан Хөвөн" ХК-иас авах авлага болно.

**b. Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл нь тухайн байгууллагад учирч болох гадаад хүчин зүйл буюу хөрөнгийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, хууль зүй, татварын бодлого гэх мэт зах зээлийн орчноос хамаарч байгаа эрсдэл юм.

Тайлант жилд Үнэт цаасны Зах Зээлийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт орсон.

**c. Хүүний түвшний эрсдэл**

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Компанид хүүний түвшний өөрчлөлтөөс хүлээх эрсдэл одоогоор байхгүй.

**c. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл**

Компанийн Монгол улсын мөнгөн тэмдэгт (төгрөг)-ээс өөр валютаар хийж буй хөрөнгө оруулалт буюу бусдад олгосон зээл, санхүүжилт буюу банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, худалдан авалт болон борлуулалтанд гадаад валютын эрсдэл учирч болно. Эрсдэлд өртөж болох валют нь АНУ-ын доллар, БНХАУ-ын юань, Европын холбооны улсуудын евро болно. Гадаад валютын ханшийн хэт хэлбэлзэл нь тус компанийн санхүүгийн байдал, мөнгөн урсгалд нөлөөлөх магадлалтай.

Тайлант жилүүдийн явцад ашиглагдаж байсан төгрөгтэй харьцах ханшийг дор үзүүлэв.

| Валют | Дундаж ханш | | Хаалтын ханш | |
|---|---|---|---|---|
| | 2013 он | 2012 он | 12/31/2013 | 12/31/2012 |
| Ам.доллар | 1,523.93 | 1,359.24 | 1,654.10 | 1,392.10 |
| Юань | 248.03 | 215.48 | 272.88 | 223.39 |
| Евро | 2,026.36 | 1,748.47 | 2,275.63 | 1,835.83 |





2014 07 04

161

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 6. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

### е. Хөрвөх чадварын эрсдэл

Компани нь санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах чадваргүй болох, эсвэл түүний үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдал үүсэх эрсдэл юм.

Компанийн баримтлах бодлого бол үүргийн гүйцэтгэлийн хугацааны эцэст түүнийг барагдуулах хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд компани нь дор хаяж 45 хоногт хүлээгдэж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй (эсвэл харилцан тохиролцсон хэрэглүүр) байх явдал юм.

Түргэн хөрвөх чадварын эрсдэл нь Компанийн мөнгөн урсгалыг удирдах чадвараас үүсдэг. Компани түүний жилийн төсвийг мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг үнэлсний үндсэн дээр баталдаг.

162

СЭХ
2014 оны 07 сарын 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 7. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Бэлэн мөнгө | 16,301 | 1,211 |
| Баталгааны сан* | 26,307 | 15,798 |
| Барьцаанд байршуулсан мөнгө** | 57,500 | 137,500 |
| Харилцах дансанд байршуулсан мөнгө | 672,572 | 417,109 |
| Хувьцааны арилжааны данс | 52,176 | 56,596 |
| Эрсдлийн санд байршуулсан мөнгө*** | 33,000 | 33.000 |
| | 857,856 | 661,214 |

* -Компанийн сүүлийн 3 сард хийсэн үнэт цаасны өдрийн дундаж арилжааг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг ҮЦТТТХТ-д байршуулдаг.

** - Арилжааны банкинд байршуулсан үнэт цаасны төлбөрийн барьцаа.

*** - Үнэт цаасны болзошгүй эрсдлээс хамгаалах зориулалттайгаар Арилжааны банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө.

## 8. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Энгийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 3,683,699 | 3,800,684 |
| Эрхийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 100 | 100 |
| Бодит үнэ цэнийн тохируулга | 445,419 | 619,458 |
| Болзошгүй эрсдлээс хамгаалах сан | (33,000) | (33,000) |
| | 4,096,218 | 4,387,242 |

Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын дүнд Монголын Хөрөнгийн Бирж дээрх арилжаа нь зогссон компаниуд дахь хөрөнгө оруулалт 211,210 мянган төгрөг (2012: 212,302 мянган төгрөг) болон Хувьцаат компанийн бүртгэлээс хасагдсан компаниуд дахь хөрөнгө оруулалт 1,098 мянган төгрөг (2012: [illegible] мянган төгрөг)-ийн хөрөнгө оруулалт бүртгэгдсэн байгаа бөгөөд тэдгээр нь бодит үнэ цэнээрээ бус өртгөөрөө илэрхийлэгдсэн байгаа.

Дээрх Монголын Хөрөнгийн Бирж дээрх арилжаа нь зогссон хувьцаат компаниуд дахь хөрөнгө оруулалтын дүнд "Зоос банк" ХК-ийн энгийн хувьцаан дахь хөрөнгө оруулалт болох 206,061 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт бүртгэлтэй байна. Энэхүү хөрөнгө оруулалтаас дахин өгөөж хүртэнэ гэсэн бодитой нотолгоо байхгүй байна. *Тэмдэглэл 31* Болзошгүй алдагдал (а) үз.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 9. ХУДАЛДААНЫ БА БУСАД АВЛАГА

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Худалдааны авлага* | 1,237,048 | 788,036 |
| Ажилчидтай хобоотой авлага | 5,604 | 9,961 |
| Барьцааны авлага | 1,505 | 1,505 |
| НДШ-ийн илүү төлөлт | 1,247 | - |
| Бусад авлага | 23,096 | 72,698 |
| | 1,268,499 | 872,201 |

* - *Тэмдэглэл 30* Болзошгүй үйл явдал ба томоохон хэлцэл-д тусгагдсан "Хай Би Ойл" ХК-иас авах 3[illegible]7,262 мянган төгрөгийн хувьцаанд хөрвөх зээл багтсан.

Мөн энэхүү худалдааны авлагын дүнд *Тэмдэглэл 31* Болзошгүй алдагдал (б),(в)хэсэгт тусгагдсан "Дархан Хөвөн" ХК-иас авах авлагын 484,982 мянган төгрөг, Силикат ХК-иас авах 94,803 мянган төгрөгийн дүн багтсан байгаа болно.

Худалдааны авлагын дүнд багтсан холбоотой талуудаас авах авлагын дүнг харуулвал:

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| [illegible] Ай ХХК | 114,357 | 116,671 |
| Хувь нийлүүлэгчид болон гүйцэтгэх удирдлага | 10,560 | 31,912 |
| | 124,917 | 148,583 |

10. ӨМЧ, БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ- ЦЭВЭР

| | Барилга, байгууламж | Газрын сайжруулалт | Тоног төхөөрөмж | Компьютер тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга, эд хогшил | Бусад үндсэн хөрөнгө | Нийт үндсэн хөрөнгө |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **ӨРТӨГ** | | | | | | | | |
| 2012 оны 01 сарын 01 | 2,799,284 | 690,586 | 101,786 | 90,440 | 190,787 | 69,646 | 37,690 | 3,980,219 |
| Худалдаж авсан | - | - | - | 5,343 | 245,328 | 1,648 | 2,343 | 254,662 |
| Худалдсан/данснаас хассан | - | - | - | (1,285) | (17,399) | (1,846) | - | (20,530) |
| 2012 оны 12 сарын 31 | 2,799,284 | 690,586 | 101,786 | 94,498 | 418,716 | 69,449 | 40,033 | 4,214,352 |
| Худалдаж авсан | - | - | - | 5,861 | - | 2,692 | 1,420 | 9,973 |
| 2013 оны 12 сарын 31 | 2,799,284 | 690,586 | 101,786 | 100,359 | 418,716 | 72,140 | 41,453 | 4,224,325 |
| **ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ** | | | | | | | | |
| 2012 оны 01 сарын 01 | (163,906) | - | (38,326) | (53,274) | (51,907) | (10,955) | (8,373) | (326,740) |
| Байгуулсан | (190,604) | - | (7,367) | (19,880) | (7,043) | (6,985) | (6,544) | (238,422) |
| Данснаас хассан | - | - | - | - | 11,338 | - | - | 11,338 |
| 2012 оны 12 сарын 31 | (354,509) | - | (45,693) | (73,154) | (47,612) | (17,939) | (14,917) | (553,824) |
| Байгуулсан | (208,099) | - | (7,367) | (14,914) | (32,803) | (4,606) | (6,090) | (273,607) |
| 2013 оны 12 сарын 31 | (562,609) | - | (53,060) | (88,068) | (80,415) | (22,545) | (21,007) | (827,431) |
| **ДАНСНЫ ҮНЭ** | | | | | | | | |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2,444,775 | 690,586 | 56,093 | 21,344 | 371,104 | 51,509 | 25,116 | 3,660,528 |
| 2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2,236,676 | 690,586 | 48,726 | 12,291 | 338,301 | 49,596 | 20,446 | 3,396,621 |



СЭХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01



2014 07 04

164

165

СЗХ
2014 оны 07 сарын 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ - ЦЭВЭР

| | Санхүүгийн программ хангамж мян.төг | Брокерийн программ хангамж мян.төг | Нийт биет бус хөрөнгө мян.төг |
|---|---|---|---|
| **ӨРТӨГ** | | | |
| 2012 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 650 | 2,900 | 3,550 |
| Нэмэгдсэн хөрөнгө | - | - | - |
| Хасагдсан хөрөнгө | - | - | - |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 650 | 2,900 | 3,550 |
| Нэмэгдсэн хөрөнгө | - | 2,840 | 2,840 |
| Хасагдсан хөрөнгө | - | - | - |
| 2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 650 | 5,740 | 6,390 |
| **ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ** | | | |
| 2012 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | (540) | (960) | (1,500) |
| Тайлант жилд байгуулсан хорогдол | (65) | (725) | (790) |
| Данснаас хассан хорогдол | - | - | - |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | (605) | (1,685) | (2,290) |
| Тайлант жилд байгуулсан хорогдол | (45) | (725) | (770) |
| Данснаас хассан хорогдол | - | - | - |
| 2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | (650) | (2,410) | (3,060) |
| **ДАНСНЫ ҮНЭ** | | | |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 45 | 1,215 | 1,260 |
| 2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | - | 3,330 | 3,330 |

## 12. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Монгол 999 ХХК | 1,000 | 1,000 |
| Эл Ай ХХК | - | 1,000 |
| Бусад* | 81 | 81 |
| | 1,081 | 2,081 |

* - энэхүү дүн нь 2011 оноос өмнө Хувьцаат Компанийн хэлбэрээс Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болон өөрчлөн зохион байгуулагдсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын өртгийг илэрхийлнэ.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 13. УРТ ХУГАЦААТ АВЛАГА

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Орон сууцны зээл* | 95,647 | 95,647 |
| Бусад** | 8,615 | 13,221 |
| | 104,261 | 108,867 |

* - Компани ажилчиддаа орон сууц худалдан авахад зориулан олгосон зээлийн дүнг илэрхийлнэ. Энэхүү зээл нь хүүгүй бөгөөд 2015 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй.

** - Авто машин худалдан авах болон бусад зориулалтаар ажилчдад олгосон зээлийн урт хугацаанд төлөгдөх хэсгийг илэрхийлнэ. Энэхүү зээл нь хүүгүй бөгөөд сар бүрийн тогтмол хэмжээний эргэн төлбөрийг ажилчдын цалингаас суутгадаг.

## 14. ХУДАЛДААНЫ БА БУСАД ӨГЛӨГ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Худалдааны өглөг | 31,258 | - |
| Аж ахуйн нэгжид өгөх өглөг* | 44,298 | 174,373 |
| Ажиллагсадтай холбоотой өглөг | 17,418 | 18,296 |
| Барьцааны өглөг | 11,485 | 6,411 |
| Бусад өглөг | - | 950 |
| | 104,459 | 202,030 |

* - 2013 онд 44,298 мянган төгрөгийн өглөг (2012: 44,298 мянган төгрөг) нь *Тэмдэглэл 9 Худалдааны ба бусад авлага*-д тусгагдсан "Дархан Хөвөн" ХК-иас авах авлагыг цуглуулсаны дараа түүнээс "БиДиПиИЭф" ХХК-д өгөх өглөгийн дүнг илэрхийлнэ.

## 15. БУСАД ТАТВАРЫН ӨГЛӨГ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| ХХОАТ-ын өглөг | 11,288 | 9,120 |
| ЭМНДШ-ийн өглөг | - | 7,478 |
| НӨАТ-ын өглөг | 1,408 | 590 |
| | 12,696 | 17,187 |





2014 07 04

167

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 16. НОГДОЛ АШГИЙН ӨГЛӨГ

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | - | 550,000 |
| Тайлант жилд зарласан ногдол ашиг | 660,000 | - |
| Тайлант жилд олгосон ногдол ашиг | - | (550,000) |
| Эцсийн үлдэгдэл | 660,000 | - |

Компани 2013 оны 02 сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 08 тоот тогтоолоор 2012 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 60 төгрөгний ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн.

## 17. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨГЛӨГ

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 61,946 | 139,099 |
| Тайлант жилд хэрэгжсэн түр зөрүү | (17,404) | (77,153) |
| Эцсийн үлдэгдэл | 44,542 | 61,946 |

## 18. ХУВЬЦААТ КАПИТАЛ

Компанийн хувьцаат капитал нь 2013 оны 12-р сарын 31-ний байдлаар 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,000,000 ширхэг зөвшөөрөгдсөн буюу гаргасан энгийн хувьцаанаас бүрдэж байна.

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Энгийн хувьцаа (зөвшөөрөгдсөн 11,000,000 ширхэг, гаргасан 11,000,000 ширхэг) | 11,000,000 | 11,000,000 |
| Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөг) | 100 | 100 |
| Нэгж хувьцаанд нэмж төлөгдсөн капитал (төгрөг) | 257 | 257 |
| | 3,925,305 | 3,925,305 |



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 18. ХУВЬЦААТ КАПИТАЛ (үргэлжлэл)

Компанийн хувьцааны тархалт 2013 оны 12-р сарын 31-нээр дараах байдалтай байна.

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмшиж буй хувьцааны тоо Ширхэг | Эзэмшлийн хувь Хувь |
|---|---|---|
| АНУ-ын иргэн Alexander Zwahr | 3,080,500 | 28% |
| Монгол Улсын иргэн Д.Даянбилгүүн | 2,708,110 | 26% |
| АНУ-ын Firebird Master Fund хөрөнгө оруулалтын сан | 1,054,301 | 10% |
| Firebird Master Fund Holding | 576,035 | 5% |
| Firebird Global Master Fund | 475,276 | 4% |
| Монгол Улсын иргэн Б.Лхагвадорж | 473,963 | 4% |
| Монгол Улсын иргэн Д.Амгаланбаяр | 332,129 | 3% |
| Монгол Улсын иргэн Н.Батгэрэл | 329,367 | 3% |
| Пи Би Си ХХК | 325,464 | 3% |
| Бусад жижиг хувьцаа эзэмшигчид | 1,644,855 | 14% |
| | 11,000,000 | 100% |

2013 оны 05-р сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн. Одоогоор хувьцаа гаргалтын бэлтгэл ажил явагдаж байна.

## 19. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

Компани нь 2008 онд "Нимм Аудит" ХХК, 2011 онд "Пантеон" ХХК-иар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд хөрөнгийн үнэлгээний нэмэгдлийг энэхүү дансанд тусгасан болно.

## 20. ҮНЭТ ЦААСНЫ ХЭРЭГЖЭЭГҮЙ ОЛЗ/(ГАРЗ)

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 557,512 | 1,251,891 |
| Тайлант хугацааны эцсээрх үнэт цаасны үнийн өсөлт/(бууралт) | (156,635) | (694,379) |
| Эцсийн үлдэгдэл | 400,877 | 557,512 |

169

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 21. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Андеррайтерийн үйл ажиллагааны орлого | 206,833 | 67,114 |
| Брокерийн үйл ажиллагааны орлого | 1,173,059 | 4,119,921 |
| Дилерийн үйл ажиллагааны орлого | 941,840 | 1,575,388 |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагааны орлого | 124,333 | 15,567 |
| | 2,446,064 | 5,777,990 |

## 22. ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

Компани Сүхбаатар дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэр Залуучуудын өргөн чөлөө дэх өөрийн эзэмшлийн оффисын барилгын 3-аас 5-р давхрын нийт 578.8м$^2$ талбайг богино хугацаатайгаар 1м$^2$-ыг дунджаар 22 мянган төгрөгөөр үйл ажиллагааны түрээсээр түрээслэдэг. Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн охин компани болох "БиДиСиЭйПи" ХХК нь оффисын түрээсийн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг.

## 23. САНХҮҮГИЙН ОРЛОГО/(ЗАРДАЛ)

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Харилцах, хадгаламжийн хүүний орлого | 14,454 | 28,747 |
| Зээлийн хүүний орлого | 21,486 | - |
| Бондын хүүний орлого | 115 | 7,131 |
| Ногдол ашгийн орлого | 3,197 | 1,059 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз | 29,364 | 167,328 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз | (28,399) | (160,647) |
| Зээлийн хүүний зардал | (7,459) | (1,612) |
| | 32,759 | 42,006 |



2014 07 04

СЗХ
2014 оны 07 сарын 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 24. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 505,525 | 395,178 |
| Нийгмийн даатгалын зардал | 56,693 | 43,814 |
| Засвар үйлчилгээ, сэлбэгийн зардал | 23,187 | 32,507 |
| Ашиглалтын зардал | 79,395 | 79,694 |
| Харуул хамгаалалтын зардал | 17,468 | - |
| Сургалтын зардал | 8,733 | 5,865 |
| Томилолтын зардал | 133,062 | 25,065 |
| Тээврийн зардал | 34,375 | 24,437 |
| Элэгдлийн зардал | 274,650 | 239,184 |
| Зар сурталчилгааны зардал | 22,558 | 62,479 |
| Шуудан холбооны зардал | 25,071 | 10,993 |
| Шимтгэл, хураамжийн зардал | 367,022 | 2,063,750 |
| Бусад зардал | 80,831 | 125,239 |
| | 1,628,571 | 3,108,205 |

## 25. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Үндсэн хөрөнгө борлуулснаас үүссэн олз | - | 407 |
| Бусад | 463 | 1,000 |
| | 463 | 1,407 |

## 26. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Үйл ажиллагааны бус бусад зардал | 27,509 | 58,575 |
| [illegible] зардал | 380 | 4,718 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | - | 1,366 |
| Хандив тусламж | - | 10,000 |
| | 27,890 | 74,659 |





2014 07 04

## "БИДИСЕК" ХК

2013 оны 12 сарын 31-нийн өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тэмдэглэл (үргэлжлэл)

### 27. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Компани нь Монгол Улсын ААНОАТатварын хуулийн дагуу 3 тэрбум хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 3 тэрбумаас давсан татвар ногдох орлогод 25 хувийн ААНОАТ-ийн орлогын татвар төлөх үүрэгтэй.

| | "БиДиСек" ХК 2013 он мян.төг | "БиДиСек" ХК 2012 он мян.төг | "БиДиСиЭйПи" ХХК 2013 он мян.төг | "БиДиСиЭйПи" ХХК 2012 он мян.төг | Нэгтгэсэн 2013 он мян.төг | Нэгтгэсэн 2012 он мян.төг |
|---|---|---|---|---|---|---|
| Татвар төлөхийн өмнөх ашиг | 278,233 | 1,651,337 | 44,735 | 14,197 | 322,969 | 1,665,534 |
| **Татварын байнгын зөрүү** | | | | | | |
| *Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох орлого* | (11,362) | 37,266 | - | 1,662 | (11,362) | 38,928 |
| *Татвараас хасагдахгүй зардал* | (39,252) | (36,937) | - | - | (39,252) | (36,937) |
| | 27,890 | 74,203 | - | 1,662 | 27,890 | 75.865 |
| **Татварын түр зөрүү** | | | | | | |
| *Татвар ногдох түр зөрүү* | - | - | - | - | - | - |
| *Татвараас хасагдах түр зөрүү* | - | - | - | - | - | - |
| | - | - | - | - | - | - |
| Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох ашиг (алдагдал) | 266,871 | 1,688,603 | 44,735 | 15,859 | 311,606 | 1,704,462 |
| Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар | 26,687 | 168,860 | 4,474 | 1,586 | 31,161 | 170,446 |
| Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан татвар | 3,925 | 3,694 | - | - | 3,925 | 3.694 |
| Тайлант жилийн нийт татварын зардал | 30,612 | 172,554 | 4,474 | 1,586 | 35,086 | 174,140 |



СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2014 07 04

(7)

## 28. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ (төгрөг)

| | 2013 он төгрөг | 2012 он Төгрөг |
|---|---|---|
| Энгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилагдах ашиг | 287,882,792 | 1,491,394,168 |
| Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо | 11,000,000 | 11,000,000 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг) | 26 | 136 |

## 29. ХОЛБООТОЙ ТАЛ

| Холбоотой талуудын нэр | Харьяалал | Хамаарал | Ажил гүйлгээ |
|---|---|---|---|
| "БиДиСиЭйПи" ХХК | МУ-ын хуулийн этгээд | "БиДиСек" ХК-ийн охин компани | Хоорондын тооцоо |
| "[illegible]йй" ХХК | МУ-ын хуулийн этгээд | Гүйцэтгэх удирдлагын хяналтанд байдаг компани | Хоорондын тооцоо |
| Alexander Zwahr | АНУ-ын иргэн | "БиДиСек" ХК-ийн 28%-ийн хувьцаа эзэмшигч | Ногдол ашиг |
| Б.[illegible]вадорж | МУ-ын иргэн | ТУЗ-ийн дарга, Тэргүүн дэд захирал | Цалин урамшуулал, зээл |
| Д.[illegible]гүүн | МУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, 26%-ийн хувьцаа эзэмшигч | Цалин урамшуулал, зээл, ногдол ашиг |
| Н.Бат[illegible]рол | МУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн, Дэд захирал | Цалин урамшуулал, зээл |
| Д.[illegible]галанбаяр | МУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| Б.[illegible]хбаяр | МУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| Б.[illegible]рсанаа | МУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| James Passin | АНУ-ын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| Hitoshi Tani | Япон улсын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| Alexis M.[illegible]cquenem | Франц улсын иргэн | ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал, зээл |
| Firebird Master Fund | АНУ-ын хуулийн этгээд | "БиДиСек" ХК-ийн 10%-ийн хувьцаа эзэмшигч | Ногдол ашиг |
| Firebird Master Fund Holding | АНУ-ын хуулийн этгээд | "БиДиСек" ХК-ийн 5%-ийн хувьцаа эзэмшигч | Ногдол ашиг |
| С.[illegible]дэвсүрэн | МУ-ын иргэн | БиДиСиЭйПи ХХК-ийн гүйцэтгэх захирал | Цалин урамшуулал, зээл |



СЗХ 2014 он 07 сар 07 өдөр БҮРТГЭВ № 01

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 29. ХОЛБООТОЙ ТАЛ (үргэлжлэл)

*Холбоотой талуудын ажил гүйлгээ*

Дээр дурдсан холбоотой талуудтай хийсэн томоохон хэмжээний ажил гүйлгээ нь дараах байдалтай байна:

| | 2013 он мян.төг | 2012 он мян.төг |
|---|---|---|
| Шилжүүлсэн үндсэн хөрөнгө | - | (3,131) |
| Олгосон зээл | (302,025) | (139,569) |
| Зээлийн эргэн төлөлт | 325,691 | 22,897 |
| Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин, урамшуулал | (65,315) | (67,488) |

| | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2012 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| *Холбоотой талуудаас авах авлага/(өгөх өглөг)* | | |
| "Эм Ай" ХХК | 114,358 | 116,672 |
| Хувь нийлүүлэгчид | 10,560 | 31,912 |
| | 124,917 | 148,583 |

## 30. БОЛЗОШГҮЙ ҮЙЛ ЯВДАЛ БА ТОМООХОН ХЭЛЦЭЛ

Компани "Хай Би Ойл" ХК-тай 2013 оны 08-р сарын 09-ний өдөр 170,000 ам.доллар, 2013 оны 09-р сарын 12-ны өдөр 80,308 мянган төгрөгийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулсан. Уг зээлийн гэрээний дагуу зээл тус бүр 3 сарын хугацаатай (170,000 ам.долларын зээлийг 2013 оны 11-р сарын 26-ны өдрийн нэмэлт гэрээгээр хугацааг 2014 оны 01-р сарын 01-ний өдөр хүртэл сунгасан) бөгөөд жилийн 15%-ийн хүүтэй. Зээлийн хугацааны эцэст нийт зээл болон хүүгийн төлбөрийн нэг бүр нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий төлбөр нь хийгдсэн энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй. 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр хуримтлагдсан хүү 19,318 мянган төгрөг байна. Санхүүгийн Зохицуулах Хорооноос хувьцаа хөрвүүлэлтийг зөвшөөрөөгүй тохиолдолд "Хай Би Ойл" ХК-иас зээлийн үндсэн төлбөр болон хүүг 3 хоногийн дотор нэн даруй төлнө.

## 31. БОЛЗОШГҮЙ АЛДАГДАЛ

a. *Тэмдэглэл 8* Богино хугацаат хөрөнгө оруулалт -д тусгагдсан арилжаа нь зогссон хувьцаат компани дахь хөрөнгө оруулалтын дунд "Зоос банк" ХК-ийн энгийн хувьцаан дахь хөрөнгө оруулалт болох нийт 206,061 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт бүртгэлтэй байгаа бөгөөд процедурыг үнээс сэргээж хүртэнэ гэсэн бодитой нотолгоо байхгүй байна. Банкны жижиг хувьцаа эзэмшигчид (Үүнд: "БиДиСек" ХК хамаарна) Зоос банкны эрх хүлээн авагч болох одоогийн Төрийн банкинд үргэлжлүүлэн хувьцаа эзэмшиж хөрөнгө оруулагчаар үлдэх нэхэмжлэлээ шүүхэд гаргасан байгаа бөгөөд шүүхийн шийдвэр аль талд гарахаас хамааран компанийн хүртэх ашиг, алдагдлын хэмжээ тодорхойлогдоно.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 31. БОЛЗОШГҮЙ АЛДАГДАЛ (үргэлжлэл)

[illegible] Тэмдэглэл 9 Худалдааны ба бусад авлага -ын дунд багтсан "Дархан Хөвөн" ХК-иас авах авлага болох нийт 484,982 мянган төгрөг нь 2007 оны 07-р сарын 08-ны өдөр "Дархан Хөвөн" ХК-ийн 51%-ийн хувьцаа эзэмшигч болох Б.Байгальтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу "Дархан Хөвөн" ХК-д оруулсан нийт 322,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт болон зээл, зээлийн хүүний нийт төлбөрөөс бүрдэж байгаа юм. Уг төлбөрийг "Дархан Хөвөн" ХК-иас гаргуулахаар Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн 2009 оны 04-р сарын 24-ний өдрийн 555 дугаар захирамж гаргуулан авч одоо шийдвэр гүйцэтгэлийн [illegible] хийгдэж үйлдвэрийг бусдад худалдах, тоног төхөөрөмжийг зарах, [illegible] хийгдэж байгаа. Үүнтэй холбоотойгоор ирээдүйд ямар нэгэн болзошгүй [illegible] магадлалтай юм.

[illegible] Тэмдэглэл 9 Худалдааны ба бусад авлага-ын дунд багтсан "Силикат" ХК-иас авах 94,803 мянган төгрөгийн дүн нь 2011 онд "Силикат" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргалтын ажилтай холбоотойгоор үүссэн Андеррайтерын үйлчилгээний үлдэгдэл төлбөр юм. Хөрөнгийн зах зээл дээр нэмж хувьцаа гаргах ажил амжилттай явагдаж дууссан болович "Силикат" ХК-ийн зүгээс "БиДиСек" ХК-ийг "хууль зөрчсөн", "андеррайтерын үүргээ зохих ёсоор биелүүлээгүй", "компанийн удирдлагын эрхийг авахыг санаархсан" гэх мэт үндэслэлээр цаашид хамтран ажиллахаас татгалзсан бөгөөд энэхүү авлага нь эргэн төлөгдөхгүй байх магадлалтай байна.

## 32. ТАЙЛАГНАЛЫН ҮЕИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тайлагналын өдрөөс аудитын тайлан батлагдах хүртэлх хугацаанд үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, удирдлагын шийдвэр гаргалтанд нөлөөлөхүйц хэмжээний томоохон үйл явдал тохиолдоогүй болно.

## 33. ЗЭРЭГЦҮҮЛСЭН ҮЗҮҮЛЭЛТ

[illegible] санхүүгийн тайлантай нийцүүлэх үүднээс 2012 оны зэрэгцүүлэх [illegible] тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

## 34. АНГЛИ ОРЧУУЛГА

Санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэлнээ үйлдэгдсэн бөгөөд Англи хэл болон Монгол хэл дээрх хувилбаруудад орчуулгын ямар нэгэн зөрүү гарвал Монгол хэл дээрх [illegible]



2014 07 04

СЭХ
2014 оны 07 сар 07 өдөр
№ 01



**ДАЛАЙВАН АУДИТ ХХК**

*Нягтлан бодох бүртгэлийн зөвлөлгөө, аудит, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага*

# ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Захиалагчийн нэр:
**"Бидисек" ХК**

Бүртгэл, регистр:
**9010001030; 20052482;**

Компанийн хаяг, зорилго:
**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,**
**Залуучуудын өргөн чөлөө 27/1;**
**Компанийн 2013 оны 12-р сарын 31-ны байдлаарх үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ**

Үндсэн хөрөнгийн өнөөгийн үнэ цэнэ:
**10,013,147.2 мянган төгрөг**

2014 оны 02 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот



2014 07 04

176

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**ДАЛАЙВАН АУДИТ**

Аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг. Амарсанаагийн гудамж-5
Утас: 305401, 305402, 305404, 305405
Факс: +976-11305403
Э.шуудан: ceo@dalaivanaudit.mn
info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

*Огноо: 2014.02.12.*

**"Бидисек" ХК-ийн Тэргүүн дэд захирал Б.Лхагвадорж танаа**

***Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн тухай***

Таны ирүүлсэн хүсэлтээр байгуулсан Үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу Танай байгууллагын өмчлөлд байгаа үндсэн хөрөнгө (барилга байгууламж; тээврийн хэрэгсэл; тавилга эд хогшил, тоног төхөөрөмж)-ийн зах зээлийн өнөөгийн үнэ цэнийг тогтоож, тайлан бэлтгэж хүргүүлэв.

Үнэлгээнд хамрагдсан дээрх эд хөрөнгийн зах зээлийн өнөөгийн үнэ цэнэ нь 2014 оны 02 дугаар сарын 12-ний өдрийн байдлаар **10,013,147.2 мянган (арван тэрбум арван гурва сая нэг зуун дөчин долоон мянга хоёр зуун) төгрөг** байна. *Үүнээс: барилга байгууламж, газар эзэмших эрхийн үнэ цэнэ **9,501,600.0 мянган төгрөг**; тээврийн хэрэгслийн үнэ цэнэ **335,404.0 мянган төгрөг**; компьютер **35,086.4 мянган төгрөг**; тавилга эд хогшил **40,873.8 мянган төгрөг**; бусад хөрөнгө **72,036.6 мянган төгрөг**; "БиДиСиЭйПи" ХХК-ийн компьютер, таилга эд хогшил **28,146.5 мянган төгрөг** болно.*

"Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол улсын хуулийн дагуу зохих сургалтанд хамрагдан, олон удаагийн сонгон шалгаруулалтанд тэнцэж, тусгай зөвшөөрлийн ээлжит хугацаагаа Сангийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 286 тоот тушаалаар сунгуулсан үнэлгээчид Танай компанийн өмчлөлд байгаа уг эд хөрөнгийн тоо хэмжээ, ашигласан хугацаа, байршил, одоогийн төлөв байдал, цаашид ашиглах боломж зэргийг харгалзан, өртөг, орлогын хандлага болон зах зээлийн харьцуулалтын аргаар энэхүү үнэлгээг гаргав.

Бидэнтэй хамтран ажилласан Танд талархлаа илэрхийлье

**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**

**Ц.ЖИГДЭН**

an independent member of
BAKER TILLY INTERNATIONAL

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Огноо: 2014.02.12** **Улаанбаатар хот**

# "БиДиСЕК" ХК-ийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн тухай тайлан

## *нэг.*Захиалагчийн талаарх мэдээлэл

| | |
|---|---|
| Захиалагчийн нэр: | "Бидисек" ХК |
| Тэргүүн дэд захирлын нэр: | Б.Лхагвадорж |
| Улсын бүртгэл, регистрийн дугаар: | 9010001030; 20052482 |
| Захиалагчийн хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, өөрийн байранд |
| Үнэлүүлэх объектын хаяг: | 1.Дээрх хаягт байрлах үйлчилгээний 6 давхар барилга, байгууламж; 2.Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд байрлах салбарын ажлын байр; 3.үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл, компьютер, бусад үндсэн хөрөнгө; 4."БиДиСиЭйПи"ХХК-ийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер; тавилга эд хогшил |
| Үнэлгээ хийлгэх захиалга: | Ерөнхий захиралтай байгуулсан 2/02 тоот гэрээ |
| Огноо: | 2014.02.04. |

## *хоёр.*Үнэлгээний зорилго, тодорхойлолт, зориулалт, хугацаа

2.1.Үнэлгээний зорилго нь "Бидисек" ХК-ийн өмчлөлд байгаа барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө болон "БиДиСиЭйПи" ХХК-ийн үндсэн хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хороонд шинэчлэн бүртгүүлэх зорилгоор санхүүгийн тайлагналын зориулалтаар дахин үнэлэхэд оршино.

2.2.Үнэлгээний олон улсын стандартын (ҮОУС) Хэрэглээ 1."Санхүүгийн тайлангийн зориулалт бүхий үнэлгээ" бүлгийн 1.2-т "Үнэлгээчин нь хэрэглэгчид тохиромжтой хэлбэрээр зах зээлд үндэслэсэн тодорхойлолтуудыг баримтлан, бодит байдал болон бусад холбогдох асуудлуудыг бүрэн тодруулах нь санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний шаардлагын үндэслэл болно" гэжээ.





2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-аар балансад хөрөнгийг өртгийн болон бодит үнэ цэнийн гэсэн хоёр загвараар хүлээн зөвшөөрч тусгадаг. Хөрөнгийг балансад бодит үнэ цэнийн загвараар тусгах тохиолдолд дахин үнэлгээ хийх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангийн зориулалт бүхий үнэлгээний тодорхойлолтуудыг Үнэлгээний олон улсын стандарт (ОУҮС)-д дараахь байдлаар илэрхийлсэн байдаг.

- **Зах зээлийн үнэ цэнэ.**Үнэлгээний өдрөөрх аливаа арилжааны үр дүнд, бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд аль ч тал нь хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэгэн шахалтгүйгээр хандсан гэж үзсэнээр зүй зохистой маркетинг хийсний дараахь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр өмчийг солилцож болох тооцоолсон дүн байна. (ОУҮС1, 3.1-р зүйл)
- **Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг.** Хөрөнгийн бүх төрлийн биет болон эдийн засаг, үйл ажиллагааны элэгдэл, хоцрогдлыг хассан дахин үйлдвэрлэлийн эсвэл орлуулалтын өнөөгийн өртөг болно. (ОУҮС Хэрэглээ 1,Санхүүгийн тайлагналын зориулалт бүхий үнэлгээ 3.2-р зүйл)
- **Өртгийн хандлага.** Тухайн хөдлөх өмчийг худалдан авахын оронд түүнтэй адил, тэнцүү хэрэглээтэй өмчийг үйлдвэрлэн бүтээж орлуулах өртөг бөгөөд, өмчийг бэлтгэх ажиллагаа хойшилсноос ямар нэг нэмэлт зардал гарахгүй гэж үздэг. (ОУҮС Хэрэглэх заавар 5. Хөдлөх хөрөнгийн үнэлгээ.5.10.1-р зүйл)
- **Орлуулалтын өртөг.** Тухайн өмчтэй адил хугацаа, хэмжээ, чанар, өнгө, нөхцөл бүхий өмчид төлж болох дүнгийн тооцоолсон төсөөлөл байна. Ихэвчлэн энэ нь жинхэнэ эхийн хуулбарын өртөг болох бөгөөд хуулбар гэдэг нь орчин үеийн зохион бүтээх аргаар жинхэнэ зүйлийг түүнтэй аль болох ойролцоо шинж чанар, чанартай болон ойролцоо хуучралтай материалаар хуулбарлахыг хэлнэ. (ОУҮС Хэрэглэх заавар 5. Хөдлөх хөрөнгийн үнэлгээ.5.10.2.1-р зүйл)
- **Дахин үйлдвэрлэлийн өртөг.** Жинхэнэ эхийн нарийн хуулбар, эсвэл яг адил хуулбарт төлөхөд бэлэн байгаа дүн бөгөөд нарийн хуулбар гэдэг нь жинхэнэ эхийг анх зохион бүтээсэн аргаар нь жинхэнийхтэй бараг адилхан шинж чанар, чанар, хуучралтай материалаар яг адилханаар хуулбарлахыг хэлнэ. (ОУҮС Хэрэглэх заавар 5. Хөдлөх хөрөнгийн үнэлгээ.5.10.2.1.2-р зүйл)
- **Тусгай (төрөлжсөн) өмч.** Өмчийн мөн чанар, загвар, зохион бүтээлт, хэмжээ, байрлал болон бусад шинжээс нь болоод давтагдашгүй байдаг учир харьяалагдаж байгаа бизнес эсвэл аж ахуйн нэгжийг худалдахаас бусад тохиолдолд зах зээлд бараг арилжаалагддаггүй ховор өмч юм. (ОУҮС Хэрэглээ 1,Санхүүгийн тайлагналын зориулалт бүхий үнэлгээ 3.4-р зүйл)
- **Эдийн засгийн үр ашигтай хугацаа.** Хөрөнгийг нэг болон хэд хэдэн хэрэглэгч эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэглэж болох хугацаа. (ОУҮС Хэрэглээ 1,Санхүүгийн тайлагналын зориулалт бүхий үнэлгээ 3.19-р зүйл)

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын тодорхойлолтууд:

- **Бодит үнэ цэнэ.** Холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүнг хэлнэ. (НББОУС 16, 6-р зүйл) Бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнэтэй заавал ижил байх албагүй бөгөөд энэ нь СТОУС-уудад өөр өөр утгаар хэрэглэгддэг. (НББОУС 16, 31-р зүйл)
- **Дансны үнэ** гэдэг нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараа хөрөнгийг балансад хүлээн зөвшөөрдөг дүн юм.(НББОУС 36.6-р зүйл)
- **Элэгдэл.** Хөрөнгийн элэгдэх хэмжээг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэй хуваарилсан хуваарилалт. (НББОУС 16, 6-р зүйл; НББОУС 36, 6-р зүйл)
- **Дахин үнэлэгдсэн дүн.** Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс дараа үеийн хуримтлагдсан элэгдэл болон дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн. (НББОУС 16, 31-р зүйл)
- **Ашигтай хугацаа.** Аж ахуйн нэгж хөрөнгийг ашиглахаар тооцож буй хугацаа. (НББОУС 16, 6-р зүйл; НББОУС 36, 6-р зүйл)
- **НББОУС 16-ын дагуу үнэлгээ хийх.** а). "Газар болон барилгын үнэ цэнийг ихэвчлэн мэргэшсэн үнэлгээчин зах зээлийн нотолгоонд үндэслэн тогтооно. Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ихэвчлэн үнэлгээгээр тодорхойлогдсон зах зээлийн үнэ цэнэ байна." (НББОУС 16, 32-р зүйл) б)."Тасралтгүй бизнесийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болохоос бусад тохиолдолд үндсэн хөрөнгийн өвөрмөц шинж чанар болон ховор арилжаалагддаг байдал зэргээс шалтгаалан бодит үнэ цэнийг тогтоох зах зээлийн нотолгоо байхгүй үед тэдгээр хөрөнгийг орлогын болон элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлагаар үнэлнэ." (НББОУС 16, 33-р зүйл) Зах зээлийн шууд нотолгоо байхгүй үед элэгдэл тооцсон орлуулалтын өртгийг тусгай хөрөнгийн үнэ цэнийг тогтоох арга гэж хүлээн зөвшөөрдөг боловч энэ арга зүйг өнөөгийн өртөг болон элэгдүүлэлтийн хувийг үнэлэхэд үнэлгээчдийн зах зээлийн ажиглалттай хослуулж хэрэглэх ёстой. Энэ арга зүй нь зах зээлийн үнэ цэнийн зарчмын талаар зөв ойлголттой талуудын ижил төстэй онолын ажил гүйлгээнд тулгуурлана. (ОУҮС Хэрэглэх заавар 8.Санхүүгийн зориулалт бүхий өртгийн хандлага. 5.3-р зүйл)

2.3.Дахин үнэлгээний тайлан тооцоо, дахин үнэлэгдсэн дээрх үндсэн хөрөнгийн үнэ цэнийн үр дүнг санхүүгийн тайлагналдаа тусгаж, Санхүүгийн зохицуулах хороонд шинэчлэн бүртгүүлэхдээ өөрийн үндсэн хөрөнгийн боломжит чадавхиа үндэслэлтэй илэрхийлэх зэрэгт хэрэглэх зориулалттай болно. Иймд хөрөнгийн үнэлгээний энэ тайлангийн үр дүнг аливаа өөр зориулалтаар ашиглахгүй гэдэгт бид итгэж байна.

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2.4.Үнэлгээний тайланг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үндэслэж бичив.

### *гурав.* "Бидисек" ХК-ийн үйл ажиллагааны товч танилцуулга

"Бидисек" ХК нь 2005 онд үнэт цаасны зах зээл дээр Андеррайтерын үйл ажиллагаа явуулах эрх авч, Брокер, Дилер, Андеррайтерын үйл ажиллагааг иж бүрнээр явуулах эрх бүхий анхны компани болсон.

Монголын хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, шилдэг үйлчилгээг бий болгох зорилгоор зах зээлд гарсан гол гол бүтээгдэхүүнүүдэд ерөнхий болон туслах зуучлагчаар идэвхитэй оролцож байна. Үүнд: "Бидисек" ХК нь Пума группээс гаргасан "Пума Бонд"-ийн ерөнхий зуучлан борлуулагч, "МонИнжБар" ХК-ийн "Бүтээн байгуулалт" бондын ерөнхий зуучлан борлуулагч, "МСиЭс Электроникс" ХХК гаргасан "МСиЭс Элетроникс Бонд"-ийн туслан гүйцэтгэгч, Анод банкнаас гаргасан "Анод Бонд"–ын туслан гүйцэтгэгчээр ажилласан. Мөн тус компани нь хөрөнгийн зах зээл дээр "Женко тур бюро" ХК-ийн гаргаж буй 10 тэрбум төгрөгийн хувьцааны ерөнхий зуучлан борлуулагчаар ажиллаж байна.

"Бидисек"ХК нь Монгол улсын томоохон банк, компаниуд, гадаадын харилцагч, иргэд нийлээд 50`000 гаруй харилцагчдын эрх ашгийг ямагт дээгүүр тавьж, тэдний итгэлийг хүлээн ажиллаж байна.

Монголын хөрөнгийн зах зээлд оролцдог гадаадын харилцагчдын 95%, томоохон байгууллагуудын 30% нь "БиДиСек" ХК-аар үйлчлүүлж байна.

Хөрөнгийн зах зээлд оролцож буй шилдэг компани "БиДиСек" ХК 2006 онд өөрийн компаний үйл ажиллагааны хэлбэрээ өөрчлөн Хувьцаат Компани болон өөрчлөгдсөн.

Компанийн мэргэжлийн боловсон хүчний хувьд бүрэн хангагдсан бөгөөд шинэ зах зээлд ажиллах чадвар бүхий мэргэжлийн 11 хүн байнга ажиллаж байна. Техник, Технологийн хувьд үйл ажиллагааг орчин үеийн түвшинд бүрэн хантан явуулахуйц түвшинд хүрч хамгийн сүүлийн үеийн компьютер техникууд ашиглаж байна. Дархан, Орхон, Төв, Архангай, Дорноговь аймгуудад салбартай.

Үйл ажиллагаа явуулах эрхээ цуцлуулсан "Түмэн Булл" Брокер дилерийн компанийн харилцагчдийг шилжүүлэн авсанаар хамгийн олон харилцагчтай компани болсон.

"Бидисек" ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн бөгөөд үнэт цаасны зах зээлд тасралтгүй 15 жил дагнан ажиллаж буй зах зээлийн тэргүүлэгч компаниудын нэг юм.

Үнэт цаасны зах зээл дээр брокер диллерийн үйл ажиллагаа эрхлэхээр Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 113 дугаар тогтоолоор 3/15 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон.

Тус компани 40 гаруй ажиллагсадтай.



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлага**

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын талаар эдийн засагчид их ярих болсон. Учир нь санхүүгийн зах зээлийн үндсэн 2 тулгуур болох хөрөнгийн зах зээл өнгөрсөн 10 жилийн хугацаанд мөнгөний зах зээлээс хөгжлөөр хоцорсон гэж хэлж болно.

Ийм учраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт хүргэх арга замуудыг сүвэгчлэх болж Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэлхийн жишигт хүргэхийн тулд Лондонгийн хөрөнгийн биржтэй менежментийн гэрээ байгуулан ажиллаж байна. Хөрөнгийн зах зээл хөгжих үндэс суурь болсон хууль эрх зүйн орчныг өнгөрсөн 3 жилийн хугацаанд эрчимтэй сайжруулж байна.

Өнөөдөр Монголын хөрөнгийн зах зээлтэй холбоотой Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль мөн Хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг нь шинэчлэгдэн гарснаар олон улсын практикт байдаг санхүүгийн бүтээгдэхүүн жинхэнэ утгаар хөгжих боломжтой болсон. Мөн үндэсний хэмжээний компаниудын үйл ажиллагаа улам өргөжин тэлж хөрөнгийн зах зээл дээр гарч нээлттэй компани болж, олон нийтийн хэлбэрт шилжих сонирхол нь өндөр болж байна.

Монгол улсад орж буй хөрөнгө оруулалтууд цаашид зөвхөн нээлттэй компаниудаар дамжин орж ирэх хандлага ажиглагдаж байгаа нь цаашид хөрөнгийн зах зээл үсрэнгүй хөгжих үндэс нь болно.

***дөрөв.* Үнэлэгдсэн эд хөрөнгийн одоогийн байдал**

4.1. "Бидисек" ХК-ийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлт, эд хөрөнгийн тооллогын бүртгэлд тулгуурлан хийсэн болно. Үндсэн хөрөнгийг 6 хэсэгт хувааж ангилсан: барилга байгууламж; тээврийн хэрэгсэл; компьютер; тавилга эд хогшил; тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө, бусад үндсэн хөрөнгө; "БиДиСиЭйПи" ХХК-ийн компьютер, тавилга эд хогшил.

4.2. Барилга байгууламжид: Сүхбаатар дүүргийн 8-р хороонд байрлалтай "Бидисек" ХКомпанийн төв байр, 6 давхар барилга, байгууламж; Чингэлтэй дүүрэг 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай "Express Tower" үйлчилгээний барилгын 3 давхарын 153,6$м^2$ талбайтай Экспресс салбарын ажлын байр.

4.2.1 Үйлчилгээний барилга анх 2006 онд зочид буудлын зориулалтаар баригдсан бөгөөд тус компани 2007 худалдан авч зориулалтыг нь өөрчилсөн, 14x18м хэмжээтэй, нийт 1908$м^2$ талбайтай, төмөр бетон карказан хийцийн тоосгон ханатай, давхар дундын цутгамал бетон хучилттай, вакууман цонхтой, хиймэл паркетан шалтай, дотор шахмал модон хаалгатай, 1-р давхраас дээш хойд хэсэг бүх давхар консоль хийцтэй, хяналтын камертай, төвийн инженерийн шугамд бүрэн холбогдсон, зоорийн давхартай 6 давхар барилга. Уг барилгын хуучин өрөөнүүдийн доторхи "00" өрөөнүүдийг буулган өөрчилж, ажлын өрөөний талбайг нэмэгдүүлсэн, халаалтын систем сольсон, давхар бүрийн коридорт нийтийн ариун цэврийн өрөөг шинээр тохижуулан





2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

засварлан хийсэн, өөрсдийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа өрөө тасалгааг сүүлийн үеийн материал, хийц ашиглан зохих зураг төсвийн дагуу шинэчлэн нэлээд засвар тохижилт хийсэн юм байна. 2010 -2013 оны хооронд нийт 46,0 сая төгрөгийн засварын хөрөнгө оруулалт хийгдсэн.

Тус компани барилгын 1; 2; 6-р давхарыг өөрсдийн үндсэн үйл ажиллагааны хэрэгцээнд, 3; 4; 5-р давхарыг гадны байгууллагуудад түрээслүүлэн ашиглаж байгаа.

Давхар бүрийн өрөөний зохион байгуулалтыг дурдвал:

-Зоорийн давхартаа 6 машины гаражтай; фитнесийн өрөө; халаалтын бойлерийн өрөөтэй.

-1-р давхар үүдний орох хэсэг хөлийн өрөө, арилжааны танхим, номын сан, архивын байр, харуулын өрөө (хяналтын камертай)-тэй. Давхар тус бүрт хяналтын камер, ариун цэврийн тусдаа өрөөтэй. Хүн тээврийн лифт, шаттай.

-2-р давхарт уулзалтын өрөөг шинээр тохижуулж засварласан; оффисын 2 өрөө тасалгаанд компанийн ажилтнуудын ажлын байр болгон тохижуулсан, гадна кодтой хаалга хийсэн.

-3-р давхар 6 өрөө тасалгаатай.

-4-р давхар 7 өрөө тасалгаатай.

-5-р давхар 8 өрөө тасалгаатай.

-6-р давхарт хурлын өрөөг томсгосон; ажилчдын цайны өрөөг шинээр хийсэн; уулзалтын 2 өрөө; захирлын өрөө; амралтын өрөө нийт 6 өрөө тасалгаатай, гадна кодтой хаалга хийсэн.

Уг барилга хотын төвд төв зам дагуу үйлчилгээ эрхлэхэд байршил сайтай, цаашид зориулалтаар нь ашиглаж, бизнесийн болон эдийн засгийн үр ашиг олох боломжтой.

1908м$^2$ талбайтай уг барилгыг өмчлөх эрхээ баталгаажуулж, 2009 оны 07 дугаар сарын 08-ны өдөр улсын бүртгэлийн газрын Ү-2203013940 дугаарт бүртгүүлж 000077671 тоот гэрчилгээ авсан байна.

4.2.2 Дээрх барилгын доорхи болон эргэн тойрны 3007/0086 нэгж талбарын дугаартай 900м$^2$ талбайтай газрыг Нийслэлийн газрын албанаас 2010 оны 02-р сарын 08-ний өдөр 5 жилийн хугацаатай үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэхээр 0229136 тоот гэрчилгээ олгожээ.

Уг эзэмшил газрын урд хэсэгт дээрх 6 давхар барилга баригдсан байгаа бөгөөд хойд хэсэгт автомашины зогсоол бетон хийцийн 640м$^2$ орчим талбайтай, 2 талд 60 у/м хэмжээтэй төмөр хайсан хашаатай, тов шугамаас 200у/м орчим дулааны шугамыг өөрсдийн зардлаар татсан болно.

4.2.3 Express салбар Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, "Express tower"-ийн 3 давхарт, 153,6м$^2$ талбайтай хэсгийг эзэмшдэг. Энэ хэсэг оршиж буй ажлын байр нь 16 давхар, цутгамал бетон каркастай, блок тоосгон ханатай, давхар бүртээ 3-4 ажлын өрөө гаргасан, цахилгаан болон аваарын шаттай, сүүлийн үеийн загвар хийцтэй. Express салбар уг барилгын 3-р давхарын урд талын хэсгийг эзэмшдэг бөгөөд урагш харсан 2, баруун тийш харсан 2 вакууман цонхтой, паркетан шалтай, шилэн хаалт хийж хурлын өрөө гаргасан, арилжааны мэдээлэл харах зурагт, ширээ, сандал, үзүүлэн самбар байрлуулсан.

Конторын зориулалттай 153,6 м$^2$ талбайтай энэ хэсгийг өмчлөх эрхээ баталгаажуулж, 2013 оны 11 дугаар сарын 19-ний өдөр улсын бүртгэлийн Ү-2202018212 дугаарт бүртгүүлж 000291563 тоот гэрчилгээ авсан байна.



2014 07 04

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Уг салбарын байр хотын төвд төв зам дагуу үйлчилгээ эрхлэхэд байршил сайтай газар байрладаг, цаашид зориулалтаар нь ашиглаж, бизнесийн болон эдийн засгийн үр ашиг олох боломжтой.

4.3.Албаны хэрэгцээнд ашиглагдаж байгаа Тээврийн хэрэгсэл 7 ширхэг, бүгд суудлын зориулалттай, чанар байдал өнгө үзэмж сайн, цаашид зориулалтын дагуу ашиглах бүрэн боломжтой. Эдгээр тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтыг дараахь хүснэгтэд харуулав:

| дд | Улсын дугаар | марк | Тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар | Үйлдвэрлэсэн он | МУ-д орж ирсэн огноо | Хөдөлгүүр, арал, бүхээгний дугаар | өнгө |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 7813 УНП | Тоёото Марк II GX100 | АЯ№0229681 | 1998 | 2007.07.31 | хөдөлгүүр: 6547385 Бүхээг:GX100-0071149 | Сувдан цагаан |
| 2 | 8234 УНӨ | Toyoto Lexus LX570 | АЯ№0316028 | 2012 | 2012.05.28 | Арал: JTJH7AX9D4083830 | Хар |
| 3 | 1551 УНХ | Toyota Camery | АЯ№0057409 | 2009 | 2010.08.03 | Арал: GTLB42K3AX624268 | Хар |
| 4 | 5597 УНН | Lexus LX570 | АЯ№0401397 | 2008 | 2008.10.15 | Арал:JTJHY00W4007688 | Хар |
| 5 | 8032 УНП | Toyota Hilux | АЯ№0020927 | 2001 | 2010.02.22 | Арал: RZN185-0043650 | Хар |
| 6 | 5444 УБМ | Тоёото Lexus LX470 | АЯ№0223849 | 2000 | 2006.06.06 | Арал:JT64TOOW2Y0089670 | Ногоон |
| 7 | 4000 УНД | Toyota Hilux | АЯ№0022984 | 1999 | 2010 | Арал:PZNJ85-9027067 | Мөнгөлөг |

4.4."Бидисек" ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж бусад үндсэн хөрөнгө: компьютер, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бусад хөрөнгө, биет бус хөрөнгө нь (Хавсралт-5; 6; 7;) зориулалтын дагуу ашиглагдаж байгаа, чанар байдал өнгө үзэмж сайн, цаашид зориулалтын дагуу ашиглах бүрэн боломжтой.

4.5."Бидисек" ХК-ны 2007 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар "Би Ди Пи И Эф" ХХК-ийг Хөрөнгө оруулалтын чиглэлээр "Би Ди Сек" ХК–н 100%-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2007 оны 8 сарын 15 нд 5157781 регистер бүхий 9011117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан охин компани "БиДиСиЭйПи" ХХК-ийг үүсгэн байгуулсан. 2007 оны 9-р сарын 14-нд "Би Ди Пи И Эф" ХХК ний нэрийг өөрчилж "Би Ди Си Эй Пи" ХХК болгосон.

"Би Ди Си Эй Пи" ХХК нь "Би Ди Сек" ХК-ын байрны 3-5-р давхарын 21-н өрөө буюу 578.8 м2 талбайг түрээслүүлж, "Би Ди Сек" ХК-ийн үйл ажиллагааг найдвартай, шуурхай явуулж харилцагчидад үйлчлэхэд шаардлагатай бүхий л эд зүйлсээр хангах, компьютер, барилга,

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



объектын бүрэн бүтэн байдал, түүний ашиглалтыг хэвийн ажиллагаагаар хангах зорилготой ажиллаж байна.

Тус компанийн үндсэн үйл ажиллагаанд 22 нэрийн компьютер, дагалдах хэрэгсэл; 24 нэрийн тавилга эд хогшил (Хавсралт-8) дахин үнэлгээнд хамрагдсан бөгөөд эдгээр хөрөнгө зориулалтын дагуу ашиглагдаж байгаа, чанар байдал өнгө үзэмж сайн, цаашид зориулалтын дагуу ашиглах бүрэн боломжтой

.

## *тав.* Үнэлгээний талаархи мэдээлэл

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үнэлгээчдийн баг "Бидисек" ХК-ийн дахин үнэлгээнд хамрагдах барилга байгууламж, автомашин, тоног төхөөрөмжүүдийг газар дээр нь очиж үзэж танилцав.

Үзэж танилцах явцдаа уг эд хөрөнгийн эзэмшигчидтэй уулзаж, барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн хийц бүтэц, ашигласан хугацаа, иж бүрдэл, ашиглалт, чанар байдал, одоо ба ирээдүйн байдлыг сонирхож, үнэлгээ хийх бусад мэдээлэл цуглуулав. Мөн шаардлагатай зарим хэмжилт, үзлэгийг газар дээр нь хийсэн болно. Зохих шаардлагатай баримт бичгүүдтэй танилцаж, биечлэн танилцсан үндсэн барилга байгууламжийн гэрэл зураг татаж хавсаргав (Хавсралт 9).

## *зургаа.* Үнэлгээний ажлын хууль зүйн үндэслэл, хэрэглэсэн аргачлал, гарсан үр дүн

***<u>Хууль зүйн үндэслэл:</u>***

-Монгол улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль (2010.01.21)

-Сангийн сайдын 2013 оны 286-р тушаалаар хөрөнгийн үнэлгээчдэд олгосон хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн №071200024 тоот гэрчилгээ (үнэлгээчин Р.Бүүвэйбаатар); №071200025 тоот гэрчилгээ (үнэлгээчин Ц.Жигдэн); №071200026 тоот гэрчилгээ (үнэлгээчин З.Сарантуяа);

***<u>Арга зүйн үндэс:</u>***

- Олон улсын үнэлгээний стандарт (ҮОУС, 2011 оны ес дэх хэвлэл)
- Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой Монгол улсын эрх зүйн актууд

. ***<u>Хэрэглэсэн арга:</u>***

Дахин үнэлэгдсэн **барилга байгууламжийн** өнөөгийн үнэ цэнийг Олон улсын үнэлгээний стандартын (ОУУС) урд дурдсан заалтуудын үзэл санаанд үндэслэж, дараах байдлаар тооцсон:



2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

*А.Өртөгийн хандлагын арга:*

***Өртгийн хандлагын арга*** нь тухайн хөрөнгийг дахин шинээр бий болгоход шаардагдах зардлын үнэлгээнд (өнөөгийн өртөг буюу өнгөрсөн зардалд) тулгуурлан хөрөнгийн ашиглалтын хугацаа, эдэлгээг харгалзан үнэлгээг гаргана.

1. "Бидисек" ХК-ийн барилга байгууламжийг үнэлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 336 дугаар тогтоолоор баталсан "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, тосвийн жишиг үнэлгээ"; Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 29 дугаар тушаалаар баталсан "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг баримтлан нэгж талбайн үнийг авч, нийт талбайгаар үржүүлэн бүрэн орлуулалтын өртгийг тогтоож, хананы хийц, инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэхийн засвар хийж, түүнээс ашигласан хугацааны элэгдлийг (Монгол улсын Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолыг үндэслэн үнэлгээнд хамрагдсан барилгуудыг хийцээс нь хамааруулан 36-60 жил ашиглана гэж тооцсон) хасч, дээрх баримт бичгүүд батлагдснаас хойш барилгын салбарт гарсан үнийн өсөлтийн илтгэлцүүрээр засвар хийж, байршил чанар байдлын илтгэлцүүрээр тохируулга хийж, элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлсон болно.

2.Барилга байгууламжид сүүлийн 3 жилд засвар тохижилтын хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмж зах зээлийн бодит үнэ цэнийг гаргасан.

Аж ахуйн зориулалттай газрыг эзэмших эрхийн үнэ цэнийг дараахь байдлаар тооцов. Уг газрыг эзэмших эрхийн үнэлгээг Сүхбаатар дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт газар эзэмших эрхээ шилжүүлсэн (арилжсан) мэдээллүүдийг харьцуулж гаргалаа. Захиалагчийн барилгын хойд талд байрладаг бар, караоке ажиллуулдаг 2 давхар 100 $м^2$ талбайтай объектыг, эзэмшдэг 100 $м^2$ газартай нь 140 сая төгрөгөөр зарахаар зарласан. Барилгын өртгийг хасч тохируулга хийвэл 1$м^2$ газрын үнэ 650.0-850.0 мянган.төгрөг байхаар байна.

"Бидисек" ХК-ийн эзэмшилд байгаа барилга байгууламж, эзэмшил газрын эзэмших эрхийн (гэрчилгээний) өнөөгийн үнэ цэнийг өртгийн хандлагаар тооцоход **5,007,111.0 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 1-р хавсралтанд харуулав.)

*Б.Орлогын хандлагын арга:*

Үнэлгээний орлогын хандлагын арга нь хүлээлтийн зарчимд тулгуурлана. Ердийн хөрөнгө оруулагч буюу хөрөнгө худалдан авагч нь ирээдүйд ашиг орлого олно гэсэн хүлээлт, горьдлогоор үл хөдлөх эд хөрөнгө зах зээлээс худалдан авдгийг энэ зарчим илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл ирээдүйн ашиг олох эрхийн өнөөгийн үнэ цэнийн өртөг гэж тодорхойлж болно.





2014 07 04

186

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Орлогын хандлагын аргаар хийх үнэлгээ дараах 4 үе шаттай. Үүнд:

1. Үнэлж байгаа хөрөнгийн буюу эсвэл ижил төстэй хөрөнгийн зах зээлийн өнөөгийн орлогыг шинжлэн ирээдүйн боломжит нийт орлогыг гарган авах.

2. Зах зээлийн урдын хандлага, тухайн өмчийн байдлыг харгалзан дутуу ашиглалтын болон орлого олж чадахгүй алдагдлын хэмжээг тогтоож, тэр хэмжээгээр боломжит нийт орлогыг хорогдуулж, бодитой нийт орлогыг тодорхойлно.

3.Тухайн өмчийн жинхэнэ зардал болон зах зээл дэх хэвийн төвшний хэмжээ (хувь)-гээр баримтлан зардлыг тооцно. Түүнийг бодитой орлогоос хасна. Зардалд зөвхөн тухайн өмчтэй холбогдсон зардлын зүйл ангийг оруулна. Ингэхэд татварын өмнөх орлого гарах бөгөөд татварын дундаж утгыг хасаад цэвэр орлого гарна.

4.Дараа нь ирээдүйн цэвэр орлогыг янз бүрийн аргаар өнөөгийн өртөгт шилжүүлж болно. Ямар арга хэрэглэх нь зах зээлийн мэдээллийн хүрээ, чанараас хамаарна.

Үнэлэгдэж буй эд хөрөнгийг хамгийн үр ашигтай хэрэглээний зарчмаар өөрөөр хэлбэл одоогийнх нь зориулалтаар түрээслэж ашиг олох хувилбарыг сонгов. Орлогын хандлагын аргаар өнөөгийн үнэ цэнийг олохдоо дараахь нөхцөл байдлуудыг харгалзаж үзсэн болно.

Үүнд:

- Эдгээр объектыг хамгийн үр ашигтай хэрэглээний зарчмаар 5 жил түрээслэж ашиглана, 6 дахь жилд нь үлдэх өртгөөр нь зарна, энэ хугацаанд хөрөнгө оруулалт хийхгүй, зээл авахгүй гэсэн урьдач нөхцлөөр таамаглав;
- Түрээслэх нэгжийг талбайгаар авав. Нийт талбайн 80%-ийг түрээслэнэ гэж төсөөлөв. Нэгж талбайн түрээсийг барилгын байршил, зориулалт, хэрэглээний нөхцөл, чанар байдал зэргээс нь хамааруулж 50.0-60.0 мянган төгрөгөөр тогтоолоо. Тэгэхдээ тухайн дүүргүүдэд түрээслэж байгаа түрээсийн үнийг харгалзсан болно.
- барилга байгууламжийг жилийн турш түрээслэнэ гэж үзэв.
- түрээсийн болзошгүй алдагдлыг 5% байхаар тооцов;
- түрээсийн үйл ажиллагааны зардлыг 20% байхаар тооцов;
- татварын хувийг 10% байхаар тооцов;
- татварын дараахь цэвэр орлого дээр элэгдлийн шимтгэлийг нэмж цэвэр мөнгөн гүйлгээг гаргав
- цэвэр мөнгөн гүйлгээ жил бүр 3% -иар өсне, прогнозын дараахь жилүүдэд энэ өсөлт хэвээр хадгалагдана гэж төсөөлөв;

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



- дискуантын хувийг нийлбэрийн аргаар 2015 онд 13% байхаар тооцож, дараачийн жилүүдэд зах зээл тогтворжих хэрээр буурч прогнозын 5 жилийн төгсгөлд 10% болохоор тооцов;
- прогнозын төгсгөлд үлдэх үнэ цэнийг Гордоны загвараар тооцов;
- прогнозын 5 жилийн цэвэр мөнгөн гүйлгээ, үлдэх үнэ цэнийн нийлбэрээр барилгын өнөөгийн үнэ цэнийг гаргав.
- Дараа нь шууд түрээслэх боломжгүй боловч өнөөгийн бодит үнэ цэнэтэй байгаа бусад эд хөрөнгийн өртгийг нэмж нийт эд хөрөнгийн үнэ цэнийг гаргав.

"Бидисек" ХК-ийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн өнөөгийн үнэ цэнийг орлогын хандлагаар тооцоход **7,267,088.9 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 2-р хавсралтанд харуулав.)

***B. Зах зээлийн харьцуулалтын арга:***

Зах зээлийн харьцуулалтын арга нь үнэлгээ хийгдэж буй үл хөдлөх хөрөнгөтэй адил төрлийн хөрөнгөд худалдан авагчдаас төлж буй жишиг үнүүдийг шинжлэн үзсэний үндсэн дээр уг үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтоодог.

Бид дээрх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн харьцуулалтын арга хэрэглэн дараахь байдлаар тооцов. 2013 оны 12 дугаар сарын байдлаар үл хөдлөх хөрөнгийн худалдаа зуучлалын томоохон байгууллагуудаар (Актив зууч ХХК; Осмо ХХК; Тэнхлэг зууч ХХК; Тунамал зоос ХХК г.м) интернетэд (www.zuuch.mn; www.zarmedee.mn; www.barilga.mn) болон сонин хэвлэлээр үйлдвэр, үйлчилгээний болон ажлын байр худалдана гэж зарлан, зах зээлд санал болгосон борлосон үнийг Улаанбаатар хотын хэмжээнд, түүний дотор хотын төвийн 1-р бүсийн хүрээнд судалж үзлээ. Үнэлгээний ажил гүйцэтгэсэн огноо буюу 2013 оны 12-р сарын 31-ны байдлаар үнэлж байгаа 2 объекттой ижил төстэй, адил хийцтэй шинэ объектуудыг хийц, байршил, хийсэн засал тохижилт интерьер, экстерьер, хэрэглэсэн материал, дулааны хангамж зэргээс нь хамааруулж нэгж талбайн үнийг Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт үйлчилгээний зориулалттай барилгад 4500,0-5500,0 мянган төгрөгөөр тус тус худалдахаар санал болгожээ. Худалдахаар зарласан эдгээр үнэ нь зах зээлд энэ үнээр шууд борлогдоно гэсэн үг хараахан биш юм. Зарлагдсан үнэ гэдэг бол хөрөнгөө чөлөөтэй зах зээлд хүрэлцээтэй хугацаанд зарлан байлгаж байж олох гэж хүсэж байгаа худалдагч эзний орлогын хамгийн их боломжит хэмжээ юм. Зарлагдсан үнэ, борлогдсон үнэ хоёрын хооронд ямар зөрөө гардгийг тогтоосон судалгаа Монголд одоохондоо алга байна. Энэ нь Монголд үл хөдлөх хөрөнгийн зах зээл төлөвшөөгүй байгаа, мөн зах зээлийн багтаамж бага байгаатай холбоотой. Зах зээлийн србдийн нөхцөлд энэ зөрөө 5-10% байдаг байна. Худалдан авагчтай тохиролцож, яг арилжаа хийж өгөлцөж, авалцах үнийг дээрх нэгж талбайн





2014 07 04

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



санал болгосон үнэд 5%-иар тохируулга хийвэл 2 нэрийн үйлчилгээний барилга 4200,0-5000,0 мянган төгрөг болж байна.

"Бидисек" ХК-ийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн өнөөгийн үнэ цэнийг зах зээлийн харьцуулалтын аргаар тооцоход **9,501,600.0 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 3-аас үзнэ үү) байна.

Дахин үнэлэгдсэн **машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн** өнөөгийн үнэ цэнийг Үнэлгээний олон улсын стандартын (ҮОУС) урд дурдсан заалтуудын үзэл санаанд үндэслэж, дараах байдлаар тооцсон:

Машин тоног төхөөрөмжийн үнэлгээнд өртгийн, зах зээлийн болон орлогын хандлагыг үндсэндээ хэрэглэдэг, гэхдээ машин тоног төхөөрөмж нь хам байдлаар үйлдвэрлэлд оролцож эцсийн үр дүн нь дундын шинжтэй байдгаас шалтгаалаад салангид тоног төхөөрөмжийн үнэлгээнд орлогын хандлагыг хэрэглэх нь хязгаартай байдгийг үнэлгээнд харгалзан үзэв. Бидний үнэлэх тоног төхөөрөмжүүд нь салангид байдлаар үнэлэгдэх тул орлогын хандлагаар үнэ цэнийг тооцоолох нь ач холбогдол багатай гэж үзэж орлогын хандлагын аргуудыг тооцоонд хэрэглээгүй болно.

Машин тоног төхөөрөмж нь суурилагдсан байрандаа зориулалтын дагуу ашиглагдана, ашиглалтын эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна, машин тоног төхөөрөмжийн эдийн засгийн нас нь дуусаагүй, зориулалтын дагуу ашиглах үндэслэлтэй гэсэн нөхцөлөөр машин, тоног төхөөрөмжийг үйлдвэрийн бусад тоног төхөөрөмжөөс салангид байдлаар авч үзэх арга зүйд тулгуурладаг. Иймээс тайланд өртгийн эцсийн дүгнэлт гаргахдаа өнөөгийн үлдэгдэл өртөг буюу өнөөгийн зах зээлийн үндэслэлтэй өртөг нь дээрхи нөхцөлийг тусгасан болно.

**Өртгийн хандлага.** Энэ хандлага нь мэдээлэл сайтай хөрөнгө оруулагч үнэлж байгаа тоног төхөөрөмжид адил ашигт байдал бүхий хөрөнгийг сэргээн босгоход гарах зардлаас илүү үнэ төлөхгүй гэсэн үндэслэлд тулгуурладаг. Энэ нь хэрэв Тоног төхөөрөмж шинэ байгаа бол түүний ижил, орлуулах тоног төхөөрөмжийн өртөг нь үнийн дээд хязгаар нь болдог. Хэрэв тоног төхөөрөмж нь хуучин бол элэгдлийн хэмжээгээрээ, тухайлбал биет, үйл ажиллагааны болон эдийн засгийн хуучралын өртгөөрөө ялгаатай байна.

Өртгийн хандлагаар тоног төхөөрөмжийг үнэлэхдээ үнэлэх хөрөнгийн орлуулах юм уу, бүрэн сэргээх өртгийг тодорхойлоод түүнээс биет, үйл ажиллагааны болоод эдийн засгийн хуучралын элэгдлийн өртгийг хасаж хөрөнгийн өнөөгийн өртгийг тооцоолдог.

Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн (цаашид товчлохын үүднээс үндсэн хөрөнгө гэх) өнөөгийн өртгийг дээр дурдсан аргачлалд үндэслэж, дараах байдлаар тооцсон:

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01



1. Үндсэн хөрөнгийн анхны өртгийг худалдаж авсан буюу ашиглалтанд орсон өртгөөр нь тайлан тэнцлийн бүртгэлийн үнийг баримтлан тогтоосон. Анхны өртгийн үнэн зөв эсэхийг анхдагч баримт бичгийн материалаар түүвэрчлэн шалгасан.

2.Үндсэн хөрөнгийн бүрэн орлуулалтын өртгийг бүх тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжид нэг бүрчлэн тооцоолж, тээврийн хэрэгслийн хувьд үйлдвэрлэгч фирм болон дилерүүдийн үнийн мэдээллийг интернетээс хайх, каталог ашиглах замаар тогтоож, тоног төхөөрөмжид анхны өртөгт тулгуурлан үнийн өсөлтөөр индексжүүлэх, зах зээлийн аргаар шууд ба шууд бус аргаар зэрэгцүүлэх, ойролцоо жишгээр харьцуулах зэрэг аргуудаар тодорхойлж, түүнээс ашигласан болон цаашид ашиглах хугацаагаар тодорхойлсон элэгдлийг хасч, чанар байдлын илтгэлцүүрээр зохицуулалт хийж, өнөөгийн өртгийн үнэлгээг гаргасан.

3.Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хувийг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ"-г баримтлахын зэрэгцээ, дээрх баримт бичгүүдэд заагдаагүй эд хөрөнгийн элэгдлийн хувийг ижил төстэй ойролцоо хөрөнгийн элэгдлээр буюу эсвэл үнэлгээчид өөрсдөө экспертийн аргаар тооцоолсон болно.

4.Хуримтлагдсан элэгдлийг дараах байдлаар тогтоов. Эхлээд ашиглагдсан хугацаа (жил)-г элэгдлийн хувиар үржүүлж хуримтлагдсан элэгдлийн нийт илтгэлцүүрийг процентоор гаргасан. Дараа нь бүрэн орлуулалтын өртгийг хуримтлагдсан элэгдлийн нийт илтгэлцүүрээр үржүүлж хуримтлагдсан элэгдлийн хэмжээг гаргасан.

5.Бүрэн орлуулалтын өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасч үлдэгдэл өртгийг гаргасан.

6.Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн мөртлөө одоо ашиглалтанд байгаа эд хөрөнгийн хувьд цаашид ашиглагдах хугацааг салбарын мэргэжлийн экспертүүдийн туслалцаатайгаар үнэлгээчид тогтоож, энэ үлдсэн ашиглагдах хугацаанд харгалзах үлдэгдэл өртгийг бүрэн орлуулалтын өртгөөс нь үндэслэж тогтоосон.

7.Бүрэн орлуулалтын өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасч тооцсон үлдэгдэл өртгийг шинжилж үзээд үлдэгдэл өртөгт чанар байдлыг нь харгалзан шаардлагатай бол зохих илтгэлцүүрээр тохируулга хийж өнөөгийн өртгийг гаргасан.

Одоо ашиглаж байгаа дансны тэг үнэтэй хөрөнгийн цаашид ашиглах хугацааг 3 жилээр тооцон үнэлсэн болно.





2014 07 04

190
СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"Бидисек" ХК-ийн тээврийн хэрэгсэл, компьютер, тавилга эд хогшил, бусад хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг өртөг, харьцуулалтын аргаар тооцоход:

- Тээврийн хэрэгсэл **335,404.0 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 4-р хавсралтанд харуулав.)
- Компьютер **35,086.4 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 5-р хавсралтанд харуулав.)
- Тавилга эд хогшил **40,873.8 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 6-р хавсралтанд харуулав.)
- Тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө, бусад хөрөнгө **72,036.6 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 7-р хавсралтанд харуулав.)
- "БиДиСиЭйПи" ХХК-ийн компьютер, тавилга эд хогшил **28,146.5 мянган төгрөг** (дэлгэрэнгүй тооцооллыг 8-р хавсралтанд харуулав.)

***<u>Үнэлгээний эцэслэсэн дүн:</u>***

"Бидисек" ХК-ийн дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг -барилга байгууламжийг зах зээлийн харьцуулалтын аргад; -бусад үндсэн хөрөнгийг өртгийн аргын тооцоололд тус бүр 100%-ийн бүрэн ач холбогдол өгч, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцвол:

- Барилга байгууламж, газар эзэмших эрхийн үнэ цэнэ **9,501,600.0 мянган төгрөг;**
- Тээврийн хэрэгслийн үнэ цэнэ **335,404.0 мянган төгрөг;**
- Компьютерийн үнэ цэнэ **35,086.4 мянган төгрөг;**
- Тавилга эд хогшлийн үнэ цэнэ **40,873.8 мянган төгрөг;**
- Тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө, бусад хөрөнгийн үнэ цэнэ **72,036.6 мянган төгрөг;**
- "БиДиСиЭйПи" ХХК-ийн компьютер, тавилга эд хогшилийн үнэ цэнэ **28,146.5 мянган төгрөг;**

**Бүгд үндсэн хөрөнгийн үнэ цэнэ 10,013,147.2 мянган төгрөг** болов

***<u>Үндэслэл ба хязгаарлах нөхцөл:</u>***

Үнэлгээг дараахь үндэслэл ба хязгаарлах нөхцөлд үндэслэн гүйцэтгэв. Үүнд:

Энэ үнэлгээний шинжилгээг бид "БиДиСек" ХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-нээрх үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үндэслэсэн.

Энэ тайланд орсон мэдээлэл, прогноз, санал дүгнэлт нь найдвартай гэж тооцогдох эх үүсвэрт үндэслэсэн ба эх үүсвэрийн талаар бид хариуцлага хүлээхгүй болно.



2014 07 04

191

СЭХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Компанийн удирдлагаас гаргаж өгсөн мэдээлэл нь үнэн зөв болохыг бид хүлээн зөвшөөрч, өөрийн зүгээс нягтлан шалгаагүй болно.

Энэхүү тайлан буюу түүний хуулбар тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэвлэн нийтлэх эрх олгохгүй бөгөөд уг тайланг бидний үйлчлүүлэгчээс өөр аливаа этгээд үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр аваагүй нөхцөлд бусад зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү тайланд тусгасан өртгийн аливаа тооцоонууд зөвхөн энэ үнэлгээнд хамаарагдаж, түүний салшгүй хэсэг байхын зэрэгцээ тэдгээрийг тайлангийн зорилго, агуулгаас гадуур ашиглаж үл болно. Үнэлгээ нь зөвхөн энэхүү тайланд тодорхойлсон зорилгуудын хувьд хүчин төгөлдөр болно.

Үнэлгээнд хамрагдаж буй "Бидисек" ХК нь цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлж, бизнесийн өнөөгийн чиглэл, шинж чанараа хэвээр хадгална гэсэн үндэслэлийг энэ үнэлгээнд ашиглав.

Тайланд үнэлгээ хийсэн огноонд хүчин төгөлдөр байсан баримт, нөхцөл байдлыг шалган судлав. Үнэлгээний тайланг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хийсэн тул дээр тооцоолсон өртөг нь мөн өдөрт хамаарна. Энэ өдрөөс хойш бий болсон улс төр, эдийн засаг, хууль тогтоомж, хөрөнгийн биет элэгдлийн дунд болон өртөгт нөлөөлөх аливаа өөрчлөлтийн талаар гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй.

Захиалагчаас үнэлгээний тайланг ашиглан бусадтай хийсэн хэлцлээс захиалагч болоод түүний түншид учирч болох аливаа хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй, олох ашгийг хуваалцахгүй болно. Захиалагч болоод түүний түншүүд хэлцэл хийхдээ өөр өөрсдийн зүгээс хөрөнгийн байдал, өмчлөх эрх, өртгийг нарийвчлан хянаж, эрсдэлээс зайлсхийх нөхцөлийг судлах үүрэгтэйг тэмдэглэж байна. Хөрөнгө нь үнэлгээчний тогтоосон эл өртгөөр зах зээл дээр борлогдоно гэж хатуу ойлгож болохгүй. Мөн түүнчлэн хөрөнгийг богино хугацаанд яаралтай борлуулах, албадан худалдах, татан буулгах нөхцлийг тусгаагүй болно.

Үнэлгээний тайлан нь тухайн хөрөнгийн зуун хувийн өртгийг үндэслэх үнэлгээчийн мэргэшлийн санал дүгнэлтийг агуулж байгаа болно.

Үүнийг үнэлгэч нь тус эд хөрөнгийн ба ирээдүйд хувийн сонирхолгүй бөгөөд худалдан авах, худалдах, бусдад зуучлах зэрэг ажилд оролцохгүй болно.

Тайланд хавсаргасан үнэлгээ тооцооны болон бусад хавсралт нь түүний салшгүй хэсэг болно. Энэ тайлан нь 30 хуудас бүхий 9 хавсралттай, түүний дотор 21 ширхэг гэрэл зурагтай болно.

192

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Дахин үнэлгээний ажлын удирдагч:**

**Ерөнхий захирал** **Ц. Жигдэн**

**Дахин үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн:**

**Мэргэшсэн үнэлгээчин, зөвлөх инженер** **Р.Бүүвэйбаатар**

**Мэргэшсэн үнэлгээчин, төсөвчин инженер** **З.Сарантуяа**

**Үнэлгээний тайлантай танилцсан:**

**"Бидисек" ХК-ийн**
**Тэргүүн дэд захирал** **Б.Лхагвадорж**

**Ерөнхий ня-бо** **М.Цагаанцэцэг**

Mongolia Ulaanbaatar

*Tel: 99006277. 305405* *Э-шуудан: info@dalaivanaudit.mn; buuvei_r@yahoo.com*

СЗХ
2014 он 07 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Үнэт цаас гаргагчтай холбоо барих

Б.Лхагвадорж
Тэргүүн дэд захирал
И-мэйл: lkh@bdsec.mn

Ш.Шинэбаяр
Хөрөнгө оруулалтын албаны менежер
И-мэйл: shinee@bdsec.mn

Ц.Цог
Харилцагчийн албаны менежер
И-мэйл: tsog@bdsec.mn

Хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Залуучуудын өргөн чөлөө,
8-р хороо, 27/1
“БиДиСЕК” ХК-ийн байр
Утас: 976-11-313108
Факс: 976-11-323411
Цахим хуудас: www.bdsec.mn
: www.facebook.com/BDSecJSC
: www.twitter.com/BDSecJSC



2014 07 04